

АЛХИМИЧ

Пауло Коело

Зохиогчийн үг:

АРВАН ЖИЛ ӨНГӨРЧЭЭ

Америкийн хэвлэлийн компани Харпер Коллинзоос “Алхимичийг унших нь үүрээр эртлэн босоод бусдыг унтан байх зуур нар мандахыг харахтай адил” хэмээсэн захиа авснаа миний бие эргэн дурсдаг. Би гадагшаа гараад тэнгэр рүү ширтэн өөртөө “За тэгэхээр энэ ном минь англиар хэвлэгдэх нь дээ” гэж бодлоо. Тэр үед би зохиолч болохын тулд чармайн, ямар ч боломжгүй зүйл гэж бүгд хэлж байсан ч өөрийн замаа дагахаар тэмцэж байлаа.

Тэгээд бага багаар миний мөрөөдөл биелж эхэлсэн юм. Арав, зуу, мянга, сая хувь Америкт зарагдлаа. Нэг өдөр ерөнхийлөгч Билл Клинтон уг номыг уншин зургаа авахуулсныг хэлэхээр нэгэн Бразил сэтгүүлч над руу утасдаж билээ. Түүнээс хэсэг хугацааны дараа Туркт байхдаа ‘Vanity Fair’ сэтгүүлийг нээтэл Жулиа Робертс уг номыг маш их үнэлдэгээ хэлсэн байв. Маяамигийн гудамжаар ганцаараа алхаж явтал нэгэн охин ээждээ “Та Алхимичийг заавал унших ёстой!” гэж хэлэхийг ч мөн сонсож байсан юм.

Энэхүү ном маань тавин зургаан хэлээр орчуулагдаж хорин сая гаруй хувь зарагдсан бөгөөд хүмүүс надаас “Энэхүү асар их амжилтын нууц нь юу вэ?” гэж асууж эхэлцгээсэн.

Миний цор ганц үнэн хариулт бол: Би мэдэхгүй.

Миний мэдэж буй зүйл гэвэл бид бүгдээрээ хоньчин хүү Сантьяго шиг өөрсдийн дотоод тэмүүлээ анзаарч байх хэрэгтэй. Тэгвэл хүний дотоод тэмүүлэл гэж юу юм бэ? Энэ бол Бурханы адислал, энэ бол Бурханы энэ дэлхий дээр чамд сонгосон зам. Бид өөрсдийгөө урам зоригоор дүүргэх зүйлсийг хийж байх үедээ өөрсдийнхөө бахархалаар замнаж байдаг. Гэсэн хэдий ч бидний бүгдэд нь өөрийнхөө хүсэл мөрөөдлөөр амьдрах зориг байдаггүй.

Яагаад?

Үүнд дөрвөн саад байдаг. Эхнийх нь: бид хүүхэд байхаасаа эхлэн бидний хийхийг хүсдэг юм бүхэн боломжгүй зүйл хэмээн хэлүүлсээр өссөн байдаг. Бид энэ үзэлтэй хамт өсч томрон, он жилүүд улирах тутамд айдас, буруутгах үзэл болон гэмшлийн давхаргууд адилхан зузаардаг. Тэгээд нэгэн цагт бидний дотоод тэмүүлэл маань бидний сүнс сүлдний дэндүү гүнзгийд булагдаж үл үзэгдэгч мэт болдог. Гэхдээ тэр оршсоор л байдаг.

Хэрвээ бид хүсэл мөрөөдлөө илрүүлэн гаргах зориг тэвчээртэй байж чадвал удаах саадтай учирдаг: тэр нь хайр юм. Бид өөрсдийн юу хийхийг хүсч байгаагаа мэдэж байвч өөрийн хүсэл мөрөөдлөөр замнахын тулд бүхнийг орхиж өөрсдийн эргэн тойронд байгаа хүмүүсээ шархлуулахаас эмээдэг. Бид хайр бол нэмэлт хөдөлгөгч хүч болохоос биднийг урагш тэмүүлэхээс саатуулдаг зүйл огтхон ч биш гэдгийг ухаардаггүй. Бид өөрсдөдөө үнэн сэтгэлээсээ сайн сайхныг хүсдэг, жаргалтай байлгахыг хүсдэг хүмүүс маань тэрхүү аялалд хамтдаа явахаар бэлтгэгддэг гэдгийг ухаардаггүй.

Нэгэнтээ хайр гэдэг бол хүч нэмэгдүүлэгч гэдгийг хүлээн зөвшөөрсний дараагаар бид гурав дахь саад болох замд тааралдах ялагдлуудаас айх айдастай тулгардаг. Зорьсон зүйлс бүтэлгүй байх үед мөрөөдлийнхөө төлөө

тэмцэгчид бид бусдаас хавьгүй илүү шаналдаг, яагаад вэ гэвэл бид хуучны цагаатгал болох “За яах вэ, би ямар үүнийг тэгтлээ их хүссэн ч биш дээ.” хэмээгээд орхиж чадахгүй. Бид үүнийг хүссэн тэгээд үүний төлөө байгаа бүхнээрээ дэнчин тавьсан гэдгээ мэдэж байвч өөрийн тэмүүллийн зам маань зөвхөн бидний зүрх сэтгэл л энэ аялалд хамт байдгаас, өөр бусад замуудаас огтхон ч хялбар биш юм. Тэгэхээр гэрлийн дайчид бид хүнд үеүдэд тэсвэрлэх тэвчээрээр бэлтгэгдэх ёстой ба хэдий хэрхэн яаж гэдгийг нь ойлгохгүй ч бүх л ертөнц бидэнд туслаж байдаг гэдгийг санаж байх шаардлагатай.

Би өөрөөсөө дараах зүйлийг асуудаг: Ялагдлууд зайлшгүй гэж үү?

Зайлшгүй ч бай, үгүй ч бай тэд ер нь тохиолддог. Бид өөрсдийнхөө мөрөөдлийн төлөө тэмцэж эхлэхдээ туршлагагүйн учраас маш их алдаа гаргадаг. Гэхдээ амьдралын нууц нь гэвэл долоо дордож найм сэхэхэд шүү дээ. Тэгэхээр, хэрвээ бид зөвхөн бусдаас илүүтэйгээр зовох болдог юм бол өөрсдийн дотоод тэмүүллийн дагуу амьдрах нь үнэхээр тийм чухал гэж үү?

Яагаад вэ гэвэл бид бэрхшээлүүдийг давж чадвал – угаасаа бид үргэлж ялдаг – маш их хэмжээний сэтгэл ханамж болон итгэлээр дүүрдэг. Өөрсдийгөө амьдралын гайхамшигаар үнэлэгдэнэ гэдгээ баталж байгаагаа зүрхний гүндээ мэдэрдэг. Өдөр бүр, цаг бүхэн сайн үйлийн төлөөх тэмцлийн хэсэг болно. Бид оргилуун сэтгэлээр, ая тухтайгаар амьдарч эхлэнэ. Цочмог хүчтэй, гэнэтийн шаналалууд тэвчиж болохоор мэт шаналалуудаас илүү хурдан сарниж алга болдог. Анхандаа тэвчиж болох мэт шаналалууд бидэнд ажиглагдалгүйгээр он удаан жил үргэлжилж бидний сүнс сүлдийг идсээр байх бөгөөд нэг л өдөр бид тэрхүү гунигт байдлаас өөрсдийгөө чөлөөлөх чадалгүй болон үлдсэн бүхий л амьдралаа зовлон шаналалтайгаа хамт өнгөрөөдөг.

Хүсэл мөрөөдлөө илрүүлэн таниж, хайрын хүчээр түүнийгээ тэтгэн, он удаан жилүүдийг ширүүн тэмцэн өнгөрүүлсний эцэст бид цаг үргэлж хүсч мөрөөдөж байсан зүйл маань хажууханд магадгүй маргааш ч тохиолдохоор ойрхон байгааг гэнэтхэн анзаардаг. Энэ үед дөрөвдүгээр саад болох бүх насаараа зориж ирсэн хүсэл мөрөөдлөө биелэгдэхээс айх айдастай учирдаг.

Оскар Вилде хэлэхдээ: “Хүн бүр хайртай зүйлээ устгадаг.” гэсэн бөгөөд энэ үг үнэн билээ. Өөрийн хүсдэг зүйлдээ хүрэх өчүүхэн боломж маань хүний сэтгэлийг гэмшлээр дүүргэдэг. Эргэн тойрондоо байх хүссэн зүйлдээ хүрч чадаагүй хүмүүсийг хараад бид өөрсдөө ч гэсэн түүндээ хүрэх гавъяагүй хэмээн боддог. Бид даван туулсан бүх саадуудаа, тэсвэрлэсэн бүх шаналалуудаа, энэ хүртэл явахын тулд орхигдуулсан бүх зүйлсийнхээ тухай мартчихдаг. Би өөрсдийн дотоод тэмүүлэл нь гараа сунгахад л хүрчихээр ойрхон байсан үедээ удаа дараа бодлогогүй алдаанууд хийж зорилгодоо хэзээ ч хүрч чадаагүй, зорилгоо ганцхан алхмын цаана байхад нь шантарсан олон хүний тухай мэднэ.

Энэ бол учирч болох саад тотгоруудаас хамгийн аюултай нь яагаад вэ гэхээр үүнд хөөр баясал болон сэтгэлийн эзэмдэлтийг орхисон нэгэн төрлийн ариун төрх оршдог. Гэвч чи өөрийн авахаар шантралгүй тэмцсэн зүйлдээ хүрэх гавъяатай гэдэгтээ итгэж чадвал чи Бурханы илгээсэн зэмсэг болох бөгөөд Дэлхийн сүнсэнд туслаж, энэ хорвоод яагаад төрснөө ухаарах болно.

Пауло Коело
Рио Де Жанейро
2002 оны 11-р сар

Удиртгал

Алхимич жингийн цувааныхны нэгнийх нь авчирсан номыг сугалан авлаа. Номын хуудсуудыг эргүүлэн байх зуураа тэрээр Нарсисисын тухай түүхийг олж харав.

Алхимич Нарсисисийн домгийг мэддэг билээ. Нарсисис хэмээх нэгэн үзэсгэлэнт залуу хүү өөрийгөө нуурын усанд өдөр бүр тольддог байсан бөгөөд тэрээр өөртөө үлэмж ихээр татагдсан учраас нэгэн өглөө нуурын ус руу унаад живчихсэн бөлгөө. Хүүгийн унасан тэр газар нэгэн цэцэг ургасныг нарсисис хэмээн нэрлэдэг болсон билээ.

Гэвч тэр номын зохиогч нь энэ тухай бичиж номоо төгсгөөгүй байлаа.

Тэр бичихдээ Нарсисисийг нас барах үед ойн охин тэнгэрүүд гарч ирээд цэнгэг устай нөгөө нуур өөрийгөө давстай нулимсан нуур болгон хувирган байхтай тааралдсан хэмээжээ.

“Чи яагаад уйлж байгаа юм бэ?” гэж охин тэнгэрүүд нуурнаас асуулаа.

“Би Нарсисисийн төлөө уйлж байна.” гэж нуур хариулав.

“Тиймдээ, чи Нарсисисийн төлөө уйлж байгаад гайхах зүйл алга даа,” гэж охин тэнгэрүүд хэлээд “гэхдээ бид түүнийг ойд байнга даган хөөцөлддөг байхад чи ганцаараа түүний үзэсгэлэнг алган дээрээ мэт хардаг байсан даа.”

“Гэхдээ ... Нарсисис тийм үзэсгэлэнтэй байсан гэж үү?” хэмээн нуур асуулаа.

“Чамаас илүүтэйгээр түүнийг мэдэгч байна гэж үү?” хэмээн охин тэнгэрүүд гайхацгаалаа. “Эцсийн эцэст тэр чиний усанд өөрийгөө харах л гэж өдөр бүр ирдэг байсан юм!”

Нуур хэсэг хугацаагаар чимээгүй боллоо. Тэгснээ нуур хэлсэн нь:

“Би Нарсисисийн төлөө уйлж байна, гэхдээ би Нарсисис үзэсгэлэнтэй байсныг ердөө ч ажиглаж байгаагүй юм байна. Би яагаад уйлж байна вэ гэхээр тэр миний дэргэд суугаад усанд минь өөрийгөө харах бүрт түүний нүдний харцны гүнд туссан миний үзэсгэлэн надад харагддаг байсан юм даа.”

“Юутай уярмаар түүх вэ,” хэмээн алхимич бодлоо.

Тэргүүн бүлэг:

1-р хэсэг

Хүүг Сантьяго гэдэг байв. Үдшийн бүрий тасрах үеэр хүү хонио туусаар нэгэн орхигдсон сүмийн дэргэд ирэв. Сүмийн дээвэр аль эрт нураад гол шүтээн байсан газар нь нэгэн асар том агч мод ургасан харагдана.

Тэр шөнийг тэнд өнгөрөөхөөр шийдлээ. Хүү бүх хонио сүмийн эвдэрхий хаалгаар оруулсан эсэхээ нягтлаад сүргээ шөнө үргэхээс сэргийлж хэсэг банзаар хаалгыг дарав. Энэ мужид чоно байдаггүй боловч урьд нь нэг удаа хээрийн амьтан шөнөөр гүйдэллээд, хүү маргааш нь бүх л өдөржингөө түүнийг хайх болж байсан билээ.

Тэр хүрмээ шалан дээр дэвсээд саяхан уншиж дууссан номоо дэрлэн хэвтэв. Тэгээд тэр зузаан ном уншвал зүгээр юм байна удаан дуусна бас илүү аятайхан дэр болно доо хэмээн бодлоо.

Түүнийг сэрэхэд гэгээ сайн ороогүй байсан бөгөөд хэрвээ жаахан хичээж харах юм бол сүмийн эвдэрхий дээврээр однууд харагдахаар байлаа. Ахиад жаахан унтах байсан юм даа хэмээн тэр бодож амжив. Тэр шөнө хүү өнгөрсөн долоо хоногт зүүдэлсэнтэйгээ яг ижил зүүд зүүдлээд ахиад л түүнийгээ дуусахаас нь өмнө сэрсэн нь тэр байлаа.

Хүү босоод шилбүүрээ аваад нойрмоглон байгаа хонинуудаа сэрээж эхэллээ. Түүнийг босмогц ихэнх хонинууд нь босоод шилгээж эхэлж байгааг хүү гэнэт анзаарав. Магадгүй ямар нэгэн далдын хүч түүнийг сүүлийн хоёр жилийн туршид тэдгээр хонинуудыг хариулан өвс устай бэлчээр хайн амьдрахаар нөлөөлөөд байж ч болох юм. "Энэ хэд минь ч миний занд ингэтлээ дасчихаж дээ" гээд хүү бувтналаа. Ингэж бодох зуураа хүү бас нөгөө талаас тэр өөрөө хонинуудынхаа хэвшилд дассан байж болохоо ч тунгааж бодов.

Гэхдээ тэдний дунд бас арай сэрээгүй байгаа хэсэг ч байлаа. Хүү тэднийг дараалан шилбүүрээрээ ёворч босгоод бүгдийг нь нэрээр нь дуудлаа. Тэр хонинуудаа түүний хэлснийг ойлгох чадвартай гэж үргэлж итгэдэг бөгөөд хүү заримдаа тэдэнд номынхоо онцгой сэтгэгдэл төрүүлсэн хэсгээс уншиж өгөх юмуу эсвэл зэлүүд тал нутаг дахь хоньчин амьдралынхаа жаргал, зовлонгоос тэдэнд яридаг байлаа. Хааяа дайрч гарсан суурингууддаа үзсэн зүйлсээс тэдэнд тайлбарлаж өгнө. Гэхдээ сүүлийн хэдэн өдрийн туршид хүү тэдэнд зөвхөн ганцхан зүйлийн тухай тодруулбал барагцаагаар дөрвөн өдрийн дараа хүрэх сууринд амьдрах нэгэн худалдаачны охины тухай л ярисан болно. Хүү тэр сууринд өнгөрсөн жил очиж байсан бөгөөд мөнөөх худалдаачин барааны дэлгүүртэй бас мэхлүүлэхгүйн тулд хонийг заавал харж байж ноосыг нь хяргуулдаг зантай нэгэн бөлгөө. Түүнд нэг найз нь энэ тухай хэлсэнээр хүү хонио туун тэнд очиж байсан билээ.

-***-

2 - р хэсэг

"Би жаахан ноос зарах гэсэн юм" хэмээн хүү худалдаачнаас асуув. Дэлгүүр хүн ихтэй завгүй байгаа болохоор худалдаачин түүнийг үд болтол хүлээхийг хүссэн бөгөөд хүү дэлгүүрийн өмнөх довжоон дээр суугаад үүргэвчин дэх номоо гарган уншиж хүлээв.

"Хоньчид уншиж чаддаг гэж би ердөө ч бодож байсангүй " гэж нэгэн охины дуу ард гарлаа. Тэр охин Андалуиза нутгийн нийтлэг шинж болох намирсан урт хар үс, тормолзсон хар нүдтэй Мүрийнхний дайчин удмыг санагдуулам нэгэн байв.

"Хэ хэ, ер нь бол би номноос илүү хониноосоо суралцдаг л даа" хэмээн хүү хариулав.

Тэд хоёр цагийн туршид ярилцахад охин түүнд өөрийгөө худалдаачны охин бөгөөд суурингийн амьдралын талаар бүх л өдөр яг ижилхэн байдаг тухай ярих. Хүү түүнд Андалуиза нутгийн хөдөө нутгийн талаар бас замдаа дайрсан газруудынхаа сониноос хуучлав. Энэ нь хонины тухай ярианы сэдвийг өөрчлөх сайхан боломж байлаа.

“Чи яаж уншиж сурсан юм бэ?” гэж охин түүнээс асуув.

“ Хүмүүс яаж сурдаг тэгэж л ,” гэж тэр хэлээд “ Сургуульд” хэмээн нэмлээ.

“Аанхан. Гэхдээ чи уншиж чаддаг юм бол яагаад зүгээр л хонь хариулаад яваад байгаа юм бэ?” Хүү түүний асуултнаас аятайхан бултах нэг хариулт буйтналаа. Учир нь хүү түүнийг хоньчин болохоор шийдсэнийг охин яагаад ч ойлгохгүй гэдэгт итгэлтэй байв. Тэр охинд өөрийнхөө паянгаас үргэлжлүүлэн ярихад охины тунгалаг хар нүд нь заримдаа айдас , заримдаа гайхашаар тормолзон байлаа. Цаг өнгөрөх тусам хүү тэр өдөр хэзээ ч битгий дуусаасай түүний аав нь завгүй л байсаар байгаад гурван өдөр болоосой хэмээн хүсч байв. Тэр өөрөө өмнө нь хэзээ ч бодож байгаагүй мэдрэмж буюу нэг газар суурьшин амьдрах хүсэл төрж байгаагаа анзаарлаа. Энэ сайхан гилгэр хар үстэй охины дэргэд түүний өдрүүд хэзээ ч нэгэн хэвийн байхгүй мэт бодогдоно.

Эцэст нь даанч худалдаачин гарч ирээд хүүг дөрвөн хонь хяргаж өгөхийг хүсэв. Худалдаачин хүүд ноосных нь үнийг төлөөд ирэх жил ахиад ирээрэй хэмээжээ.

-***-

3 - р хэсэг

Одоо ердөө дөрөвхөн өдрийн дараа хүү нөгөө сууринд ахиад очих болох нь. Тэр догдлож байсан ч сэтгэл нь бас түгшүүртэй байлаа. Магадгүй тэр охин, түүнийг аль хэдийн мартчихсан ч байж болох шүү дээ. Зөндөө олон хоньчид ноос зарахаар очсон байж таараа.

“За тэр ямар хамаатай юм бэ,” хэмээн хүү хонинууддаа хэллээ. “Би энд тэндхийн зөндөө л олон охидууд танина.” Гэвч хамаатай байна шүү гэдгийг зүрхэн дотроо хүү мэдэрч байлаа. Түүнчлэн тэр хоньчид ч гэсэн далайчид болон явуулын худалдаачдын адилаар хаа нэгтээ сууринд эрх дураараа хэсүүчлэн амьдрахын жаргалыг нь мартуулсан хэн нэгэнтэй үргэлж учирдаг гэдгийг мэдэж байлаа.

Үүр цайж эхэлсэн бөгөөд хүү хонио нар угтуулахаар шавдууллаа. Тэд ердөөсөө ч шийдвэр гаргах шаардлагагүй юм хэмээн хүү бодов. Магадгүй тиймдээ ч тэд үргэлж миний дэргэд байдаг байх.

Хонинуудад хэрэгцээтэй зүйлс нь ердөө идэх өвс, уух ус л юмаа. Ер нь хүү Андалуизад хамгийн сайн бэлчээр хаана байгааг мэдэж байгаа цагт тэд түүний нөхөд хэвээрээ л байх болно. Тиймдээ, тэд өдөр бүрийг, өдөр болгон нар мандахаас жаргах хүртэлх барагдахгүй урт мэт хугацааг дандаа л ижилхэн өнгөрүүлнэ. Хэзээ ч тэд жаахан байхдаа ном уншиж байгаагүй хүү тэдэнд хотуудын сайхнаас ярьж өгөхөд ойлгоочгүй. Тэд зөвхөн өвс тэжээл болон усыг л чухалчилна тэгээд хариуд нь ноосоо харамгүй өгнө, замын сайн хань болно эцэст нь нэг удаа өөрсдийн махаа өгнө. Хэрвээ өнөөдөр би мангас байсан байгаад тэднийг нэг нэгээр нь цувуулан төхөөрч эхэлвэл тэд сүргийн ихэнхи нь

нядлагдсаны дараа л сэхээрч эхлэх байхдаа хэмээн хүү бодлоо. Тэд надад итгэдэг, тэд өөрсдийнхөө зөн билэгтээ итгэхээ мартчихсан яагаад вэ гэвэл би л өвс устай бэлчээр олж тэднийг хариулдаг.

Хүү өөрийнхөө бодолд гайхаж байв. Магадгүй тэр дотор нь агч мод ургасан сүм гүйдэлтэй юм болов уу. Түүнээс болоод хүү яг ижил зүүд хоёр дахь удаагаа давтаж зүүдлээд бас өөрийнхөө үнэнч нөхдийн эсрэг таагүй зүйл бодоод байгаа бололтой. Хүү өчигдөр оройн хоолны даруулганаас үлдсэн дарснаас жаахныг балгаад хүрмээ биендээ улам ойртууллаа. Хэдхэн цагийн дараа нар хурцаар шарж тэр хонио бэлчээж чадахааргүй болтол халуун болно гэдгийг хүү мэдэж байв. Энэ бол бүх Испани даяараа зуны улиралд налайдаг үе байлаа. Халуун бүрий болтол үргэлжилж тэр болтол хүү хүрмээ үүрч явах болно. Хүнд хүрэм үүрч явахын тээртэйг төвөгшөөн бодовч, хүрэмнийхээ хүчээр үүрийн сэрүүнийг давдагаа хүү бас саналаа.

Бид өөрчлөлтөнд бэлтгэгдэх шаардлагатай юмдаа гэж тэр бодох зуураа хүрэмнийхээ хүнд жин болон дулаан илчинд нь олзуурхаж байлаа.

Хүрмэнд зориулалт байна хүүд ч бас зорилго бий. Түүний зорилго нь аялаж явах бөгөөд Андалуиза нутгаар хоёр жил хэрэн явахдаа хүү энэ мужийн бүх л хот, суурингуудыг үзэж амжсан болой. Тэр энэ удаагийн уулзалтан дээрээ жирийн нэг хоньчин хэрхэн уншиж сурсаныг охинд тайлбарлаж өгнө хэмээн төлөвлөж байлаа. Учир нь юу вэ гэвэл хүү арван зургаа хүртлээ сүмд сурсан билээ. Хүүгийн эцэг, эх нь түүнийг номтой лам болгохыг хүсдэг байсан бөгөөд хөдөөгийн ядуу тэдний хувьд энэ нь том бахархал болох байлаа. Аав, ээж хоёр нь, дөнгөж идэх хоол, уух ундаа залгуулахын тулд борви бохисхийлгүй ажиллаж яг л хонинуудын адилаар амьдарна. Хүү сүмд латин болон испани хэл, шашны номлол үздэг байв. Гэвч тэр хүүхэд байхаасаа эхлэн эх дэлхийгээ таниж мэдэхийг үргэлж хүсдэг байсан бөгөөд энэ нь түүний хувьд Бурханыг шүтэх болон хүний нүглийг судлахаас хавьгүй илүү чухал байсан юм. Нэг өдөр, гэртээ амралтаараа ирээд байх үедээ хүү лам болохыг хүсэхгүй байгаагаа болон аялаж явахыг мөрөөддөг гэдгээ аавдаа хэлж зүрхэлсэн билээ.

-***-

4 - р хэсэг

“Газар газрын хүмүүс энэ сууринг дайрч өнгөрдөг юм, хүү минь” хэмээн аав нь хэлээд “Тэд шинэ зүйлсийн эрэлд ирцгээдэг боловч буцахдаа ирж байснаасаа үндсэндээ ялгаагүй л хүмүүс буцацгаадаг. Тэд шилтгээн үзэхийн тулд уул руу мацна, гэхдээ л тэд өнгөрсөн үе нь одоо байгаагаасаа илүү дээр байжээ хэмээн эцэст нь дүгнэдэг. Тэд шаргал үстэй эсвэл хар арьстай байлаа ч үнэн хэрэгтээ энд амьдардаг хүмүүс шиг л хүмүүс байдаг юм даа.”

“Гэхдээ би тэдний амьдардаг хотуудын цайзуудаас үзмээр байна шүү дээ” гэж хүү тайлбарлалаа.

“Тэдгээр хүмүүс манай нутгийг харчихаад энд бүрмөсөн суурьшиж амьдрамаар сайхан нутаг байна гэдэг” гэж аав нь үргэлжлүүлээ.

“Тэгвэл, Би ч гэсэн тэдний нутгийг харж тэд яаж амьдарч байгааг үзмээр байна,” гэж хүү хэллээ.

“Энд аялж ирцгээдэг тэдгээр хүмүүс мөнгөтэй чинээлэг хүмүүс байдаг тиймдээ ч тэд жуулчилцгаадаг харин бидний дунд аялж чадах хүмүүс гэвэл зөвхөн хоньчид л байх шив дээ.”

“Тэгвэл би хоньчин больё!”

Аав нь ахиад өөр юм хэлсэнгүй. Маргааш нь аав нь түүнд гурван ширхэг хуучны Испани алтан зоос бүхий жижиг уут өгөөд “Би үүнийг өмнө нь талбайгаас олсон юм. Энэ зооснуудыг чиний өвлөх хөрөнгөний нэг хэсэг болгоё гэж бодож байлаа. Гэхдээ чи үүнийг өөртөө сүрэг худалдаж авахдаа хэрэглэ. Талд гарч амьдар, тэгээд чи нэг өдөр манай нутаг хамгийн сайхан нь, манай бүсгүйчүүд хамгийн үзэсгэлэнтэй нь гэдгийг ойлгох болно.” Тэгээд тэр хүүгээ адислав.

Хүү тэгэхэд аавынхаа харцнаас, дэлхийгээр аялах хүсэл, хэдийгээр аав нь өнгөрсөн олон жилийн туршид уух унд, идэх хоол, үргэлж нэг газраа унтах хувь заяаныхаа дарамтан доор үл харгалзан булшилсан ч унтраагүй амьд байгаа тэр нэгэн хүслийн очыг олж харсан билээ.

5 - р хэсэг

Тэнгэрийн хаяа улайрч эхэлснээ гэнэт нар мандлаа. Хүү аавтайгаа ярьж байснаа дурсаад сэтгэл нь сайхан болов. Тэр аль хэдийн зөндөө цайзуудаар аялчихсан зөндөө охидуудтай танилцчихсан (гэвч тэдний аль нь ч одоо түүнийг хэдэн өдрийн зайтай хүлээж буй охиныг гүйцэхгүй). Түүнд хүрэм, өөр номоор солиж уншдаг нэг ном, бас сүрэг хонь байгаа. Гэвч хамгийн чухал нь, тэр өдөр бүр өөрийнхөө мөрөөдлөөр амьдрах боломжтой юм. Хэрвээ тэр Андалуизагийн тал нутгаас уйдвал хонио зарчихаад далай руу явж болно. Далайгаар аялаад ханах үедээ тэр бас л зөндөө олон хотууд, хүүхнүүд болон бусад жаргалтай байх зүйлстэй учирсан байх болно. Би ч Бурхантай уулзаж чадахгүй л байсан болов уу сүмдээ сууж байсан бол хэмээн хүү нар мандахыг ажиглах зуураа бодлоо.

Хэзээ л бол хэзээ тэр аялах шинэ зам олж чадна. Хүү энэ хавиар зөндөө аялсан боловч өмнө нь ерөөсөө тэр нурсан сүмд очиж байгаагүй. Дэлхий үнэхээр том бас агуу юм шиг. Хонинуудаа хэсэг өөрсдийнх нь дураар билчээхэд л тэр шинэ сонирхолтой зүйлс нээж чадна. Асуудлын гол нь юунд байна гэхээр хонинууд нь өдөр бүр шинэ замаар явж байгаа гэдгээ ухаардаггүйд байх юм. Тэд талд шинээр өвс ургамал ургаж байгааг улирлууд ээлжлэн солигдож байгааг ч анзаарахгүй. Тэдний боддог зүйл нь өвс, ус хоёр л юм даа.

Магадгүй бид бүгдээрээ ч тийм юмуу даа хэмээн хүү бодлогошров. Би ч гэсэн л худалдаачны охинтой танилцсанаасаа хойш өөр охидуудын талаар бодохоо болисон шүү дээ. Тэр нар руу харангаа Тарифад үдийн өмнө очих юм байна хэмээн багцаалав. Тэнд хүү номоо арай зузаан номоор солино, саваа дарсаар дүүргэнэ, сахлаа хусч, үсээ засуулна. Тэр охинтой уулзах уулзалтандаа өөрийгөө бэлтгэх хэрэгтэй, бас тэр өөрөөс нь олон хоньтой хоньчид түүнээс өрсөж очоод охиныг гуйх боломжийн талаар бодохыг ч хүсэхгүй байлаа. Мөрөөдлөө биелүүлэх боломж нь амьдралыг сонирхолтой болгох юмаа гэж тэр бодох зуураа нар руу ахин нэг хараад алхаагаа түргэсгэв. Хүү Тарифад зүүдний тайлал хэлдэг настай авгай байдгийг гэнэт саналаа.

6 - р хэсэг

Настай авгай хүүг байшингийнхаа арын өрөөнд дагуулан орлоо. Энэ өрөө нь том өрөөнөөсөө өнгийн жижиг сондоруудыг хэлхсэн хөшгөөр тусгаарлагдах бөгөөд өрөөний голд нэг ширээ, хоёр сандал болон хананд нь Есүс Христийн зураг байрлуулсан байв.

Авгай суунгаа хүүг бас суу хэмээн дохив. Тэгээд тэр хүүгийн хоёр гарыг бариад чимээгүйхэн залбирч эхлэв. Энэ нь цыгануудын уншлагатай төстэй сонсогдож байлаа. Хүүг замд аялж явахад цыганууд тааралдаж байсан бөгөөд тэд бас аялан явцгаадаг ч хонь хариулдаггүй билээ. Хүмүүс ярихдаа цыганууд бусдыг мэхлэж амьдардаг бас тэд нар чөтгөртэй холбоотой түүнчлэн жаахан хүүхдүүдийг хулгайлж өөрсдийнхөө этгээд оромжиндоо аваачаад боол болгодог гэгцгээдэг байв. Хүү жаахан байхдаа цыганууд түүнийг хулгайлж аваад явчих вий гэхээс маш их айдаг байсан бөгөөд тэрхүү багын айдас нь настай авгай түүний гарыг барих үед ахиад мэдрэгдлээ.

Гэхдээ Есүсийн зураг байгаа юм чинь зүгээр байлгүй дээ хэмээн хүү бодонгоо тайван байхыг хичээж аман дотроо чимээгүйхэн тарни уншлаа. Тэр өөрийнхөө гарыг чичрүүлж настай авгайд эвгүйцэж байгаагаа мэдэгдэхийг хүсэхгүй байв.

“Яасан сонин юм бэ” хэмээн настай авгай хүүгийн гарыг ширтэн ажиглах зуураа хэлээд хэсэг чимээгүй болов. Хүү улам тэвдэж гар нь мэдэгдэхүйц чичирч эхлэхэд настай авгайд тэр нь мэдрэгдэв. Хүү гараа хурдхан гэгч нь татаж авлаа.

“Би танд гарынхаа алгыг уншуулах гэж ирээгүй ээ” гэж тэр хэлэхдээ хэрэггүй ч энд ирэв үү хэмээн дотроо харамсаж байлаа. Хүү ерөөсөө төлбөрийг нь төлөөд цааш нь юм асуулгүйгээр явдаг ч юм бил үү ер нь энэ зүүдний тайлал хэрэгтэй ч юмуу даа гэж бодож суув.

“Чи энд өөрийнхөө зүүдний талаар асуухаар ирсэн юм байна” гэж настай авгай хэллээ.

“Зүүд бол Бурхны хэл. Хэрвээ тэр бидний хэлээр яривал би түүнийг тайлж орчуулж чадна. Хэрвээ тэр сүнслэг хэлээр яривал зөвхөн чи л түүнийг ойлгож чадна. Гэвч аль ч тохиолдолд би чамаас зөвлөснийхөө хөлсийг авах болно.”

Хмм, Ээлжит заль, хэмээн хүү дотроо бодлоо. Гэвч тэр азаа туршихаар шийдэв. Хоньчид үргэлж л чоно болон ган гачгийн эсрэг азаа үзэж байдаг тэр нь ч тэдний амьдралыг сонирхолтой болгодог билээ.

“Би хоёр удаа адилхан зүүд зүүдлэсэн юм,” гэж хүү хэллээ. “Миний зүүдэнд би хоньтойгоо талд явж байтал нэг жаахан охин гэнэт гарч ирээд тэдэнтэй тоглож эхлэх юм. Хүмүүс ингэхэд би дургүй, учир нь хонинууд танихгүй хүнээс үргээд байдаг. Гэвч хүүхдүүд хонинуудыг үргээлгүй тоглож чаддаг мэт санагддаг. Амьтад хүний насыг яаж ялгаж танидагийг би мэдэхгүй юм.”

“Цааш нь үргэлжлүүлээд ярь,” гэж настай авгай хэллээ. “Би одоо хоолоо хийх ёстой чамд их мөнгө байхгүйгээс хойш би чамд тэгэж их цаг гаргаж чадахгүй.”

“Тэр охин хонинуудтай нэлээд удаан тоглолоо,” гэж хүү хэлэнгээ жаахан гунигт автав. “Тэгээд гэнэт тэр охин намайг гарнаас минь атгаж нисээд Египетийн

пирамидийн дэргэд аваачлаа.” Хүү хэсэг ярихаа зогсоож настай авгайг Египетийн пирамидуудын талаар мэдэж байгаа эсэхийг ажиглалаа. Гэвч тэр юм хэлсэнгүй.

“Тэгээд, Египетийн Пирамидуудын дэргэд,” – хэмээн тэр сүүлийн гурван үгийг авгайд ойлгуулахын тулд удаанаар хэлээд – “тэр охин надад ‘Хэрвээ та энд ирэх юм бол нуугдсан эрдэнэсийг олох болно.’ гэж хэлсэн. Эрдэнэс яг хаана байгаа газрыг охин надад хариугүй үзүүлэх үед би сэрчихсэн, хоёр удаад хоёуланд нь.”

Настай авгай хэсэг чимээгүй суулаа. Тэгснээ тэр хүүгийн гарыг ахин анхааралтайгаар үзэж эхлэв.

“Би чамаас одоо төлбөр авахаа болилоо, гэхдээ хэрвээ чи эрдэнэсийг олвол түүний аравны нэг хувийг авая.” гэж авгай хэллээ.

Хүүгийн инээд гэнэт хүрэв. Тэр нуугдсан эрдэнэсийн талаар зүүдэлсэнээрээ өөртөө байгаа жаахан мөнгөнөөсөө хэмнэх боломжтой болох нь.

“За за, тэгвэл энэ зүүдийг тайлдаа,” гэж хүү хэллээ.

“Юуны өмнө надад ам өг. Миний хэлэх зүйлийн оронд олох баялгийнхаа арав хуваасны нэг хувийг өгнө гэж амла.”

Хүү тэгнэ хэмээн амаллаа. Настай авгай түүнийг Есүс Христийн зургийн өмнө ахиад амла хэмээн хүслээ.

“Энэ бол ертөнцийн хэлээрх зүүд. Би үүнийг тайлж чадна, гэхдээ тайлал нь маш хэцүү юм байна. Тийм ч учраас би чиний олох зүйлсээс хувь хүртэх эрхтэй гэж бодож байна. “Миний хэлэх тайлал гэвэл: Чи Египетийн Пирамидууд руу заавал оч. Би тэдний талаар өмнө нь сонсож байгаагүй ч хэрвээ тэр жаахан охин чамд харуулсан бол тэд байдаг гэсэн үг. Тэндээс чи чамайг маш баян болгох эрдэнэс олох болно.”

Хүү гэнэт догдлосон ч бас эгдүү нь хүрэв. Үүнийг сонсох байсан юм бол энэ авгай дээр ирэх хэрэг байсан гэж үү. Гэвч тэр төлбөр төлөх шаардлагагүй гэдгээ саналаа.

“Би ердөө үүний төлөө цагаа үрэх хэрэггүй л байсан шүү дээ,” гэж хүү хэллээ.

“Энэ их төвөгтэй зүүд байна гэдгийг би чамд хэлсэн. Ер нь амьдрал дээр энгийн зүйлс л хамгийн тайлагдашгүй зөвхөн ухаант мэргэдүүд л ойлгодог юм шүү дээ. Нэгэнтээ би цэцэн бишээс хойш өөр бусад зүйлс жишээ нь хүний гарын алгыг унших гэх мэтийг л сурах болсон юм.”

“За за, Би тэгвэл Египет рүү яаж очих вэ?”

“Би зөвхөн зүүдний тайлалыг хэлдэг. Түүнийг яаж хэрэгжүүлэхийг би мэдэхгүй. Тиймдээ ч би охидуудынхаа өгсөнийг нь хүргээд л амьдарч байна даа.”

“Хэрвээ би хэзээ ч Египет орохгүй бол яах вэ?”

“Тэгвэл би хувь хүртэхгүй гэсэн үг. Энэ анхны удаа биш ээ.”

Авгай хүүг яв гээд түүнд аль хэдийн зөндөө цаг үрчихсэн байгаагаа хэлэв.

Хүүгийн урам нь хугарч ахиж хэзээ ч зүүдэнд итгэж байхгүй хэмээн шийдлээ. Тэр зөндөө олон зүйлс амжуулах ёстой гэдгээ саналаа. Хүү зах руу очиж идэх юм худалдаж аван, номоо өөр зузаан номоор солиулаад шинээр авсан дарсаа амсаж үзэхээр захын талбайн булан дахь нэгэн вандан сандал дээр тухлан суулаа. Халуун өдөр байсныг ч хэлэх үү сэрүү татуулсан сайхан амттай дарс байлаа. Хонинууд нь хотын хаалганы ойролцоо нэг найзынх нь саравчинд байгаа. Хүү энэ хотод нэлээд олон хүн танидаг. Аялаж явахын нэг тааламжтай нь тэр үргэлж шинэ нөхдүүдтэй болохоос гадна тэдэнтэй үргэлж хамтдаа байх албагүй. Хэрвээ хүн бусадтай өдөр бүхэн хамтдаа байгаад байвал тэд түүний амьдралын нэг хэсэг яваандаа болдогийг хүү сүмд сурч байсан үедээ ойлгосон. Тэгээд тэд тэр хүнийг өөрчлөгдөхийг хүсдэг. Хэрвээ хэн нэгэн бусдын хүсч байгаагаар байхгүй байвал тэд уурлацгаадаг. Хүмүүс бүгдээрээ бусдыг хэрхэн амьдралаа авч явах талаар тов тодорхой бодолтой байдаг мэт боловч харин өөрийнхийгөө болохоор мэддэггүй. Хүү нар арай доошилтол хүлээгээд хонио бэлчээрт гаргая гэж бодлоо. Гурван өдрийн дараа тэр худалдаачны охинтой хамт сууж байхнээ.

Тэр худалдаж авсан номоо уншиж эхлэв. Эхний хуудсанд нэгэн оршуулгын ёслолын тухай бичсэн байлаа. Бас зохиолын баатруудын нэр нь хэлэхэд маш хэцүү нэртэй байлаа. Хэрвээ тэр хэзээ нэгэн цагт ном бичих юм бол нэг удаад зөвхөн нэг хүний тухай л өгүүлнэ учир нь уншигч олон хүний нэр тогтоох гэж зовох хэрэггүй болно хэмээн бодов.

Аажмаар тэр уншиж байгаа зүйлдээ төвлөрч эхлэхэд тэр номонд илүү татагдаж эхлэв, оршуулга нэгэн цас бударсан өдөр болж байсан бөгөөд тэр сэрүү татах мэдрэмжийг таалан бодов. Хүү үргэлжлүүлэн уншиж байх зуур нэгэн настай хүн түүний хажууд ирж сууснаа түүнтэй яриа өдөж эхлэв.

“Тэр хүмүүс юу хийгээд байгаа юм бэ” гэж тэр хүн асуунгаа талбай дээр байгаа хүмүүс рүү заалаа.

“Ажиллаж байна,” гэж хүү тоомсоргүй хариулснаа номоо амтархан уншиж байгаа хүний дүр эсгэхийг хичээлээ.

Үнэнийг хэлэхэд хүү өөрийгөө худалдаачны охины өмнө хонь хяргаж байгаагаар төсөөлөн бодож байсан бөгөөд ингэснээрээ охин түүнийг бас ч үгүй хэцүү зүйлсийг хийх чадвартай эр хүн гэдгийг харна гэсэн үг. Хүү энэ агшиныг зөндөө олон удаа төсөөлөн бодож байсан бөгөөд тухай бүрд нь хонийг хойноос нь урагшаа хяргах ёстой гэж тайлбарлахад тэр охин ихэд гайхаж догдлох болно. Хүү бас хонь хяргаж суухдаа ярих сонирхолтой түүх, яриануудаас цээжлэж байгаа ба ихэнхийг нь тэр номноос уншсан боловч өөртөө тохиолдсон мэтээр л охинд ярьж өгөх болно. Тэр охин анзаарах ч үгүй, учир нь охин уншиж чадахгүй шүү дээ.

Энэ хооронд нөгөө настай хүн түүнтэй яриа өдсөөр л байв. Өвгөн хэлэхдээ цангаж байна тэгээд ууж байгаа дарснаасаа жаахан балгуулаач гэлээ. Хүү одоо л нэг намайг орхих нь гэж найдан лонхтой дарсаа түүнд өглөө.

Гэвч тэр хүн ярилцахыг хүссээр л хүүг ямар ном уншиж байгааг асуулаа. Хүү уцаарлан, бүдүүлэг авирлаж өөр суудалд очиж суумаар санагдсан ч аав нь түүнд ахмад настай хүнийг хүндэлж бай хэмээн сургасан билээ. Тэгмэгцээ хүү дараах хоёр шалтгааны улмаас - нэгдүгээрт тэр номын нэрийг яг юу гэж

хэлэхийг мэдэхгүй, хоёрдугаарт хэрвээ тэр хүн уншиж мэддэггүй бол түүндээ санаа нь зовоод аяндаа өөр сандал дээр очиж суух бизээ хэмээн тооцоолоод номоо тэр хүнд өгч орхив.

“Хмм ...” хэмээн настан номыг ямар нэг этгээд зүйл буй мэтээр эргүүлж тойруулан ажиглангаа хэлээд “Энэ нэлээд чухал ном ч гэсэн үнэн яршигтай”.

Хүү цочирдлоо. Настан уншиж чаддагаар барахгүй энэ номыг аль хэдийн уншчихсан байх нь. Хэрвээ энэ ном настаны хэлсэнээр үнэхээр дэмий ном бол хүү түүнийг өөр номоор солих хугацаа бас байна.

“Энэ ном бараг бусад бүх номонд гардагтай адил зүйлийг өгүүлдэг юм,” хэмээн настан үргэлжлүүлээ.

“Энэ номонд хүмүүс өөрсдийн Хувийн бахархалаа сонгох чадваргүйн тухай өгүүлэх бөгөөд хүн бүхэн хорвоогийн агуу хуурамч чанарт итгэдэг хэмээн төгсдөг юм.”

“Хорвоогийн агуу хуурамч чанар гэж юу юм бэ?” хэмээн хүү үнэхээр гайхширан асуулаа.

“Хүмүүс амьдралынхаа тодорхой үед бидэнд юу тохиолдоод байгааг өөрсдөө удирдах чадвараа алдаж бидний амьдрал зурсан зургийнхаа дагуу явж эхэлдэг. Энэ бол хорвоогийн агуу хуурамч чанар юм.”

“Тэр ч надад хэзээ ч тохиолдож байгаагүй ээ,” гэж хүү хэллээ. “Манайхан намайг лам болгохыг хүсч байсан ч би хоньчин болохоор шийдсэн.”

“Маш сайн байна,” гэж настан хэлээд “Учир нь чи аялахыг үнэхээр их хүсдэг.”

“Миний юу бодож байгааг мэдэх чадвартай байх нь,” хэмээн хүү дотроо бодов.

Настан энэ хооронд номын хуудсуудыг эргүүлэн буцааж өгөх шинж ер нь алгаа. Хүү тэр хүн этгээд байдлаар хувцасласныг ажиглав. Тэр араб шиг харагдах бөгөөд арабууд энэ хавиар зөндөө л тааралдана. Африк тив Тарифагаас хэдхэн цагийн зайтай ердөө завиар нэг нарийхан хоолой гатлахад л орчихно. Арабууд энэ хотод нэлээд их ирдэг бөгөөд худалдаа наймаа хийнэ бас өдөрт хэд хэдэн удаа тэдний этгээд мөргөлөө үйлддэг байв.

“Та хаанаас ирсэн бэ?” хэмээн хүү асуулаа.

“Энд тэндээс.”

“Хэнбэгуай ч гэсэн олон газраас байж чадахгүй шүү дээ,” хэмээн хүү хэллээ. “Би хоньчин, би олон газраар аялсан ч гэсэн ганц л газраас, нэгэн эртний шилтгээний дэргэдэх хотоос гаралтай. Тэнд би төрсөн юм.”

“За хө тэгвэл, чи намайг Салемд төрсөн гэж ойлгож болно.”

Хүү Салем хаана байдгийг мэдэхгүй боловч юм мэддэггүй хүн шиг харагдахаас санаа нь зовоходоо асууж зүрхэлсэнгүй. Хүү зах дээр нааш цааш холхилдох хүмүүсийг хэсэг зуур ажиглан суулаа. Тэд бүгд л завгүй харагдана.

“Салем ямаршуухан бэ?” хэмээн хүү жаахан ч гэсэн зүйл тодруулах санаатай асуулаа.

“Ямар байсан түүн шигээ л байна даа.”

Одоохондоо ямар ч мэдэгдэх зүйл алга. Гэхдээ хүү Салем ямар ч гэсэн Андалуизад байдаггүйг мэдэж байв. Байдаг бол тэр аль хэдийн сонссон л байх учиртай.

“Тэгвэл та Салемд юу хийдэг юм бэ?” хэмээн хүү шаргуу асууж эхлэв.

“Салемд би юу хийдэг гэж үү?” настан инээснээ. “Зүйтэй, Би Салемийн хаан байна!”

Хүмүүс сонин сонин зүйл ярих юмдаа хэмээн хүү бодлоо. Заримдаа ч хоньтойгоо хамт байх нь дээр ч юмуу тэд ямар юм ярих биш. Ном уншаад суувал бүр ч илүү. Номнууд өөрийнхөө уянгат түүхүүдийг хэзээ хүссэн үед л хэлж өгнө. Гэтэл хүмүүстэй ярилцах үед тэд үнэхээр сонин зүйлс бүр цааш нь яриаг яаж үргэлжлүүлэхээ мэдэхгүй болгох хүртэл зүйлс хэлэх юмдаа.

“Намайг Мэлкизидэк гэдэг.” хэмээн настан хэлэв. “Чамд хэдэн хонь бий вэ?”

“Хангалттай олон,” хэмээн хүү хариуллаа. Тэр хувийн асуудлынх нь талаар настан илүү мэдэхийг хүсч байгааг анхаарлаа.

“За тийм бол бидэнд асуудал гарлаа. Хэрвээ чи хангалттай олон хоньтой гэж бодож байгаа бол би чамд туслаж чадахгүй нь дээ.”

Хүүгийн дургүй нь хүрч эхлэв. Тэр ямар тусламж гуйсан ч биш. Энэ настан өөрөө эхлээд л дарснаасаа балгуулаач гээд бас яриа өдөөд байсан шүү дээ.

“Миний номыг өгөөдөх,” хэмээн хүү хэллээ. “Би явах хэрэгтэй байна хонио цуглуулаад замдаа гарах минь.”

“Надад сүргийнхээ арав хуваасны нэгийг өг,” хэмээн настан хэлээд “Би чамд нуугдсан эрдэнэсийг яаж олохыг хэлж өгье.” Хүү зүүднийхээ талаар санаад тэгмэгц гэнэт бүх зүйл түүнд тодорхой болж ирэв. Настай авгай түүнээс төлбөр аваагүй, харин энэ өвгөн, магадгүй тэр авгайн нөхөр ч байж магадгүй, заль гаргаж огт байдаггүй зүйлийн тухай яриад улам их зүйл салгахыг оролдож байгаагаас зайлахгүй. Энэ хүн ч гэсэн ер нь цыган бололтой.

Гэтэл хүүг үг хэлж амжихаас өмнө, настан тонгойж нэгэн саваа авснаа талбайн элсэн дээр бичиж эхэллээ. Түүний цээжиндэх ямар нэгэн гялгар зүйлээс хурц гэрэл ойн хүүгийн нүдийг хэсэг зуур юм харагдахгүй болтол нь гялбуулав. Настай хүн гэхэд итгэмээргүй шалмаг хөдөлгөөнөөр тэр хүн тэрхүү зүйлийг нөмрөгөөрөө хааж орхив. Хүүгийн хараа нь хэвийн байдалдаа буцаж оронгуут хүү настаны элсэн дээр бичсэн зүйлсийг унших боломжтой боллоо.

Тэрхүү жижиг хотын захын талбайн элсэн дээрээс хүү аав, ээжийнхээ нэрийг түүнчлэн сүмд судлаж байсан хичээлүүдийнхээ талаар уншив. Тэр бас өөрөө ч мэддэггүй нөгөө худалдаачны охины нэрийг болон хэзээ ч хүмүүст ярьж байгаагүй зүйлсийнхээ тухай унших нь тэрээ.

-***-

7 - р хэсэг

"Би бол Салемийн хаан" хэмээн настан хэлсэн билээ.

"Ямар учраас хаан хүн энгийн хоньчинтой ярьж байгаа билээ?" гэж хүү гайхашран асуулаа.

"Хэд хэдэн шалтгааны улмаас. Гэвч хамгийн чухал нь гэвэл чи өөрийн Хувийн бахархалаа илрүүлж чадсанд оршино." Хүү хүний Хувийн бахархал гэж юу байдгийг мэдэхгүй байв.

"Хувийн бахархал гэдэг бол чиний үргэлж биелүүлэхийг хүсдэг зүйл юм. Хүн бүхэн залуу байх үедээ тэдний Хувийн бахархал нь юу болохыг мэдэж байдаг. Тухайн үед тэдэнд бүх зүйл ойлгомжтой, бүх зүйлийг бүтээх боломжтой мэт санагдаж байдаг. Тэд мөрөөдөхөөс айдаггүй бас өөрсдийнхөө амьдралд тохиолдохыг хүссэн зүйлсээ хүлээсэн итгэлээр дүүрэн байдаг. Гэвч цаг хугацаа өнгөрөх тутамд нэгэн хачирхалтай хүч тэднийг Хувийн бахархалаа биелүүлнэ гэдэг бүтэшгүй зүйл хэмээн итгүүлж эхэлдэг." Настны хэлсэн зүйлсийн аль нь ч хүүгийн анхаарлыг татахгүй байв. Гэхдээ хүү худалдаачны охинд ярьж өгч гайхашруулахын тулд тэрхүү хачирхалтай хүч гээч нь юу байдгийг мэдэхийг хүслээ.

"Энэ хүч нь сөргөөр нөлөөлөөд байгаа мэт санагддаг ч үнэндээ бол Хувийн бахархалаа хэрхэн биелүүлэхийг зааж өгдөг хүч юм. Тэрээр чиний сэтгэл санаа болон хүсэл зоригийг бэлтгэдэг учир нь энэ дэлхий дээр нэгэн агуу үнэн зүйл байдаг нь чи хэн ч байсан, юу хийдгээс чинь үл хамааран ямар нэг зүйлийг үнэхээр хүсч байвал тэрхүү хүсэл нь ертөнцийн сүнснээс үүссэн байдаг юм. Энэ нь чиний энэ дэлхий дээрх биелүүлэх даалгавар болно."

"Тэгвэл хүсч байгаа зүйл нь ердөө аялах ч юмуу, аль эсвэл бөс барааны худалдаачны охинтой гэрлэх байсан ч гэсэн үү?"

"Тиймээ, эсвэл баялгийг хайх ч гэсэн. Дэлхийн сүнс нь хүмүүсийн аз жаргалаар тэжээгдэж байдаг. Мөн гуниг зовлон, атаа хорсол, өш хонзонгоор ч гэсэн ялгаагүй. Хүн өөрийнхөө Хувийн бахархалыг биелүүлэх нь хүний жинхэнэ даалгавар юм. Бүх зүйлс адилхан. Хэрвээ чи ямар нэг зүйлийг үнэхээр хүсвэл түүндээ хүрэхэд чинь бүх ертөнц тусалдаг юм."

Тэр хоёр хэсэг хугацаагаар чимээгүй болон захын талбай болон хотын хүмүүсийг ажиглан байлаа. Тэгснээ настан хүүгээс түрүүлж асуув.

"Чи яагаад хонь хариулдаг юм бэ?"

"Яагаад гэвэл би аялах дуртай."

Настан талбайн үзүүрт байх дэлгүүрийнхээ цонхны дэргэд зогсож байгаа талхчин эрийн зүг заангаа "Тэр эр жаахан хүү байхдаа бас л аялахыг мөрөөддөг байсан. Гэвч тэр эхлээд талхны газар худалдаж аваад мөнгө хураахаар шийдсэн. Тэр хөгшрөхөөрөө Африкт сарын хугацаатайгаар аялахаар явах болно. Талхчин эр хүмүүс амьдралынхаа ямар ч үед мөрөөддөг зүйлээ биелүүлэх чадвартай гэдгийг ерөөсөө ухаараагүй юм даа."

"Тэр хоньчин болохоор шийдэх байж дээ," гэж хүү хэллээ.

"Тэр бодоогүй биш бодсон, " хэмээн настан хэлэнгээ "Гэхдээ талхчид бол хоньчидоос илүү чухал хүмүүс шүү дээ. Хоньчид хээр газар унтаж байхад талхчид харин гэр оронтой улсууд. Эцэг эхчүүд хүүхдээ хоньчидоос илүү

талхчинтай суувал баярлах болно." Хүү худалдаачны охины талаар бодонгоо зүрх нь зүсэгдэх шиг л болов. Түүний хотод нь талхчид байж л таараа.

"Эцсийн эцэст хүмүүсийн хоньчид болон талхчидын талаарх бодол нь тэдэнд Хувийн бахархалаас нь илүү чухал болдог юм даа." гэж настан үргэлжлүүлэн хэллээ.

Настан номын хуудсыг эргүүлж байснаа нэг хуудас гарган уншиж эхлэв. Хүү түүнийг хүлээж байснаа настанг яг л өөр шиг нь уншлагыг нь тасалдуулав.

"Ямар учраас та надад энэ бүхнийг яриад байгаа юм бэ?"

"Яагаад гэвэл чи өөрийн Хувийн бахархалаа биелүүлэхийг хичээж байна. Түүнчлэн чи үүнийгээ орхих мөчдөө бараг ирчихээд байгаа учраас."

"Тэгэхээр энэ үед та дандаа гарч ирдэг үү?"

"Үргэлж энэ хэлбэрээр биш ч гэсэн ямар нэг байдлаар заавал илэрдэг. Заримдаа би чухал шийдэл юмуу, ухаалаг санаа байдлаар гарч ирдэг. Зарим үед, эгзэгтэй мөчид илүү хялбараар юмсыг бүтээж өгдөг. Миний хийдэг өөр зүйлс байдаг ч гэсэн ер нь ихэнх тохиолдолд хүмүүс намайг биелүүлж өгсөн гэдгийг ухаардаггүй юм."

Настан өнгөрсөн долоо хоногт нэгэн уурхайчний өмнө чулуу болон хувирч үзэгдсэнээ хуучиллаа. Тэр уурхайчин өөрийнхөө бүх зүйлсийг орхиж маргад эрдэнэ олборлохоор ажилласан байлаа. Таван жилийн турш тэрээр нэгэн голын хөвөөнд ажиллаж хэдэн зуун мянган чулуунаас маргад эрдэнэ хайсан байв. Уурхайчин өөрийн хүслээ орхих тэр үед ахиад ганцхан чулууг л - ердөө ганцхан чулууг л шалгасан бол тэр өөрийн хайсан маргад эрдэнээ олох байлаа. Нэгэнтээ тэрхүү уурхайчин өөрийнхөө бүх зүйлсийг Хувийн бахархалдаа зориулсан учраас настан түүнд туслахаар шийдсэн байна. Тэгээд настан өөрийгөө уурхайчны хөлийн хажууд байх чулуун доторх эрдэнэс болгон хувиргаж гэнэ. Үр дүнгүй өнгөрүүлсэн таван жилийнхээ уур бухимдал, уйтгар гунигт автсан уурхайчин тэрхүү чулууг шүүрэн аваад хажуу тийш нь шидэж орхижээ. Гэхдээ тэр чулууг хагартал шидэж чадсан бол тэрхүү чулууны хэлтэрхий дотор нь энэ хорвоогийн хамгийн гоёмсог үнэт маргад эрдэнэ байсан юм. "Хүмүүс амьдралынхаа эхэн үед тэдний байгаа шалтгаан юу вэ гэдгийг мэддэг," хэмээн настан гашуудалтайгаар хэлээд "Магадгүй тиймдээ ч тэд үүнийгээ түргэн орхидог болов уу. Гэхдээ энэ нь хорвоогийн жам юм даа. " хэмээн өгүүллээ.

Хүү настанд нуусан эрдэнэс, баялгийн талаар ярьсаныг нь санууллаа.

"Эрдэнэс бол урсгал усны хүчээр нээгдэх боловч тэрхүү урсгалдаа нууцлагддаг юм," гэж настан хэллээ. "Хэрвээ чи өөрийнхөө баялгийн талаар мэдэхийг хүсвэл сүргийнхээ аравны нэг хувийг надад өгөх хэрэгтэй."

"Миний баялгийн аравны нэг хувь байвал ямар вэ?"

Настан сэтгэл дундуур байдалтай болов. "Хэрвээ чи одоогоор өөртөө байхгүй байгаа зүйлээ амлаж эхэлвэл түүнийхээ төлөө ажиллаж биелүүлэх хүслээ алдах болно."

Хүү түүнд аль хэдийн өөрийнхөө баялгийн аравны нэг хувийг цыган авгайд өгөхөөр амласнаа хэллээ. "Цыганууд бол хүмүүсийг тийм зүйл хийлгэхдээ гарамгай улсууд," гэж настан санаа алдав. "Гэхдээ ямартай ч гэсэн, амьдрал дээрх бүх зүйл өөрийн үнэтэй гэдгийг чи сурсан чинь сайн хэрэг. Энэ бол Гэрлийн дайчдын сургахаар хичээдэг зүйл шүү."

Настан хүүгийн номыг эргүүлэн өглөө.

"Маргааш, яг өдийд сүргийнхээ аравны нэгийг надад авчир. Тэгээд би чамд нуугдсан эрдэнэсийг хаанаас олохыг хэлж өгье. Өдрийг сайхан өнгөрөөгөөрэй."

Тэгээд тэр захын хашааны булангаар тойрон алга боллоо.

-***-

8 - р хэсэг

Хүү номоо үргэлжлүүлэн уншиж эхэлсэн ч түүний анхаарал нь ер төвлөрөхгүй байлаа. Настаны хэлсэн үг үнэн гэдгийг тэр мэдэж байсан учраас хүү сэтгэлээр унаж уйтгартай болов. Тэр талхны газар руу очин зүсэм талх худалдан авах зуураа талхчинд настаны хэлсэн үгийг хэлэх үү болих уу хэмээн бодож байлаа. Заримдаа юмыг байгаа хэвээр нь орхих нь ч дээр байдагдаа хэмээн тэр бодмогцоо талхчинд юу ч хэлэхгүй байхаар шийдлээ. Хэрвээ тэр хэлвэл талхчин хэдийгээр байгаа орчиндоо дассан ч гэсэн энэ бүхнийгээ орхих талаар бодлогошрон лав л гурван өдрийг барах болно. Хүү талхчинд тэгэж төвөг учруулахыг хүссэнгүй. Тэнд нэгэн байшингийн цонхоор Африк явах тасалбар зарж байв. Тэр Египет Африкт байдгийг мэддэг байлаа.

"Танд юугаар туслах вэ?" хэмээн цонхны цаадах эр асуулаа. "Магадгүй маргааш," гэж хүү хэлэнгээ, өнгөрөн явлаа. Хэрвээ тэр ердөө ганц хонь зарахад л тэр хоолойн цаад талд хангалттай гарч чадах билээ. Тэрхүү бодол түүний айдсыг төрүүлэв.

"Бас нэг мөрөөдөгч," хэмээн хүүг цааш явахыг харах зуураа тасалбар зарагч туслахдаа хэллээ. "Тэр аялах мөнгөгүй байх л даа."

Тасалбарын цонхон дээр зогсож байхдаа хүү сүргийнхээ талаар бодож хоньчин хэвээрээ байх нь дээр юм хэмээн шийдсэн байлаа. Хоёр жилийн хугацаанд хонийг хэрхэн хариулах талаарх бүх л зүйлийг тэр сурч амжсан, хонь хэрхэн хяргахыг, төллөх хонийг хэрхэн арчлахыг бас хонин сүргээ хэрхэн чононоос хамгаалахыг гэхчлэн. Тэр Андалуизагийн бүх л тал нутаг болон бэлчээрийг мэднэ. Бас дээр нь тэр хонь тус бүрээ ямар үнэ хүрэхийг нь мэднэ. Хүү найзынхаа саравч руу аль болох тойруу замаар буцаж явахаар шийдлээ. Хотын цайзыг өнгөрөн явах зуураа тэр түр саатан цайзын хананы орой руу хөтөлсөн чулуун шатаар өгслөө. Тэндээс тэр алсад байх Африкийг харж чадах юм. Хэн нэгэн түүнд Мүүрийнхэн Испанийг эзлэхээр тэндээс ирж байсан гэж хэлж байсан удаатай. Түүний суусан газраас хот бараг бүхэлдээ харагдах бөгөөд нөгөө настантай ярилцаж байсан талбай ч гэсэн л харагдаж байлаа. Настантай уулзсан тэр мөчийг хараал идэг хэмээн хүү бодлоо. Тэр хотод өөрийнхөө зүүдийг тайлж чадах авгайтай л уулзахаар ирсэн шүү дээ. Тэр авгай, настай өвгөн хоёрын аль нь ч хүүг хоньчин гэдгийг авч хэлэлцэхгүй байсан. Тэд бол юманд итгэхээ больсон зожиг хүмүүс тэгээд хоньчид хоньтойгоо ямар ойр байдгийг ойлгохгүй. Хүү сүргийнхээ бүх хонийг, аль нь доголлон, аль нь хоёр

сарын дараа төллөх вэ гэдгийг, аль нь хамгийн залхуу вэ гэдгийг гэхчлэн бүгдийг мэднэ. Хүү тэднийг хэрхэн хяргахаа хэрхэн төхөөрөхөө ч мэднэ. Хэрвээ хүү тэднийг орхихоор шийдвэл хонинуудад нь маш хэцүү байх болно.

Салхи хөдөлж эхэллээ. Тэр энэхүү салхины тухай мэддэг билээ. Хүмүүс түүнийг левантер гэж нэрлэдэг, яагаад вэ гэвэл түүнийг хөлөглөн Мүрийнхэн Газрын дундад тэнгисийн өмнөд эрэгт байх Левант нутгаасаа энд ирж байсан юм. Левантер улам ширүүслээ. Энд би өөрийнхөө сүрэг болон баялаг хоёрынхоо дунд нь байна даа хэмээн хүү бодлоо. Тэр дассан зүйлс юмуу эзэмшихийг хүссэн зүйлс хоёрынхоо аль нэгийг сонгох шаардлагатай байлаа. Худалдаачны охин бас байгаа ч гэсэн тэр түүнд хониноос нь илүү чухал биш юм, учир нь тэр хүүгээс хамаарахгүй. Магадгүй тэр охин бүр хүүг санахгүй ч байж болох юм. Хүүтэй уулзсан өдөр тэр охинд тийм ч содон байгаагүй гэдэгт хүү итгэлтэй байв. Тэр охины хувьд бүх өдөр л адилхан өнгөрдөг гэсэн, бүх өдөр адилхан байгаад байна гэдэг нь хүмүүс өдөр бүр өглөө нар мандахаас эхлээд л тэдэнтэй тохиолддог сайн сайхан зүйлсийг танихаа болисонтой холбоотой билээ. Би аавыгаа, ээжийгээ бас хотоо орхиод гарсан. Тэд ч намайг байхгүй байгаад дассан би ч мөн адил. Хонинууд ч гэсэн намайг байхгүй байхад дасах л болно доо хэмээн хүү бодлоо. Түүний сууж байгаа газраас түрүүний талбайг ажиглаж болохоор байлаа. Хүмүүс талхчны мухлагт орж гарсаар л байв. Хүүгийн настантай ярилцаж байсан сандал дээр залуу хос сууж байх бөгөөд тэд үнсэлцлээ.

“Нөгөө талхчин ...” гэж тэр өөртөө хэлснээ бодлоо үргэлжлүүлсэнгүй. Левантер улам л хүчтэй болсоор хүүгийн нүүрэнд хүч нь мэдрэгдэж байлаа. Энэ салхи Мүрийнхнийг бас элсэн цөлийн болон гивлүүртэй бүсгүйчүүдийн үнэрийг авч ирдэг. Энэ салхи үл мэдэгдэх зүйл, алт, адал явдал бас Пирамидийг зорин алс холын аянд мордсон эрчүүдийн хөлс болон мөрөөдлийг өөртөө шингээн авч ирэх бөлгөө. Хүү салхины эрх чөлөөт байдалд атаархах сэтгэл төрсөн ч бас тэр салхитай адилаар эрх чөлөөтэй байж чадахаа харлаа. Түүнийг өөрөөс нь өөр хэн ч ухрааж чадахгүй. Хонинууд нь, худалдаачны охин бас Андалуизагийн тал нутаг бүгд л түүний Хувийн бахархалын зам дагуух алхмууд юм даа.

Маргааш нь хүү настантай жин үдэд уулзав. Тэр зургаан хонь туун авчирсан байлаа.

“Би маш их гайхлаа,” гэж хүү хэллээ. “Миний найз үлдсэн бүх хонийг шууд л худалдаад авчихлаа. Тэр хэлэхдээ тэр үргэлж л хоньчин болохыг хүсдэг байсан болохоор энэ бол сайн зөн гэж хэлсэн.”

“Энэ бол үргэлж байдгаараа байдаг тэр л зүйл,” гэж настан хэллээ. “Үүнийг тус болохын зарчим гэдэг юм. Хэрвээ чи анхны удаад хөзөр тогловол хожих нь бараг л гарцаагүй юм. Энэ нь Эхлэгчдийн аз.”

“Яагаад тэр билээ?”

“Яагаад гэвэл чамайг Хувийн бахархалаа биелүүлэхийг хүсч байдаг хүч оршдог юм. Тэрхүү хүч чиний хийх хүслийг амжилтын амтаар шагнадаг.”

Тэгээд настан хонинуудыг шалгаж эхэлснээ нэг хонь доголлон байгааг анзаарав. Хүү түүнд тэрхүү хонь сүргийн хамгийн ухаалаг нь болохоос гадна хамгийн их

ноостой хонь учраас доголлон байгаа нь тийм ч чухал биш хэмээн тайлбарлаж өгөв.

“Эрдэнэс хаана байгаа вэ?” гэж хүү асуулаа.

“Эрдэнэс Египетэд, Пирамидуудын ойролцоо.” Хүү гайхашрлаа. Настай авгай бас үүнийг хэлж байсан билээ. Гэхдээ тэр авгай түүнээс ямар ч хөлс аваагүй.

“Эрдэнэсийг олохын тулд чи зөн совингуудыг дагах ёстой. Бурхан хүн бүхэнд дагах замыг нь бэлдсэн байдаг юм. Чи зөвхөн түүний чамд үлдээсэн зөн совингуудыг л таниж унших ёстой болно доо.”

Хүүг хариу хэлэхээс өрсөж нэгэн эрвээхэй хүү болон настан хоёрын дунд эргэлдэн нисэв. Тэр эрвээхэй бол сайн үйл тохиолдохын тэмдэг хэмээн өвөөгийнхөө хэлж байсныг саналаа. Яг л дэвхрэгүүд шиг, яг л тохиолдлыг хүлээх найдвар мэт лизард гүрвэл мэт, дөрвөн дэлбээт цэцэг мэт. “Тэр үнэн,” хэмээн настан хэллээ. Настан хүүгийн бодлыг унших чадвартай шүү дээ. “Өвөө чинь заасантай адил. Энэ бол сайны тэмдэг.”

Настан хүрмээ задгайлах үед хүү харсан зүйлдээ ихэд гайхав. Настан зузаан алтаар хийж үнэт чулуугаар гоёсон цээживч өмссөн байлаа. Хүү өмнөх өдөр ажиглагдсан хурц гэрлийг эргэн саналаа. Тэр үнэхээр хаан байлаа! Тэр хулгайчидтай тааралдахаас сэргийлэн зүсээ хувилгаснаас гарцаагүй.

“Үүнийг ав,” хэмээн настан цээживчний төв хэсэгт байрлах цагаан, хар чулууг авч хүү рүү сарвайлаа. “Эдгээрийг Урим болон Түмим гэж нэрлэдэг. Хар нь ‘тийм’, цагаан нь ‘үгүй’ гэсэн утгатай. Хэрвээ чи зөн совингоо уншиж чадахгүй бол эдгээр нь чамд тусална. Үргэлж бодитой асуулт асуугаарай. “Гэхдээ чи чадвал өөрөө шийдвэр гаргаж байхыг хичээгээрэй. Эрдэнэс Пирамидуудад байгааг чи аль хэдийн мэдэж байсан ч гэлээ би зургаан хонийг төлбөртөө авахаар шаардах эрхтэй учир нь би чамд шийдвэр гаргахад чинь тусласан.”

Хүү чулуунуудыг богцондоо хийлээ. Үүнээс цааш тэрээр шийдвэрээ өөрөө гаргах болно. “Чамд тохиолдох зүйлс өөр юу ч биш зөвхөн нэг ижил л зүйл гэдгийг бүү мартаарай. Мөн зөн совингийн хэлийг битгий мартаарай. Юу юунаас түрүүнд Хувийн бахархалаа төгсгөлд нь хүртэл дагахаа бүү март. “ “Явахынхаа өмнө би чамд нэг бяцхан түүх ярьж өгье.”

“Нэгэн худалдаачин аз жаргалын нууцын тухай энэ дэлхийн хамгийн цэцэн ухаантнаас суралцуулахаар хүүгээ явуулжээ. Хүү нь цөлөөр дөчин хоног туулсаар арайхийн өндөр уулын оройд байрлах үзэсгэлэнт шилтгээнд иржээ. Энд цэцэн ухаантан амьдардаг байв. Шилтгээний гол танхимд ортол цэцэн ухаантантай уулзах биш харин худалдаачид ирж буцан, хүмүүс энд тэнд бөөгнөрөлдөн ярилцаж бас цөөн хүнтэй найрал хөгжим намуухан хөгжим тоглож байхаас гадна тэр нутгийн хамгийн амттай зоогийг нэгэн ширээн дээр дэлгэсэн байлаа. Нөгөө цэцэн ухаантан хүн бүхэнтэй яриа өрнүүлэх учир хүү түүнтэй ярилцахаас өмнө хоёр цаг хүлээх ёстой болов.

“Цэцэн ухаантан хүүг ямар учраас ирснийг анхааралтай сонссон боловч хүүд аз жаргалын нууцыг тайлбарлах цаг даанч алга даа гэж хэлээд хүүг ордноор юм сонирхож байгаад хоёр цагийн дараа эргэн ирэхгүй юу хэмээлээ. “Гэхдээ би чамаас нэг зүйлийг хийхийг хүсье, гэж ухаантан хэлээд жижиг халбаганд хоёр дусал тос дусаан хүүд өгөв. Ордноор зугаалахдаа энэхүү халбагыг авч яваад

тосыг нь бүү асгаарай гэж хэллээ. “Хүү ордны олон шатаар өгсөж уруудан явахдаа халбаганаас нүдээ салгасангүй.

Хоёр цагийн дараа тэрээр ухаантан байгаа өрөөнд буцан ирлээ. “Өө, чи хүрээд ирэв үү” хэмээн ухаантан хэлснээ, ‘Чи зоогийн танхимын ханыг чимэглэсэн Перс хивснүүдийг харав уу? Чи шилдэг цэцэрлэгчийн арван жил ургуулсан цэцэрлэгийг минь харав уу? Номын санд байгаа үзэсгэлэнтэй ховор бичмэл номуудыг ажиглав уу?’ “Хүү балмагдан юу ч ажиглаж амжаагүйгээ хүлээлээ. Тэр зөвхөн халбагатай тосыг л асгахгүйг хичээж явсан байв. “ Тэгвэл буцаж яваад миний ертөнцийн сайхан зүйлстэй танилцаад ирдээ,’ гэж ухаантан хэллээ. Чи ямар гэрт амьдардагийг нь мэдэхгүйгээр хүнд итгэж чадахгүй шүү дээ. Тайвширсан хүү халбагаа шүүрэн авч ордонтой танилцахаар яваад энэ удаад хана таазанд байх бүх л зураг, баримлуудыг ажиглалаа. Тэр цэцэрлэгүүдийг, тэдгээрийг тойрсон уулсыг, цэцэгнүүдийн үзэсгэлэнг бүгдийг нь харж амттан шимттэнээс нь сонгон амсаж явлаа. Цэцэн ухаантан дээр буцаж ирээд тэрээр харсан зүйлсээ бүгдийг нь тоочин ярив.

“Гэхдээ миний чамд хадгалуулсан тос хаана байна вэ?” гэж ухаантан асуулаа. Хүү барьсан халбага руугаа хартал тос аль хэдийн алга болсон байлаа. “Тэгэхээр би чамд зөвхөн нэг л зүйлийг зөвлөж чадах байна хэмээн цэцэн ухаантан хэллээ. “Аз жаргалын нууц гэдэг бол ертөнцийн бүх гайхамшигийг харахын зэрэгцээгээр халбагандаа байгаа тосоо мартажгүй байхыг л хэлж байгаа юм гэлээ.

Хоньчин юу ч дуугарсангүй. Тэрээр настай хаантаны хэлсэн түүхийг ойлгож байлаа. Хоньчин аялах дуртай байж болох ч тэр хонинуудаа хэзээ ч мартаж ёсгүй.

Настан хүү рүү харж байснаа гараа алдлан хүүгийн толгой дээгүүр хэд хэдэн хачирхалтай хөдөлгөөн хийв. Тэгснээ түүний хонийг туун явж одлоо.

9 - р хэсэг

Тарифагийн хамгийн өндөрлөг хэсэгт Мүрийнхний барьсан нэгэн хуучин бэхлэлт байдаг байлаа. Түүний ханан дээрээс Африкийн барааг харж болох билээ. Тэр өдрийн үд өнгөрч байхад Мэлкизедек, Салемийн хаан маань мөнөөх бэхлэлтийн ханан дээр суугаад, левантер нүүрийг нь илбэн байхыг мэдрэн байв. Хонинууд шинэ эзнээсээ үргэсэн байдалтай ойролцоохон нь идээшилж, гарсан гэнэтийн их өөрчлөлтөнд цочирдсон байдалтай байв. Хонинуудын хүсэх зүйл нь ердөө өвс, ус л юм даа.

Мэлкизедек нэгэн багахан хөлөг онгоц эргээс хөдлөн явахыг ажиглан байлаа. Тэр хүүг ахиж хэзээ ч харахгүй яг л тэр өөрөө Абрахамд эрдэнэсийнхээ аравны нэг хувийг өгснөөсөө хойш хараагүйтэйгээ адилаар. Энэ бол түүний хийдэг ажил. Бурхадад хүсэл мөрөөдөл гэж байхгүй байх ёстой учир нь тэдэнд Хувийн бахархал гэж байхгүй. Гэхдээ Салемийн хаан хүүг амжилтанд хүрээсэй хэмээн үнэн зүрхнээсээ найдаж байлаа. Хүү миний нэрийг түргэн мартаж нь тоогүй еэ хэмээн тэр бодлоо. Хүүд нэрээ дахин давтаж хэлэх хэрэгтэй байсан юм. Тэгвэл хүү миний тухай Мэлкизедек, Салемийн хаан хэмээн ярьж байх болно.

Тэр дээшээ тэнгэр рүү харснаа бага зэрэг ичингүйрсэн байдалтайгаар “Эзэн минь, миний бодож байгаа зүйл бол хувиа хичээсэн адгийн бодол гэдгийг мэдэж байна. Гэхдээ настай хаантан заримдаа өөрөөрөө бахархаж байх хэрэгтэй шүү дээ” хэмээн хэллээ.

-***-

10 - р хэсэг

Африк хир сонин газар байдаг болдоо хэмээн хүү бодлоо.

Тэр Танжиерийн нарийн гудамжуудын дагуу байрлах олон баарнуудтай адилхан нэг бааранд сууж байлаа. Зарим эрчүүд асар том гаансыг бие биедээ дамжуулан татацгаана. Хэдхэн цагийн дотор тэрээр хөтлөлцөн алхах эрчүүдийг, нүүрээ халхалсан хүүхнүүдийг, цамхагийн оройд гаран уншлага үйлдэх лам болон хүн бүхэн өвдөглөн сууж духаа газарт хүргэн бөхийн залбирахыг харлаа. "Бүдүүлгүүдийн заншил" хэмээн тэр өөртөө хэллээ.

Багадаа сүмд сурч байх үедээ хүү Гэгээн Сантьяого Матаморос цагаан морио уначихаад сэлмээ сугалахад энд харсан хүмүүс шиг хүмүүс өвдөг сөгдөн байдаг тэр зургийг үргэлж ажигладаг байж билээ. Хүүгийн сэтгэл эвгүйцэн маш ихээр ганцаардаж байлаа. Энэхүү бүдүүлгүүд харахад их сонин юм. Үүнээс гадна гэнэтийн аялалынхаа яарууд тэрээр нэг зүйлийг, зөвхөн нэг зүйлийг тэр нь түүний баялагаас удаан хугацаагаар тусгаарлаж ч магадгүй тэр зүйлийг мартсан нь юу вэ гэвэл энэ нутагт хүмүүс зөвхөн Араб хэлээр л ярьдаг юм байжээ.

Баарны эзэн хүүд ойртон ирэхэд хүү хажуугийн ширээнийхний ууж байгаа ундаа руу заалаа. Тэр ундаа нь гашуун амттай цай болж таарав. Хүү дарсыг илүүд үздэг билээ. Хүү одоохондоо үүний талаар санаа зовох шаардлагагүй юм. Түүний анхаарлаа хандуулах ёстой зүйл гэвэл түүний баялаг болон хэрхэн түүнийг олж авах талаарх асуудал байлаа. Хонинуудаа зарснаар түүнд хангалттай мөнгө хуримтлагдсан бөгөөд мөнгө байгаа цагт ид шидийн мэт байдгийг хүү мэднэ, ер нь мөнгөтэй хүн бол ганцаараа биш л гэсэн үг. Магадгүй хэдэн өдрийн дараа л тэр Пирамидуудад хүрчих байх. Алтан цээживч зүүсэн настан зургаахан хонь авахын тулд худал хэлнэ гэж арай ч баймааргүй юм. Тэр настан хүүд зөн совин болон учрах тэмдгүүдийн талаар ярьсны дараа хүү хоолойг гаталж явахдаа зөн совингийн талаар бодож явсан билээ. Тийм дээ, настан юуны талаар ярьж байгаагаа үнэхээр л мэддэг хүн байж дээ, Андалуизагийн тал нутгаар өнгөрүүлсэн хугацаандаа хүү аль замаар явахаа газар болон тэнгэрийг ажиглаад л сонгож сурсан байсан юм. Хүү зарим шувуу дайралдах нь могой ойрхон байгааг заана гэдгийг, мөн зарим нялцгай биетэн дайралдана гэдэг нь тэр хавьд ус байгааг илэрхийлдэг гэдгийг сурчихсан байсан шүү дээ. Хонинууд түүнд эдгээрийг сургасан юм. Хэрвээ Бурхан хонийг тийм сайн дагуулж байгаа юм чинь хүнийг ч мөн адил байлгүй дээ хэмээн тэр бодмогцоо сэтгэл нь тайвшрав. Нөгөө цайны амт тийм ч гашуун биш мэт санагдаж эхлэв.

"Чи хэн бэ?" хэмээн хэн нэгэн түүнээс Испаниар асуухыг тэр сонслоо. Хүү тайвшрав. Тэрээр зөн совингийн талаар яг бодож байх зуур хэн нэгэн тааралдав.

"Чи чинь яахаараа Испаниар ярьж чаддаг байнаа?" гэж хүү асуулаа. Шинэ танил нь нэг барууны маягаар хувцасласан залуу хүү байсан бөгөөд түүний арьсны өнгө нь тэр хүү энэ хотынх гэдгийг нь илчилж байв. Тэр мөн түүнтэй нуруугаар ч, насаар ч ойролцоо хүү байлаа.

"Эндхийн бараг бүх хүн л Испаниар ярьдаг. Бид Испаниас ердөө хоёрхон цагийн зайтай л байна шүү дээ."

"Суугаач, би чамайг уух юмаар дайлая," хэмээн хүү хэллээ. "Тэгээд надад хундага дарс захиалаад өгөөч би энэ цайг ууж чадахгүй нь."

"Энэ нутагт дарс байдаггүй юм," гэж залуу хүү хэллээ. "Эндхийн шашинд хориотой."

Хүү шинэ танилдаа Пирамидууд руу явах хэрэгтэй байгаагаа хэллээ. Тэр бараг л тэнд буй баялгийнхаа талаар ярих шахсан боловч хэлээд хэрэггүй хэмээн шийдлээ. Хэрвээ хэлчих юм бол энэ араб тэнд хүргэснийхээ хөлсөнд хувь хүртэж магадгүй юм. Тэр одоогоор байхгүй байгаа зүйлээ санал болгох талаар настан юу гэж хэлснийг саналаа.

"Хэрвээ чи чадна гэвэл би чамайг газарчинаар хөлслөө."

"Тэнд хэрхэн хүрэх талаар төлөвлөгөө чамд байна уу?" гэж шинэ танил нь асуулаа.

Хүү тэрхүү баарны эзэн ойролцоо зогсоод тэдний яриаг анхааралтай сонсож буйг ажиглалаа. Түүний байдал нэг л сонин санагдаад явчихав. Гэхдээ хүү газарчин олчихсон тул энэхүү боломжоо алдахыг хүсэхгүй байлаа.

"Чи Сахарын цөлийг хөндлөн гатлах болно доо," гэж залуу эр хэлээд "Үүний тулд чамд мөнгө хэрэгтэй. Чамд хангалттай мөнгө байгааг би мэдмээр байна."

Хүү ямар хачин асуулт вэ гэж бодлоо. Гэвч хүү настны хэрвээ чи ямар нэг зүйлийг чин сэтгэлээсээ хүсвэл энэ ертөнц үргэлж чиний төлөө байдаг хэмээсэнд итгэсэн билээ. Тэрээр мөнгөө гаргаад залуу эрд харууллаа. Баарны эзэн ойртон ирээд мөн харлаа. Тэр хоёр арабаар хэдэн үг солилцоход баарны эзэн зэвүүцсэн шинжтэй харагдаж байлаа.

"Эндээс гарцгаая," гэж шинэ танил хэлээд "Тэр биднийг явахыг шаардаж байна." гэв.

Хүү тайвширлаа. Тэр тооцоогоо хийхээр босмогц баарны эзэн түүнийг татан авснаа ууртайгаар хэдэн үг хэлэв. Хүү тэнхээтэй, мөн эсэргүүцэхийг хүссэн боловч тэр харийн нутагт байгаа билээ. Түүний шинэ найз нь баарны эзнийг хажуу тийш нь түлхээд хүүг дагуулан гадагш гарлаа.

"Тэр чиний мөнгийг авахыг хүсч байна," гэж тэр хэлэв. "Танжиер бол Африкийн бусад хэсгээс өөр. Энэ бол боомт. Боомт бүрт өөрсдийн хулгайчид байдаг юм."

Хүү шинэ танилдаа итгэж байв. Тэр аюултай байдлаас гарахад нь тусаллаа шүү дээ. Залуу эр хүүгийн мөнгийг гаргаж ирээд тоолж эхэллээ. "Бид Пирамидуудад маргааш гэхэд бараг хүрчихнэ," гэж залуу эр мөнгийг авангаа хэллээ. "Гэхдээ би хоёр тэмээ худалдаж авах шаардлагатай."

Тэд хамтдаа Танжиерийн нарийн гудамжуудаар алхацгаав. Хаа сайгүй бараа өрсөн лангуунууд байх аж. Тэд захын талбайн голд очицгоолоо. Зах дээр мянга мянган хүмүүс хэлэлцэцгээн, наймаа хийн, бараа худалдаж аван байх агаад хүнсний ногоонууд хутгануудын дэргэд, хивснүүд тамхины хажууд гэх мэтчилэн холилдсон байх ажээ. Гэвч хүү шинэ танилаасаа огтхон ч хараа салгахгүй явлаа. Эцсийн эцэст түүнд хүүгийн бүх мөнгө яваа шүү дээ. Хүү мөнгөө буцааж авъя гэж хэлмээр байсан ч нөхөрсөг бус зүйл болох байх гэж шийдлээ. Тэр энэхүү хачирхалтай газрын ёс заншлуудын талаар юу ч мэдэхгүй байгаа билээ.

“За би түүнийг ажиглаж л байя,” хэмээн тэр өөртөө хэллээ. Тэр өөрийгөө шинэ танилаасаа илүү чадалтай гэж мэдэж байв. Гэтэл гэнэтхэн энэ бүх эргэлзээний дунд тэрээр амьдралдаа хэзээ ч харж байгаагүй хамгийн сайхан сэлмийг харж орхив.

Хуйг нь мөнгөөр товойлгон сийлсэн, бариул нь хар өнгөтэй бөгөөд үнэт чулуугаар чимэглэсэн сэлэм байлаа. Хүү Египетээс буцаж ирэхээрээ тэрхүү сэлмийг худалдаж авна даа гэж өөртөө амлав. “Лангууны эзнээс энэ сэлэм ямар үнэтэйг асуугаад өгөөч,” гэж тэр найздаа хэллээ. Тэгээд тэр хэсэг хугацаанд сэлмийг ажиглан сатаарснаа мэдэрлээ. Түүний зүрх нь булгилж цээж нь түүнийг гэнэтхэн хавччихсан мэт л санагдаж байлаа. Тэр орчин тойрноо анхаарахаасаа ч айж байлаа учир нь тэр юу харахаа мэдэж байлаа. Хүү сэлмийг эргэн тойрноо харах сэхээ ортлоо үргэлжлүүлэн харав. Түүний эргэн тойронд ирж буцсан, хашгирсан бараа худалдаж авсан хүмүүс, этгээд хүнсний үнэр бүхий тэрхүү зах байсан ч хүү шинэхэн танилаа хаанаас нь ч хайгаад олсонгүй.

Хүү түүний найз нь санамсаргүйгээр л хэсэгхэн хугацаанд түүнээс салчихлаа хэмээн итгэхийг хүсч байв. Хүү тэндээ үлдээд түүнийг буцаж ирэхийг нь хүлээхээр шийдэв. Хүлээх зуур нь нэгэн ламтан ойролцоох цамхагийн оройд гарч мөргөлөө эхлэхэд зах дээр байгаа хүн бүхэн өвдөглөн духаа газарт хүргэн залбирцгааж байв. Тэгснээ яг л шоргоолжны арми шиг тэд лангуунуудаа хураагаад явцгаалаа. Нар ч мөн жаргаж эхэллээ. Хүү нар захыг тойрон байх хэсэг цагаан байшингуудын араар далдрах болтол нь нарны шингэх замыг ажиглан зогслоо.

Хүү энэхүү нарыг энэ өглөө мандах үед өөр тивд жаран хоньтой хоньчин нэгэн охинтой учрахыг хүсэн байснаа эргэн саналаа. Тэр өглөө хүү өөрт нь юу тохиолдож болохыг танил тал нутгаараа аялах зуураа мэддэг байсан юм. Гэвч одоо нар шингэж эхлэх энэ үед тэр хүний нутагт тэр тусмаа хэлээр нь ч ярьж чадахгүй харийн хүн болон хувирлаа. Тэр одоо хоньчин биш түүнд юу ч алга бүүр нутагтаа очиж бүхнийг шинээр эхлэх мөнгө ч үгүй л болов. Энэ бүх зүйл нар мандахаас эхлээд шингэхийн хооронд болчихлоо гэж үү хэмээн хүү бодлоо. Тэр өөрийгөө өрөвдөж амьдрал гэнэтхэн ингэж орвонгоороо өөрчлөгдсөнд халаглан байлаа. Тэр ичсэнээсээ болоод уйлмаар байлаа. Тэр хонинуудынхаа дэргэд ч уйлж үзээгүй билээ. Гэвч захын талбай хоосон тэр гэрээсээ алс хол байсан болохоор уyllлаа. Тэр Бурхан шударга биш байсанд мөн Бурхан мөрөөдөлдөө итгэгчдэд ийм зүйлээр хариу барьдагт нь уyllлаа. Хоньтойгоо байхдаа би аз жаргалтай миний орчин тойрныхон ч гэсэн аз жаргалтай байж дээ. Хүмүүс намайг хараад ирж мэндэлцгээдэг байсан даа гэж тэр бодлоо. Гэвч одоо би гунигтай бас ганцаараа. Би хүмүүст дургуйцэж, итгэмээргүй байна учир нь нэг хүн намайг хуурчихлаа. Би өөрсдийн баялгаа олсон хүмүүст атаархаж

байна учир нь би өөрийнхийгөө хэзээ ч олохгүй. Тэгээд одоо би өөртөө оногдсон өчүүхэн зүйлээ л арчилж явах болно яагаад вэ гэвэл би дэлхийг ялан дийлэхэд дэндүү өчүүхэн амьтан юм.

Тэр өмчнөөс нь юу үлдсэнийг харахаар хүүдийгээ онгойлголоо. Магадгүй хөлөг онгоцон дээр идэж байсан хачиртай талхнаас жаахан ч гэсэн үлдсэн байж магад. Гэвч тэр нэгэн зузаан ном, хүрэм бас настны өгсөн хоёр чулууг гаргаж ирлээ. Чулуунуудыг хэсэг ажиглах зуураа ямар нэгэн шалтгаанаар тэр тайвшрав. Тэр зургаан хонио хоёр үнэт чулуугаар алтан цээживчтэй настанд зарчихсан шүү дээ. Тэр чулуунуудыг буцах тасалбараар зарж ч болно. Гэхдээ энэ удаад би арай ухаалаг хандая байз гэж тэр бодонгоо чулуунуудыг үүргэвчнээсээ аван халаасандаа хийлээ.

Энэ бол боомт хот түүний шинэхэн андын хэлсэн ганц үнэн үг гэвэл боомт хотууд хулгайчуудаар дүүрэн байдаг ажээ. Хүү баарны эзэн яагаад халаглаж байсныг сая л ойлголоо. Тэр хүүд шинэ танилдаа итгэж болохгүй гэдгийг хэлэхээр оролдсон байх нь.

“Би бусдын л адил юм даа. Би энэ хорвоог өөрийнхөө хүссэн зүйлийг тохиолдоосой л гэж хардагаас үнэндээ яг тохиолддог зүйлсийг хардаггүй юм байна.”

Хүү чулуунуудаа хуруугаараа зөөлөн тэмтрэн тэдгээрийн дулааныг болон гадаргууг нь мэдрэн байлаа. Тэр чулуунууд бол хүүгийн баялаг юм. Тэднийг бариж байгаа нь түүний сэтгэлийг тайвшруулж байлаа. Чулуунууд хүүд настныг санагдуулах аж. “Хэрвээ чи ямар нэг зүйлийг чин сэтгэлээсээ хүсвэл хорвоо ертөнц чамайг түүндээ хүрэхэд чинь туслаж байдаг,” хэмээн настан хэлсэн билээ. Хүү настны хэлсэн үгийн үнэн учрыг ойлгохыг хичээж байлаа. Хүү захын эзгүй хашаанд халаасандаа ганц ч зоосгүй шөнийн туршид манаж хонох хонинууд ч үгүй ганцаараа байлаа. Гэвч чулуунууд нь түүнийг хүүгийн туулсан амьдралыг мэддэг хаантай үулзсаных нь баталгаа болж байв.

“Тэднийг Урим болон Түмим гэдэг бөгөөд чамд зөн совинг тайлж уншихад туслах болно.” Хүү чулуунуудаа халаасандаа буцаан хийгээд туршиж үзэхээр шийдэв. Настан маш тодорхой асуулт тавиарай гэсэн ба хүү үүний тулд юу хүсч байгаагаа мэдэх шаардлагатай билээ. Тэгээд тэр настны өршөөл одоо ч гэсэн байгаа эсэхийг асуулаа. Тэгээд нэг чулууг татан гаргаж ирэв.

Тэр нь “Тийм” гэсэн чулуу байв.

“Би өөрийн баялгаа олох болов уу” гэж тэр асуулаа. Тэр гараа халаасандаа шургуулаад нэг чулууг нь тойруулан тэмтрэв. Түүнийг ингэх хооронд чулуунууд нь халаасных нь цоорхойгоор газарт уналаа. Хүү халаасанд нь цоорхой байсныг ажиглаагүй билээ. Тэр Урим, Түмим хоёроо буцаан халааслахаар доош өвдөглөн суув. Чулуунуудыг газарт байгааг харах зуур нь түүнд өөр нэг захиас санаанд нь орж ирлээ.

“Зөн совингоо ажиглаж ойлгоод, түүнийг дагаж сур” хэмээн настай хаан хэлсэн билээ.

Зөн совин.

Хүү инээмсэглэв. Тэр чулуунуудаа аваад халаасандаа буцаан хийлээ. Тэр халаасныхаа цоорхойг нөхөхийг ч бодсонгүй чулуунууд нь хүссэн цагтаа унаж болох шүү дээ. Тэр хүн өөрийн Хувийн бахархалаасаа зайлсхийхгүйн тулд зарим нэгэн зүйлсийг асууж болдоггүйг ухаарлаа.

“Би шийдвэрээ өөрөө гаргана гэж амласан шүү дээ,” хэмээн тэр өөртөө хэлэв. Түүнд чулуунууд нь настны өршөөл одоо ч түүнтэй хамт байгаа гэдгийг хэлсэн тул хүүг илүү итгэлтэй болгож байлаа. Тэр эзэнгүй захыг тойруулан ахин нэг харснаа цөхөрсөн байдал нь өмнөхөөсөө багассаныг мэдрэв.

Энэ тийм ч хачин газар биш юм байна, харин энэ бол шинэ газар юм байна. Эцсийн эцэст хүүгийн үргэлж хүсдэг зүйл нь гэвэл ердөө л шинэ газруудыг мэдэх шүү дээ. Тэр хэзээ ч Пирамидуудад хүрч чадахгүй байсан ч гэсэн өөрийнхөө мэдэх бүх хоньчдоос хол аялчихсан байгаа билээ. Ээ, тэдгээр хоньчид ердөө хоёрхон цаг усан онгоцоор аялахын зайтай газарт юмс ямар ялгаатай байгааг мэддэг ч болоосой хэмээн хүү бодлоо.

Түүний шинэ ертөнц нь одоогоор ердөө л захын хоосон талбай байгаа ч тэрээр энд амьдрал буцалж байхыг харсан бөгөөд түүнийг хүү хэзээ ч мартажгүй билээ. Хүү нөгөө сэлмийг эргэн саналаа. Тэрхүү сэлмийн тухай бодох нь жаахан харамсалтай байсан ч гэсэн хүү тийм сэлмийг өмнө нь ердөө ч харж байгаагүй билээ. Хүү эдгээр зүйлсийн талаар бодлогошрон байх зуураа тэрээр өөрийгөө хулгайчийн өрөвдөлтэй хохирогч уу аль эсвэл өөрийнхөө баялгийн эрэлд яваа аз сорин аялагч уу гэдгээ сонгох ёстой гэдгээ ухаарлаа.

“Би бол баялгийн эрэлд явж буй аялагч,” хэмээн тэр өөртөө хэллээ.

-***-

11-р хэсэг

Хэн нэгэн хүн түүнийг сэгсрэхэд хүү сэрлээ. Тэр нөгөө захын гол дунд нам унтсан байсан бөгөөд захын үйл ажиллагаа ер нь эхлэж байв. Эргэн тойрондоо хонинуудаа байгаа эсэхийг харангаа хүү өөрийгөө шинэ ертөнцөд байгаагаа ухаарлаа. Гэхдээ уйтгарлахын оронд хүү жаргалтай байлаа. Тэр хонинууддаа өвс устай бэлчээр хайн явах шаардлагагүй, харин өөрийнхөө баялгийн төлөө явах боломжтой шүү дээ. Тэр халаасандаа ганц ч зоосгүй ч гэлээ түүнд итгэл байлаа. Урьд шөнө тэрээр уншиж байсан номнууддаа гардаг баатруудтайгаа адилаар өөрөө адал явдлын эзэн хэмээн шийдсэн билээ.

Хүү захаар алгуурхнаар алхлаа. Худалдаачид лангуугаа угсран байсан бөгөөд хүү нэгэн чихрийн худалдаачинд лангуугаа угсрахад нь туслав. Тэрхүү худалдаачин жаргалтай инээмсэглэн, ажилдаа тааламжтайгаар өдрийнхөө ажлыг эхлэхэд бэлдэж байв. Түүний инээмсэглэл нь хүүд нөгөө настныг, нөгөө үл тайлагдах настныг санагдуулж байв. Энэ чихрийн худалдаачин сүүлд нь аялахын тулд юмуу худалдаачны охинтой гэрлэхийн тулд чихрээ хийгээгүй нь лавтай даа хэмээн хүү бодлоо. Энэ хүн үүнийг хийдэг, яагаад вэ гэвэл тэр үнэхээр энэ ажлыг л хийхийг хүсдэг юм байна гэж хүү бодлоо. Тэр өөрийгөө нөгөө настны хэлсэнчлэн хүн ер нь өөрийнхөө Хувийн бахархалтай ойр байна уу хол байна уу гэдгийг мэдэрч чадах юм байна гэдгээ ухаарлаа. Ердөө тэднийг харахад л ойлгомжтой юм. Энэ үнэхээр хялбархан авч өмнө нь би ерөөсөө туршиж байгаагүй юм байна гэж хүү бодлоо. Лангууг угсарч дуустал чихрийн

худалдаачин тухайн өдөр хийсэн анхны чихрээсээ хүүд амсууллаа. Хүү худалдаачинд талархан чихрийг амтархан идэнгээ цааш явлаа. Тэрээр цаашаа жаахан холдох зуураа тэнд байсан хүмүүс лангуугаа угсрахдаа зарим нь арабаар зарим нь испаниар ярилцан байхыг сонсов. Тэгээд тэд нэг нэгэнтэйгээ саадгүй ойлголцох ажээ. Ер нь үгээр илэрхийлэгдэдгүй бүгдийн ойлгодог хэл байдаг юм байна гэж хүү бодлоо. Би өмнө нь үүнийг хонинуудтайгаа байхдаа мэдэрсэн одоо хүмүүсийн дунд надад мэдэгдэж байна даа.

Тэрээр маш олон шинэ зүйлст суралцаж байлаа. Тэдгээрийн зарим нь түүнд өмнө нь хэрэглэгдэж л байсан үнэхээр тийм шинэ зүйлс биш ч гэлээ өмнө нь анзаарч байгаагүй зүйлс байлаа. Яагаад өмнө нь түүнийг ажиглаж байгаагүй вэ гэхээр тэр дасчихсан байсан учраас анзаараагүй байлаа. Түүнд хэрвээ энэхүү үггүйгээр ойлголцох хэлийг сурчих юм бол дэлхийг ойлгож болохоор мэт санагдлаа. Сэтгэл нь тайвшран алгуурхнаар алхангаа хүү ер нь Танжиерийн давчуу гудамжуудаар явъя хэмээн шийдлээ. Чухамхүү тэгснээр л хүү өөртөө тохиолдох зөн совинг унших боломжтой болох байв. Тэрээр энэ үйлдэл нь маш их тэвчээр шаардана гэдгийг мэдэрч байв. Хүү энэхүү харийн жигтэй нутагт хонинуудтайгаа хамт байхдаа сурсан зүйлсээ ахин нэг удаа хэрэглэж байгаагаа анзаарлаа. “Бүх зүйлс нэг,” хэмээн настан хэлсэн билээ.

12-р хэсэг

Болор эдлэлийн худалдаачин энэ өдөр сэрээд өглөө бүр л сэрэхэд нь сэтгэлд нь буудаг нөгөө таагүй байдлаа мэдэрлээ. Тэр энэ газар гучин жилийн туршид толгодын орой дээр байрлах цөөхөн хэдэн хүн очдог дэлгүүр ажиллуулж байгаа билээ. Одоо өөрчлөлт хийхэд дэндүү оройтож түүний сурсан зүйл нь гэвэл болор шилэн эдлэлийн наймаа л байлаа.

Нэгэн цагт араб худалдаачид, Англи, Франц хайгуулчид, Герман цэргүүд гээд л мөнгөтэй олон хүмүүс түүний дэлгүүрийг мэддэг, үйлчлүүлдэг байв. Тэр үед болор эдлэлийн наймаа ашигтай ч байж тэрээр хэрхэн баяжиж нас ахих тусмаа үзэсгэлэнт бүсгүйчүүдтэй ханилан сууна даа хэмээн боддог байлаа. Гэвч он цаг улирах тусам Танжиер ч мөн өөрчлөгдсөн юм. Ойролцоох хот Сейта, Танжиераас хурдан хөгжин тэлснээр худалдаа наймааны орлого муудсан билээ. Хөршүүд нь нүүн одоод одоо толгодын орой дээр л хэдэн дэлгүүр үлджээ. Тэгээд хэн ч гэсэн цөөхөн хэдэн дэлгүүрээр орохын тулд толгод руу өгсөхийг хүсэхгүй шүү дээ. Гэвч болорын худалдаачинд сонголт байсангүй. Гучин жилийн туршид болор эдлэлийн наймаа эрхэлсэн түүнд одоо өөр зүйл хийхэд хэтэрхий оройтсон байлаа.

Тэр өглөөжингөө гудамжаар хааяа нэг алхах хүмүүсийг ажиглан өнгөрөөлөө. Худалдаачин олон жилийн туршид үүнийг хийж байгаа бөгөөд хэн хэдийд явж өнгөрөхийг андалгүй мэддэг билээ. Гэвч үдийн цайны өмнөхөн нэгэн хүү түүний дэлгүүрийн үүдэнд ирэв. Хүүгийн хувцаслалт хэвийн байсан ч туршлагатай худалдаачин хүүг хараад л юм худалдан авах зоосгүй гэдгийг нь мэдэрч байв. Гэсэн ч худалдаачин хүүг явж өнгөртөл цайндаа орохоо хэдэн хормоор хойшлуулахаар шийдлээ.

13-р хэсэг

Хаалганд өлгөсөн самбар дээр дэлгүүрт хэд хэдэн хэлээр ярилцаж болохыг илтгэсэн байх ажээ. Хүү лангууны цаана нэгэн хүн байхыг харлаа.

“Хэрвээ таныг хүсвэл тэр цонхон дээр байгаа шилэн аягануудыг цэвэрлэж өгье,” гэж хүү хэллээ. “Тэдний одоо харагдаж байгаа байдлаар хэн ч тэднийг худалдаж авахыг хүсэхгүй болов уу.”

Худалдаачин хариу хэлэлгүй хүү рүү харан зогслоо. “Оронд нь та надад жаахан идэх юм өгөхгүй юу.” Худалдаачин дуугарахгүй байсаар л, түүнийг шийдвэр гаргахаар тээнэгэлзэж байгааг хүү мэдэрч байв. Түүний хүүдийд хүрэм нь байсан бөгөөд энэ цөлд түүнд хүрэм нь хэрэг болохгүй л болов уу. Хүрмээ гаргаж ирээд хүү шилэн аягануудыг цэвэрлэж эхэллээ.

Хагас цагийн дараа хүү цонхны дэргэд байсан бүх аягануудыг цэвэрлэж дууссан бөгөөд түүнийг ингэх хооронд хоёр үйлчлүүлэгч дэлгүүрт орж ирэн хэсэг болор эдлэл худалдаж авав. Цэвэрлэж дуусаад хүү худалдаачнаас жаахан идэх зүйл асуулаа.

“За, хооллохоор гарцгаая.” хэмээн худалдаачин хэллээ. Тэр хаалган дээрээ тэмдэг орхиод ойролцоох кафе руу явцгаалаа. Кафед сул байсан ширээнд суумагцаа болор эдлэлийн худалдаачин инээлээ.

“Чи цэвэрлэгээ хийх ч шаардлагагүй байсан шүү дээ,” гэж тэр хэлээд “Коран сударт өлсгөлөн хүнийг хооллохыг сургадаг юм.” “Тэгвэл та надаар яагаад хийлгэсэн юм бэ?” гэж хүү асуулаа. “Яагаад вэ гэвэл болорнууд бохирдсон байсан. Түүнчлэн бид хоёулаа сөрөг бодлуудаас тархиа цэвэрлэх шаардлагатай байлаа.” Тэд хоолоо идэж дууссаны дараагаар худалдаачин хүү рүү хандан “Чамайг миний дэлгүүрт ажиллаач гэж гуйя. Чамайг ажиллаж байх зуур хоёр үйлчлүүлэгч ирсэн энэ бол сайны совин.”

Хүмүүс зөн совингийн талаар их ярих юм гэж хоньчин бодлоо. Гэхдээ тэд үнэндээ юу хэлж байгаагаа мэдэхгүй юмдаа. Яг л би олон жилийн туршид хоньтойгоо үг хэрэглэдэггүй хэлээр ярилцаж байснаа ухаараагүйтэй адилхан. “Чи тэгээд надад ажиллах уу?” гэж худалдаачин асуулаа. “Би танд өнөөдрийг дуустал ажиллая,” гэж хүү хариулаа. “Би бүх л шөнөжингөө, үүр цайтал таны дэлгүүрийн болор эдлэл бүрийг нэг бүрчлэн цэвэрлэж өгье. Хариуд нь надад Египет рүү маргааш хүрэхэд шаардлагатай мөнгө хэрэгтэй байна.”

Худалдаачин инээлээ. “Чи миний дэлгүүрийн болорнуудыг бүтэн жилийн турш цэвэрлэсэн ч зарагдсан болор бүрээс нэлээд сайн хувь хүртсэн ч гэсэн Египет хүрэхэд мөнгө зээлэх л шаардлагатай болно. Эндээс тэнд хүртэл хэдэн мянган километр элсэн цөл байгаа шүү дээ.”

Тэр үед хэсэг зуур чив чимээгүй болж хот тэр чигээрээ нойронд автсан мэт л болов. Захаас сонсогдох шуугиан ч үгүй, наймаачдын хоорондох маргаан ч сонсогдохгүй, цамхаг руу гарч залбирцгаах хүмүүс ч үгүй мэт болов. Итгэл найдвар ч үгүй, адал явдал ч үгүй, настай хаан ч үгүй, Хувийн бахархал ч үгүй, нуугдсан эрдэнэс ч үгүй, Пирамидууд ч үгүй болов. Дэлхий нам гүм болон зогсох мэт болсны учир нь гэвэл хүүгийн сүнс чимээгүйд автсанд байлаа. Хүү тэндээ суусан чигээрээ кафений хаалгаар дэмий л ширтэн энэ бүхнийг үүрд төгсгөн

үхчихмээр л санагдаж байлаа. Худалдаачин санаа зовнисон байдлаар хүү рүү харлаа. Өглөөхөн түүний харсан баяр баясал гэнэтхэн алга болчихлоо.

“Би чамд нутагтаа буцаж очиход чинь шаардагдах мөнгө өгч болно, хүү минь,” гэж худалдаачин хэллээ. Хүү дуугарсангүй. Тэр босч, хувцсаа засаад, хүүдийгээ авлаа. “Би танайд ажиллая,” гэж хүү хэллээ. Тэгээд хэсэг чимээгүй болсноо хүү “Надад хэсэг хонь худалдаж авах мөнгө хэрэгтэй байна.” хэмээн нэмж хэллээ.

-***-

Дэд бүлэг:

14 - р хэсэг

Хүү болор эдлэлийн худалдаачныд бараг сарын туршид ажиллахад энэ ажил түүнд тийм ч тохиромжтой бишийг мэдэрч байлаа. Худалдаачин лангууныхаа араас хүүг шилэн эдлэлүүдтэй болгоомжтой харьцахыг, юуг ч хагалж үл болохыг сануулан өдөржингөө үглэдэг байв. Гэхдээ худалдаачин хөгшин үглээ ч гэсэн хүүд сайн ханддаг, зарагдсан бараа бүрээс хүү боломжийн хувь хүртэж, хэсэг мөнгө хадгалаад амжсан тул худалдаачинтай хамт ажилласаар байлаа.

Тэр өглөө хүү тооцоо хийж үзтэл хэрвээ тэр энэ янзаараа ажиллаад байх юм бол сүрэг хонь авахын тулд бүтэн жил шаардагдахаар байлаа.

“Би болорнуудаа тавьж харуулах самбар хиймээр байна,” гэж хүү худалдаачинд хэллээ. “Бид түүнийгээ гадна тавибал толгодын доогуур явж байгаа хүмүүсийн анхаарлыг татах болно.”

“Надад өмнө нь тийм зүйл байгаагүй,” хэмээн худалдаачин хариуллаа. “Хүмүүс хажуугаар нь өнгөрөхдөө үүнийг дайраад болорнууд хагарчихна шүү дээ.”

“Тэгэхдээ л би хонио талаар бэлчээхэд могой дайралдах юм бол зарим нь үхэж ч магадгүй байдаг. Гэвч энэ нь хоньчин хонь хоёрын амьдрах жам юм даа.”

Худалдаачин гурван ширхэг болор сав асуусан үйлчлүүлэгч рүү эргэлээ. Түүний бараа өмнө нь байгаагүйгээр зарагдаж байлаа ... бараг л энэ гудамж Танжиерийн гол гудамжуудын нэг байсан үед нь буцаад очсон шиг л байлаа.

“Наймаа үнэхээр сайжирч байна,” гэж үйлчлүүлэгч явсны дараагаар худалдаачин хүүд хэллээ. “Би илүү сайн байна, удалгүй чи хонинууд руугаа буцах боломжтой болно. Юунд нь амьдралаас илүүг хүсэх билээ?”

“Яагаад вэ гэвэл бид зөн совинд хариулах хэрэгтэй,” гэж хүү юм бодолгүйгээр шууд хариулснаа, хэлсэн зүйлдээ жаахан харамслаа, учир нь худалдаачин настай хаантантай уулзаж байгаагүй шүү дээ. “Энэ бол тус болохын зарчим буюу Эхлэгчдийн аз гэж нэрлэгддэг. Яагаад вэ гэвэл амьдрал чамайг Хувийн бахархалдаа хүрэхийг хүсч байдаг,” гэж настай хаантан хэлсэн билээ.

Гэсэн ч худалдаачин хүүгийн хэлснийг ойлгосон байв. Хүү санамсаргүйгээр дэлгүүрт ирсэн нь зөн совин байсан түүнээс хойш түүний орлогын хайрцагт мөнгө цутган орох болсон тул хүүг хөлсөлсөндөө огтхон ч харамсах зүйл байсангүй. Хүү хүртэх ёстойгоосоо ч ихийг олж байсан, учир нь худалдаачин бараа ингэж ихээр зарагдана гэж бодоогүй байсан тул хүүд өндөр хувь оноосон билээ. Хүү удахгүй хонинуудаа худалдан авах боломжтой болно гэж худалдаачин тооцож байлаа.

“Чи яагаад Пирамидууд руу очихыг хүссэн юм бэ?” гэж тэрээр самбарын талаар ярилцахаас зайлсхийн асуулаа.

“Яагаад гэвэл би тэдний талаар үргэлж сонсдог байсан,” гэж хүү мөрөөдлийнхөө талаар огтхон ч хэлсэнгүйгээр хариуллаа. Эрдэнэс одоо түүний хувьд юу ч биш харамсалтай дурсамж болон үлдсэн бөгөөд хүү түүний талаар бодохоос зайлсхийхийг хичээж байлаа.

“Би зөвхөн Пирамидуудыг үзэхийн тулд цөлийг гатлахыг хүсдэг хүнийг энэ хавиар л мэдэхгүй юм,” гэж худалдаачин хэлэв. “Тэд чинь зүгээр л овоолгоотой чулуунууд шүү дээ. Хүсвэл чи ч гэсэн нэгийг хашаандаа босгож болно.”

“Та ерөөсөө аялах мөрөөдөлгүй байх л даа,” гэж хүү хэлэнгээ дэлгүүрт орж ирсэн үйлчлүүлэгчид үйлчлэхээр явлаа.

Хоёр өдрийн дараа худалдаачин хүүтэй самбарын талаар ярилцав. “Би өөрчлөлтөнд тийм ч дуртай биш,” гэж тэр хэллээ. “Чи бид хоёр баян худалдаачин Хасантай адилгүй. Хэрвээ тэр худалдан авалтын алдаа хийлээ гэхэд түүнд тэгж их нөлөөлөхгүй. Харин чи бид хоёрын хувьд өөрсдийн алдаатайгаа амьдрах л болно шүү дээ.” Энэ ч үнэхээр үнэндээ гэж хүү харуусан бодлоо.

“Яагаад чи бид самбар хийж тавих хэрэгтэй гэж бодож байна?”

“Би хонинуудаа хурдан буцаан авахыг хүсч байна. Аз бидний талд байхад түүнийг бидэнд туслахад нь амар болгох зүйлсийг хийх шаардлагатай. Үүнийг тус болохын зарчим буюу Эхлэгчдийн аз гэдэг.”

Худалдаачин хэдэн хором чимээгүй болов. Тэгснээ түүний хэлсэн нь, “Коран судрыг бүтээсэн Зөнч, бидэнд амьдралдаа дагаж мөрдөх таван даалгаврыг үлдээсэн юм. Хамгийн чухал нь цор ганц үнэн Бурханд итгэх юм. Бусад нь гэвэл өдөрт таван удаа залбирах, Рамаданын үеэр мацаг барих мөн ядууст өршөөлтэй хандах зэрэг болно.” Тэр яриагаа зогсоолоо. Зөнчийн талаар ярьж байхдаа түүний нүдэнд нулимс цийлэгнэж байв. Худалдаачин үнэнч сүсэгтэн бөгөөд хичнээн сэтгэл тавгүйцэх зүйл боллоо ч гэсэн Мусульман шашинтны хуулийн дагуу амьдрахыг хүсдэг нэгэн бөлгөө.

“Тавдугаар үүрэг нь юу юм бэ?” хэмээн хүү асуулаа.

“Хоёр өдрийн өмнө чи намайг хэзээ ч аялахыг хүсч байгаагүй гэж хэлсэн,” хэмээн худалдаачин хариуллаа. “Мусульман шашинтан бүрийн тавдугаар үүрэг бол мөргөл. Бид амьдралдаа ядаж нэг удаа гэгээн Мекка хотод очих ёстой юм. Мекка бол Пирамидуудаас ч маш хол. Залуу байхдаа миний хүсч байсан зүйл гэвэл энэ дэлгүүрийг ажиллуулж эхлэхэд шаардлагатай мөнгийг хураах л байв. Би тэр үед нэг л өдөр би баян болоод Мекка руу явах болно гэж боддог байлаа. Би нэлээд мөнгө цуглуулж эхэлсэн ч дэлгүүрээ найдан үлдээх хүн олж чаддаггүй байлаа учир нь болор бол маш үнэтэй эмзэг эд шүү дээ. Тэр үед Мекка руу аялж байгаа хүмүүс миний дэлгүүрээр үргэлж дайран гарцгаадаг байлаа. Тэдний зарим нь жингийн цуваа зарцуудаа дагуулсан баян мөргөлчид байсан ч ихэнх нь надаас ядуу хүмүүс байдаг байв. “Бүх л мөргөлчид үүнийг хийж байгаадаа аз жаргалтай байсан. Тэд гэрийнхээ үүдэнд мөргөлд явсан гэсэн тэмдэг үлдээцгээдэг. Тэдний нэг болох гутал сэлбэн оёж амьдралаа

зогоодог ядуу эр хэлэхдээ тэрээр бараг бүтэн жил цөлөөр аялсан боловч Танжиерийн гудамжаар арьс шир хайн алхахдаа илүү ядарлаа гэж билээ.”

“Та тэгвэл яагаад Мекка руу даруйхан явахгүй байгаа юм бэ?” гэж хүү асуулаа. “Яагаад вэ гэвэл Меккагийн тухай бодол намайг амьд байлгаж байгаа юм. Энэ нь намайг тавиур дээр байх чимээгүй болоруудтай, үдийн хоолоо тэр аймшгийн цайны газарт барих ёстой нэгэн хэвийн өдрүүдийг өнгөрөөхөд тусалдаг юм. Хэрвээ миний мөрөөдөл биелэгдэх юм бол надад цаашид амьдрах шалтгаангүй болно гэдгээс би айж байна. Чи өөрийнхөө хонинууд болон Пирамидуудын тухай мөрөөдөж байна, гэхдээ чи бол надаас ялгаатай учир нь чи мөрөөдлөө биелүүлэхийг хүсдэг. Би бол Меккагийн тухай зөвхөн мөрөөдөхийг л хүсдэг. Би аль хэдийн мянган удаа цөлийг гаталж байгаагаар, Гэгээн хадны талбайд очиж байгаагаар түүнээс адис авахаасаа өмнө долоон удаа тойрч байгаагаар өөрийгөө төсөөлсөн. Миний хажууд болон өмнө суун залбирах хүмүүсийг төсөөлж тэдэнтэй ярилцах яриагаа ч мэдэрсэн. Гэхдээ энэ нь зүгээр л нэг сэтгэл гансрам үйл болох вий гэдгээс би айж байгаа учраас үүний талаар зөвхөн мөрөөдөхийг л илүүд үзэх болсон юм даа.”

Тэр өдөр худалдаачин хүүд самбар барих зөвшөөрөл өглөө. Хүн болгон өөрийн мөрөөдлөө биелүүлэхийг адилхнаар хардаггүй ажээ.

-***-

15 - р хэсэг

Хоёр сар өнгөрөхөд нөгөө самбар маш олон үйлчлүүлэгчдийг авчирлаа. Хүү хэрвээ ахиад зургаан сар ажиллахад тэр буцаад Испани руугаа жаран хоньтой буцахаас гадна ахиад ч жарыг авч болох юм байна гэж тооцооллоо. Ганцхан жил хүрэхгүй хугацаанд тэрээр сүргээ хоёр дахин өсгөөд зогсохгүй арабуудтай наймаа хийх хэмжээнд хүрсэн яагаад вэ гэвэл тэр одоо тэдний хачин хэлээр ярьж чадах болсон билээ.

Захын талбайд угтсан тэр нэгэн өглөөнөөс хойш тэрээр Урим Түмим хоёроо ахиж хэрэглэсэнгүй учир нь түүний хувьд Египет худалдаачинд Мекка ямар байдаг билээ яг түүн шиг л алс холын мөрөөдөл болон хоцорсон билээ. Ямартай ч гэлээ хүү өөрийн ажилдаа сэтгэл хангалуун болсон бөгөөд Тарифадаа ялагчийн төрхтэйгээр буцаж байгаа талаар л өдөр бүр бодон өнгөрүүлэх болсон билээ. “Юу хүсч байгаагаа чи үргэлж мэдэх ёстой,” гэж настай хаантан хэлсэн. Хүү энэ талаар мэдээд зогсохгүй одоо түүнийхээ төлөө ажиллаж байгаа. Магадгүй энэ хачин газарт ирээд хулгайчтай уулзан ганц ч зоос гарздалгүйгээр сүргээ хоёр дахин өсгөх нь түүний нөгөө баялаг байсан ч юм билүү.

Тэр өөрөөрөө бахархаж байв. Тэрээр нэлээд чухал зүйлсийг сурлаа жишээ нь тэр одоо болор эдлэлтэй яаж харьцахаа мэддэг болсон мөн үггүйгээр ярилцах хэлийг бас зөн совингийн талаар мэддэг боллоо. Нэг өдөр тэрээр толгодын орой дээр байсан нэгэн эр ингэж их өгссөний дараагаар цангаага тайлчихаар аятайхан газар байхгүй байгаа талаар гоморхож байгааг анзаарлаа. Хүү зөн совингоо тайлахад суралцсан тул худалдаачинтай ярилцлаа.

“Толгодын орой дээр гарч ирсэн хүмүүст цай зарцгаая.”

“Энэ хавиар цай зардаг газрууд зөндөө л байна шүү дээ,” гэж худалдаачин хэллээ.

“Гэхдээ бид цайг болор аяганд зарж болно шүү дээ. Хүмүүс цайг уунгаа болор аягыг авахыг хүсэх болно. Гоо үзэсгэлэн бол хүний агуу өдөөгч гэж хэлэлцэхийг би сонссон билээ.”

Худалдаачин хариу хэлсэнгүй гэхдээ орой залбирлаа үйлдэж дэлгүүрээ хаасны дараагаар тэрээр хүүг арабуудын хэрэглэдэг хачин гаанснаасаа хамтдаа тамхилахыг урилаа. “Чиний хайж байгаа зүйл ер нь юу юм бэ?” гэж худалдаачин асуулаа. “Би танд хэлсэн шүү дээ. Би хонио хурдан буцааж авах хэрэгтэй байна түүний тулд надад мөнгө хэрэгтэй.” Худалдаачин гаансандаа нүүрс нэмж хийгээд гүнзгийгээр амьсгаллаа. “Би энэ дэлгүүрийг гучин жилийн туршид ажилууллаа. Би сайн болон муу болорыг ялгаж чадна ер нь болорын талаарх бүх л зүйлсийг мэднэ. Би тэдний хэмжээг ямар шинж чанартайг мэднэ. Хэрвээ би болор аяганд цай зараад эхэлвэл дэлгүүр маань өргөжих болно. Тэгэхээр би өөрийнхөө амьдралын хэвшлийг өөрчлөхөд хүрнэ.

“Тэгвэл танд сайн биш гэж үү?”

“Би юм бүгдийг байгаагаараа байхад нь дасчихсан хүн. Чамайг ирэхээс өмнө би хэдийгээр миний найзууд нүүн одоод зарим нь дампуурч зарим нь өмнөхөөсөө ч илүүтэйгээр хөлжицгөөсөн ч гэлээ ямар ч их хугацааг нэг газраа байж байгаад үрсэндээ харамсаж байлаа. Энэ бодол намайг үнэхээр бухимдуулж байв. Одоо ингээд харахад энэ бүхэн тийм ч муу биш юм байна. Дэлгүүр маань үргэлж миний мөрөөдөж байсан хэмжээнд хүрлээ. Би юуг ч өөрчлөхийг хүсэхгүй байна учир нь би өөрчлөлттэй хэрхэн зохицохоо мэдэхгүй байна. Би өөрийнхөө байгаа байдалд л дассан хүн.”

Хүү юу гэж хэлэхээ ч мэдэхгүй байлаа. Настай эр үргэлжлүүлээ, “Чи надад үнэхээр их буянтай хүн. Өнөөдөр би өмнө нь харж байгаагүй зүйлсээ ухаарлаа. Анзаараагүй өнгөрсөн хишиг буян бүхэн хараал болдог юм байна. Би амьдралаас илүү зүйл хүсэхгүй. Гэвч чи намайг миний өмнө нь мэдэрч байгаагүй хэмжээнээс илүүтэйгээр баялгийг мэдрэхэд хүчлэж байна. Одоо би үүнийг ажигламагцаа миний боломжууд ямар өргөн байсныг мэдрэмэгц чамайг ирэхээс өмнөх үеэсээ ч зовлонт байдалд орж байна. Яагаад вэ гэвэл би гүйцэтгэх ёстой байсан зүйлсээ мэдэрсэн ч гэлээ тэднийгээ хэрэгжүүлэхийг хүсдэггүй билээ.”

Би ч Тарифад байсан талхчинд юу ч хэлээгүй нь болж дээ хэмээн хүү дотроо бодлоо. Нар шингэж байх зуур тэд гаансаа үргэлжлүүлэн татацгаалаа. Тэр хоёр арабаар ярилцах бөгөөд хүү үүндээ ихэд сэтгэл хангалуун байлаа. Хүүд хонинууд нь түүнд дэлхий ертөнцийн тухай бүх зүйлийг зааж өгч чадна гэсэн бодол байсан үе бий билээ. Гэхдээ хонинууд хэзээ ч түүнд арабаар ярихыг зааж өгч чадахгүй. Хүү настай худалдаачны тухай бодолхийлэх зуураа ер нь хонинууд зааж чадахгүй зөндөө зүйлс хорвоо дэлхийд байх ёстой хэмээн бодож байлаа. Хонинуудын хайж байгаа зүйлс гэвэл өвс ус хоёр л юмдаа. Магадгүй энэ нь тэд надад заасан биш харин би тэднээс суралцаж байсан юм байна.

“Мактүб,” хэмээн худалдаачин эцэст нь хэлэв.

“Юу гэсэн утгатай үг вэ?”

“Хэрвээ чи араб хүн болон төрсөн бол ойлгомжтой байх байлаа,” хэмээн тэр хэллээ.

“Гэхдээ чиний хэлээр орчуулвал энэ нь ‘Энэ үйл бичигдсэн.’” гэсэн утгатай юм. Тэгээд тэр гаанстай тамхиа угзруулан татсанаа хүүд болор аяганд цай зарах зөвшөөрөл өглөө. Заримдаа мөрнийг эргүүлэн урсгах аргагүй болой.

16 - р хэсэг

Хүмүүс толгодын орой өөд алхацгаан оройд хүрэх үедээ ихэд ядарцгаах ажээ. Гэвч тэнд нэгэн болор эдлэлийн дэлгүүр алжаал тайлах сэнгэнэсэн сайхан цай зарж байгааг харах бөгөөд тэд үзэсгэлэнт сайхан болор аягануудад хийсэн цайг уухаар очигцоох бөлгөө.

“Эхнэр минь хэзээ ч үүнийг бодож олохгүй байсан,” хэмээн нэгэн эр хэдэн болор худалдаж авахдаа хэллээ. Тэрээр үдэш зочид урьсан агаад тэд тэрхүү шилэн эдлэлийн үзэсгэлэнд гайхашрах болно. Өөр нэгэн эр цайг болор аяганд уухад илүү амттай байдаг учир нь гэвэл тансаг амт нь хадгалагддаг гэж хэллээ. Гуравдахь эр Дорнын ард түмэнд цайг болор аяганд уудаг уламжлал байсан яагаад вэ гэвэл тэдгээр нь ид шидийн хүчтэй гэгцгээдэг хэмээх ажээ.

Энэхүү мэдээ тархаад удаагүй байтал маш олон хүн хэтэрхий хуучирсан байсан худалдааны орчинд шинэ зүйлсийг дэлгэрүүлж буй дэлгүүрийг үзэхээр толгодын орой руу мацацгааж эхэлсэн билээ. Бусад дэлгүүрүүд мөн л адил цайг болор аяганд хийн үйлчилгээж эхэлсэн ч гэлээ тэд толгодын орой дээр байрладаггүй учраас маш бага орлоготой байлаа.

Эцэст нь худалдаачин хоёр ажилтан нэмж хөлслөлөө. Тэр болор эдлэлийнхээ зэрэгцээгээр асар их хэмжээний цайг татан авч эхэлсэн бөгөөд түүний дэлгүүр нь шинэ зүйлсийг эрэн хайх хүмүүсийн дуртай газар болжээ. Мөн үүний хажуугаар цаг хугацаа өнгөрсөөр л байлаа.

17 - р хэсэг

Хүү үүр цайхаас өмнөхөн сэрлээ. Тэрээр Африк тивд анхлан хөл тавьснаас хойш арван нэгэн сар есөн өдөр өнгөрчээ. Тэрээр энэ өдөрт зориулан тусгайлан худалдаж авсан араб хувцас болох цагаан дээл өмсчээ. Хүү толгойныхоо боолтыг боогоод тэмээний арьсаар хийсэн цагиргаар бэхэллээ. Шинэ сандалаа өмсөөд тэрээр шатаар чимээгүйхэн уруудлаа.

Хот нойрсож байв. Тэрээр өөртөө хэсэг хачиртай талх бэлтгээд болор аяганаас халуун цай уулаа. Тэгээд тэр нар туссан үүдний хэсэгт суугад гаансаа татлаа. Тэр юуг ч бодолгүйгээр чимээгүйхэн тамхиа соронгоо цөлийн үнэрийг авчирсан салхины чимээг сонсон байлаа. Тамхиа татаж дуусаад тэрээр халаасаа уудлан гаргаж ирсэн зүйлээ харан хэсэг суулаа. Энэ нь боодол мөнгө байлаа. Зуун хорин хонь, буцах тасалбар болон Африкаас нутагтаа бараа оруулах зөвшөөрөл худалдаж авахад хангалттай мөнгө байв.

Хүү худалдаачныг сэрэн дэлгүүрээ нээхийг тэвчээртэйгээр хүлээлээ. Тэгээд тэр хоёр цай уухаар явлаа. “Өнөөдөр би явъя даа,” хэмээн хүү хэлэв. “Би хонио

худалдаж авахад хүрэлцэхүйц мөнгө цуглууллаа. Харин та Мекка ороход шаардлагатай мөнгөтэй болсон.”

Настай худалдаачин юу ч хэлсэнгүй. “Та надад адислалаа хүртээхгүй юу?” гэж хүү асуулаа. “Та надад тусалсан.” Худалдаачин цайгаа үргэлжлүүлэн бэлдэж хүүд юм хэлсэнгүй. Тэгснээ тэр хүү рүү эргэн харлаа. “Би чамаар бахархаж байна,” гэж тэр хэллээ. “Чи миний болор эдлэлийн дэлгүүрт шинэ мэдрэмж авчирсан. Гэхдээ чи намайг Мекка руу явахгүй гэдгийг мэднэ. Үүнтэй адилханаар чи ч гэсэн хонинуудаа худалдаж авахаар явахгүй.”

“Хэн танд тэгэж хэлээ вэ?” хэмээн хүү гайхан асуулаа.

“Мактүб,” хэмээн настай худалдаачин хэллээ. Тэгээд тэр хүүд адислалаа хүртээв.

-***-

18 - р хэсэг

Хүү өрөө рүүгээ ороод өөрийнхөө зүйлсийг авч явахад бэлдлээ. Түүний зүйлс нь гурван богц болов. Гарах зуураа тэрээр түүний хуучин хоньчин байх үеийнх нь үүргэвч өрөөний буланд байгааг харлаа. Үүргэвч нь бөөгнөрсөн зүйлсийн дунд орсон байх бөгөөд хүү түүний талаар бодолгүй удаан хугацааг өнгөрөөсөн байлаа.

Тэрээр үүргэвчнээсээ хүрмээ гарган гудамжинд тааралдах хэн нэгэнд өгье дөө хэмээн бодох зуур хоёр чулуу шалан дээр уналаа. Урим болон Түмим. Тэдгээр нь хүүд настай хаантныг бодогдуулсан бөгөөд түүний тухай эргэцүүлэн бодох болсноос хойш хир их хугацаа өнгөрснийг нь санагдууллаа. Бараг бүтэн жилийн туршид тэрээр зогсолтгүйгээр ажиллаж Испанидаа буцаад бахархалтайгаар харих хэмжээний мөнгийг хуримтлуулахыг л бодож байсан билээ. “Хэзээ ч мөрөөдөхөө зогсоож болохгүй,” гэж настай хаантан хэлсэн, “Зөн совинг дага.” Хүү Урим болон Түмимийг тонгойн авахад настай хаантан дэргэд байгаа мэт нөгөө хачирхалтай мэдрэмж дахин мэдрэгдлээ. Тэрээр бүтэн жилийн турш махран ажилласан бөгөөд зөн совин түүнд одоо явах цаг болсон гэдгийг хэлсэн билээ. Би өмнө нь юу хийж байсан түүн рүүгээ л буцаж байна даа гэж хүү бодлоо. Хонинууд түүнд арабаар ярихыг зааж өгөөгүй ч гэсэн. Гэвч хонинууд түүнд илүү чухал зүйлийг, ертөнц дээрх юм бүхэн ойлгодог хэл байдаг гэдгийг, хүүг энэ дэлгүүрт ажиллах хугацаанд байгаа зүйлсийг сайжруулахаар оролдож байхдаа ашигласан тэр хэлийг заасан байлаа. Энэ бол бадрангүй өөдрөг сэтгэлийн, хайраа шингээн, зорилготойгоор гүйцэтгэсэн зүйлсийн болон хүсч итгэж явдаг зүйлсийнхээ эрлийн нэгэн хэсэг болгон хийх хэл билээ. Танжиер харийн этгээд хот байхаа больж хүү энэхүү газрыг эзэлсэнтэйгээ адилаар дэлхийг ч эзэлж болохоор санагдаж байлаа.

“Хэрвээ чи ямар нэг зүйлсийг хүсвэл бүх л ертөнц чамайг түүндээ хүрэхэд чинь тусалж байдаг,” хэмээн настай хаантан хэлсэн билээ. Гэвч настай хаантан дээрэмдүүлэх талаар, эцэс төгсгөлгүй үргэлжлэх цөлийн талаар, эсвэл өөрсдийн мөрөөдлөө мэддэг ч гэсэн түүнийгээ биелүүлэхийг хүсдэггүй хүмүүсийн талаар огтхон ч дурссангүй. Настай хаантан Пирамидууд бол ердөө л овоолгоотой чулуунууд гэх юмуу эсвэл хэн ч гэсэн түүнийг хашаандаа барьчихаж болно хэмээн хэлээгүй билээ. Түүнчлэн тэрээр өмнө байснаасаа

илүү их сүрэг худалдан авах мөнгөтэй болвол түүнийг худалдаж аваарай гэж хэлээгүй. Хүү үүргэвчээ аван чулуунуудыг өөрийнхөө бусад зүйлстэй хамт хийлээ. Тэр шатаар уруудангаа худалдаачин нэгэн гадаад хосд үйлчлэн байгааг мөн өөр хоёр үйлчлүүлэгч дэлгүүрт ирэн болор аяганд цай ууж байгааг харлаа. Энэ өглөө бусад үеүдийнхээс илүү их хөл хөдөлгөөнтэй байлаа.

Түүний зогсож байсан газраас тэрээр анхны удаа худалдаачны үс нь нөгөө настай хаантны үстэй маш адилхан байгааг анзаарав. Тэрээр Танжиерт ирсэн анхны өдрөө, хаашаа ч явах газаргүй идэх зүйл ч үгүй байхдаа тааралдсан чихрийн худалдаачны инээмсэглэлийг эргэн санатал тэр бас л настай хаантны инээмсэглэлтэй адилхан байсан санагдлаа. Энэ нь бараг л настай хаантан энд байж өөрийн тэмдгээ үлдээсэн мэт байна даа гэж хүү бодлоо. Гэтэл эдгээр хүмүүсийн аль нь ч гэсэн настай хаантантай уулзаагүй байдаг. Нөгөө талаас хаантан Хувийн бахархалаа биелүүлэхээр хичээж буй хүмүүст туслахаар дэргэд нь илэрч байдаг хэмээж байсан билээ. Хүү болрын худалдаачинд баяртай гэж хэлэлгүйгээр явлаа. Тэр энд байгаа настай хүмүүстэй хамтдаа уйлахыг хүсээгүй билээ. Тэр энэхүү газрыг энд сурсан бүхий л сайн зүйлсээ санагалзах болно. Тэр өөртөө илүү итгэлтэй байлаа, дэлхий ертөнцийг ч захирч чадахаар санагдаж байлаа. “Гэвч би өөрийн мэддэг тал руугаа ахиад л сүргээ хариулахаар буцах гэж байна.” Тэр өөртөө үүнийг хэлсэн боловч энэхүү шийдвэртээ сэтгэл хангалуун биш байлаа. Тэр бүтэн жилийн туршид мөрөөдлөө биелүүлэхийн тулд ажилласан боловч тэрхүү мөрөөдөл нь хором хормоор чухал биш болсоор байв. Магадгүй энэ нь түүний мөрөөдөл биш байсан ч юм бил үү. Ер нь хэн мэдэхэв дээ ... магадгүй болрын худалдаачин шиг Мекка руу хэзээ ч явалгүйгээр түүнийгээ хийхийг хүсэн амьдрах нь дээр ч юмуу хэмээн тэр бодоод ахин өөрийгөө ятгахаар хичээв. Гэвч тэр Урим Түмимээ гартаа атгахад тэдгээр нь түүнд настай хаантны хүсэл болон хүчийг дамжуулж байлаа.

Санамсаргүйгээр аль эсвэл зөн совингийн улмаас ч юмуу гэж хүү бодонгоо энд ирсэн анхны өдрөө орсон бааранд орлоо. Хулгайч тэнд байсангүй харин эзэн нь түүнд аягатай цай авчирлаа. Би хэзээ ч гэсэн буцаад хоньчин болж чадна хэмээн хүү бодлоо. Би хонинуудыг хэрхэн арчлахыг сурсан би түүнийг хэрхэн хийхийг мартахгүй. Гэвч магадгүй надад Египетэд байх Пирамидууд руу очих боломж ахин олдохгүй ч байж болох юм. Алтан цээживч өмссөн настай хаантан миний өнгөрсөн амьдралыг мэдэж байсан. Тэр үнэндээ л хаан байсан, цэцэн хаантан байсан. Андалуизагийн толгодууд ердөө л хоёрхон цагийн зайтай боловч Пирамидууд болон хүүгийн дунд битүү элсэн цөл байгаа билээ. Хүүд үүнийг нөгөө талаас нь бодох мэдрэмж төрлөө, тэр өөрийнхөө баялагт хоёр цагаар ойртсон байх үед үнэндээ тэрхүү хоёр цаг нь бүхий л бүтэн жил болон сунгагдсан билээ. Би яагаад сүрэг рүүгээ буцах гээд байгаагаа ойлгож байна хэмээн хүү бодлоо. Би хонинуудыг ойлгодог тэд бол асуудал биш түүнчлэн тэд сайн найзууд болж чадна. Нөгөөтэйгүүр би элсэн цөл миний нөхөр болж чадах эсэхийг мэдээгүй ба тэрхүү цөлд би баялгаа хайх ёстой байдаг. Хэрвээ би олж чадахгүй бол хэзээ ч гэсэн гэртээ хариж болно. Эцсийн эцэст хангалттай мөнгө бас шаардагдах цаг зав байна яагаад болохгүй гэж?

Хүү гэнэтхэн аз жаргалаар дүүрлээ. Тэр хэзээ ч гэсэн буцаад хоньчин болж чадах юм байна. Мөн болрын худалдаачин ч болж чадна. Магадгүй дэлхий өөр нуугдмал эрдэнэстэй гэвч хүү мөрөөдөлтэй байснаараа хаантантай уулзсан байх нь. Энэ нь энгийн хүн бүхэнд тохиолдоод байхгүй байх. Тэрээр баарнаас

гарахдаа төлөвлөгөө хийж байлаа. Хүү болрын худалдаачны нэгэн бараа нийлүүлэгч нь цөлийг гатлан ирэх жингийн цуваагаар болроо авчирдагийг саналаа. Урим болон Түмим гартаа атгангаа тэдгээр хоёр чулууны хүчээр тэр ахин өөрийнхөө баялгийн замдаа орлоо. "Би Хувийн бахархалаа биелүүлэхийг хүсч буй хүн бүхний дэргэд байдаг," хэмээн настай хаантан түүнд хэлсэн билээ.

Ер нь тэрхүү бараа нийлүүлэгчийн агуулахаар оронгоо Пирамидууд үнэхээр тийм хол байдаг эсэхийг мэдэхэд юу илүүдэхэв дээ?

19 - р хэсэг

Хөлс, тоос, мал амьтны үнэр шингэсэн хагас агуулах, хагас саравчирхуу байгууламж доторх вандан сандал дээр нэгэн англи эр сууж байлаа. Би хэзээ ч ийм газар ирчихнэ гэж төсөөлж байсангүй хэмээн тэрээр хувилахуйн ухааны сэтгүүлийн хуудсуудыг эргүүлэх зуураа бодлоо. Их сургуульд арван жил сурсаны дараа саравчинд сууж байнаа гэж. Гэвч тэр урагшлах шаардлагатай байлаа. Тэрээр зөн совинд итгэж байсан юм. Түүний бүхий л амьдрал, бүхий л сурсан зүйлс нь ертөнцийн цор ганц үнэн хэлийг олоход чиглэгдсэн билээ.

Эхлээд тэрээр Эсперанто хэл үзэн дараагаар нь дэлхийн шашинуудыг судалсан бөгөөд одоо алхими судлаж байгаа билээ. Тэрээр хэрхэн Эсперантоогоор ярихыг мэднэ, дэлхийн бүхий л томоохон шашинуудыг сайн ойлгосон ч гэсэн одоохондоо алхимич болж чадаагүй байгаа.

Тэрээр хэцүү чухал асуултуудын цаадах учрыг илрүүлсэн ч түүний судалгаа нь түүнийг цаашаа явж чадахааргүй мэт санагдах хэмжээнд аваачсан билээ. Тэр алхимич нартай холбоо тогтоохоор цөхрөлөө бартал оролдож байсан юм. Алхимичид маш этгээд, зөвхөн өөрийнхөө төлөө бодоцгоодог улсууд байдаг тул тэд түүнд туслахаас бараг л үргэлж татгалзацгааж байлаа. Магадгүй тэд Мастер бүтээл болох Философичийн чулууны нууцыг тайлж чадаагүй учраас сурсан мэдсэнээ өөрсдөдөө хадгалцгаадаг ч юм бил үү хэн мэдэх билээ.

Тэрээр аавынхаа үлдээсэн баялгийн ихэнхийг Философичийн чулууг хайн үр ашиггүйгээр зарцуулчихсан юм. Тэрээр дэлхийн томоохон номын сангуудад асар их хугацааг зарцуулж алхимийн тухай хамгийн чухал хамгийн ховор гэсэн ботиудыг бүгдийг нь худалдан авсан юм.

Тэдний нэгэн дээрээс олон жилийн өмнө нэгэн алдартай Араб алхимич Европд аялсан тухай уншиж байсан билээ. Түүнд бичигдсэнээр тэрхүү алхимич хоёр зуу гаруй настай бөгөөд Философичийн чулуу болон Мөнхийн усыг нээсэн гэсэн байв. Англи эр тэрхүү түүхэнд үнэхээр шимтэн гайхширч байсан билээ.

Гэхдээ тэрээр энэ нь зөвхөн домог төдий биш гэдгийг зүүдлээ ч үгүй явсан бөгөөд түүний нэг найз нь цөл рүү аялсан археологийн хайгуулаасаа буцаж ирэхдээ нэгэн гайхамшигтай хүч чадал, эрдэм бүхий Араб эрийн талаар ярьж өгсөн юм.

"Тэр Эл-Фаюум баянбүрдэд амьдардаг," хэмээн түүний найз нь хэлсэн билээ. "Хүмүүс түүнийг хоёр зуу насалсан ямар ч металыг алт болгон хувиргах чадвартай." гэж ярилцдаг юм билээ.

Англи эр хөөрсөн сэтгэлээ тогтоон барьж чадахгүй байлаа. Тэрээр төлөвлөсөн бүхий л ажлаа орхиод хамгийн чухал гэсэн номнуудаа аван хөдөлсөн бөгөөд одоо энэхүү тоостой, эвгүй үнэртэй агуулахад байж байгаа нь энэ юм.

Гадаа нь нэгэн асар том жингийн цуваа Сахарын цөлийг гатлахаар бэлтгэж байгаа бөгөөд Эл-Фаюум баянбүрдийг дайран гарах болно.

Тэр хараал идсэн алхимичийг би олох л болно доо гэж англи эр бодлоо. Тэгмэгц амьтны эхүүн үнэр арай ч зөөлрөх мэт санагдав.

Ачаагаа үүрсэн нэгэн залуу араб орж ирэн англи эртэй мэндэллээ.

"Хаа хүрэх нь вэ?" гэж тэр залуу араб асуулаа.

"Би цөл рүү явна," гэж англи эр хариулангаа, уншиж байгаа зүйлдээ анхаарлаа хандуулав.

Тэр юм ярилцахыг хүсэхгүй байлаа. Түүнд шаардлагатай зүйл нь өнгөрсөн хугацаанд сурсан бүхий л зүйлсээ сэргээн санах байсан бөгөөд алхимич түүнийг шалгах нь гарцаагүй юм.

Залуу араб ном аван уншиж эхэллээ. Тэр ном испаниар бичигдсэн байлаа. Энэ ч болж байна шүү гэж англи эр бодов. Тэр арабаас илүү испаниар сайн ярьдаг учир хэрвээ энэ хүү Эл-Фаюум явах юм бол өөр хийх чухал зүйлгүй байхад ашгүй ярилцах хүнтэй болох нь дээ.

20 - р хэсэг

"Мөн ч хачин юм шүү," хэмээн хүү мөнөөх оршуулгын ёслолоор эхэлдэг номоо ахин уншихаар оролдох зуураа хэллээ. "Би хоёр жилийн турш энэ номыг уншихаар хичээсэн боловч эхний энэ хэдэн хуудаснаас цааш хэтэрч байсангүй." Бүр нөгөө анхаарал сарниулдаг хаан байхгүй байсан атал хүү анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байлаа.

Тэр гаргасан шийдвэртээ жаахан эргэлзэж байсан юм. Гэхдээ тэрээр нэг зүйлийг ухаарах чадвартай болсон байв. Шийдвэр гаргана гэдэг бол тохиолдох зүйлсийн зөвхөн эхлэл. Хэн нэгэн хүн шийдвэр гаргахад, үнэн хэрэгтээ асар хүчтэй урсгалд шумбан орж байгаа бөгөөд тэрхүү урсгал нь түүнийг анх шийдвэр гаргаж байхдаа огтхон ч төсөөлж байгаагүй газруудад аваачих болно. Би өөрийхөө баялгийг хайхаар шийдэх үедээ хэзээ ч тэр болор эдлэлийн дэлгүүрт ажиллахад хүрнэ гэж төсөөлж байгаагүй дээ, хэмээн хүү бодлоо. Түүнчлэн энэхүү жингийн цуваатай аялах нь миний шийдвэр ч гэлээ цаашдаа хаа хүрэх нь тайлагдашгүй зүйл юм даа.

Хажууханд нь нөгөө англи эр ном уншиж байлаа. Тэрээр нөхөрсөг бус санагдсан бөгөөд хүүг орж ирэх үед дургуйцсэн янзтай байсан билээ. Магадгүй тэд найз нөхөд болж болох байсан ч англи эр яриаг таслаж орхисон юм. Хүү номоо хаалаа. Тэрээр өөрийгөө англи эртэй адилхан харагдуулж магадгүй зүйл хийхийг хүсэхгүй байгаагаа мэдэрлээ. Тэгээд хүү Урим болон Түмим хоёроо халааснаасаа гаргаж ирээд тоглож эхлэв.

“Урим ба Түмим!”, гэж нөгөө хачин англи эр хашгирлаа. Хоромхон зуурт хүү тэднийгээ буцаан халааслав. “Эднийг зарахгүй ээ” гэж хүү хэллээ.

“Тэд ч угаасаа үнэтэй биш л дээ” гэж англи эр хариуллаа. “Тэд ердөө чулуун талстаар хийгддэг бөгөөд дэлхий дээр сая сая чулуун талст байдаг. Гэхдээ зөвхөн Урим болон Түмимийг ялгадаг хүмүүс л тэдгээрийг танина. Би үнэндээ тэднийг дэлхийн энэ хэсэгт ч хүртэл байдаг гэдгийг мэдсэнгүй.”

“Эдгээрийг надад нэгэн хаантан бэлэглэсэн юм,” гэж хүү хэллээ. Харийн эр хариу хэлсэнгүй харин өөрийн халааснаасаа хүүгийнхтэй адил хоёр чулуу гаргаж ирэв.

“Чи сая хаан гэв үү?” хэмээн тэр асуулаа. “Би бодохдоо чи хаан хүн над шиг хоньчинтой ярилцана гэхэд итгэхгүй байх шиг байна тийм үү,” гэж хүү хэлээд яриагаа зогсоомоор санагдлаа.

“Огтхон ч үгүй. Дэлхий даяараа хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байсан хаантныг хамгийн анх хоньчид л илрүүлэн таниж байсан шүү дээ, тэгэхээр хаадууд хоньчидтой ярилцахад гайхах зүйл юу байхав.” Тэгээд тэр хүүг өөрийнхөө ярьж буй зүйлийг ойлгохгүй байж магадгүй хэмээн болгоомжилсондоо үргэлжлүүлэн “Энэ тухай Библийн сударт гардаг юм. Надад Урим болон Түмимийн талаар зааж өгсөн ном. Эдгээр чулуунууд нь Бурханд зөвшөөрөгдсөн цорын ганц ариуслын хэлбэр. Хутагтнууд тэдгээрийг алтан цээживчиндээ хийн авч явдаг юм.”

Хүү гэнэтхэн тэрхүү агуулахад байгаадаа аз жаргалтай болчихов. “Магадгүй энэ зөн совин ч юм бил үү,” гэж англи эр дуугаа хагас өндөрсгөн хэлэв.

“Зөн совингийн талаар хэн чамд хэлсэн юм бэ?” Хүүгийн сонирхол хугацаа өнгөрөх бүрт нэмэгдэж байлаа.

“Амьдрал дээрх бүхий л зүйл бол зөн совин,” гэж англи эр уншиж байсан сэтгүүлээ хаангаа хэллээ. “Хүн бүхний ойлгодог нэгдсэн хэл байсан бөгөөд гэвч аль хэдийн мартагдсан юм. Би тэрхүү нэгдсэн хэл болон бусад зүйлсийн эрэлд явж байгаа. Тиймдээ ч би энд байна. Би тэрхүү нэгдсэн хэлийг мэддэг хүнийг хайж олох ёстой. Тэр бол Алхимич.”

Тэдний яриаг агуулахын эзэн орж ирэн таслав. “Та хоёр ч азтай юм аа,” гэж тэр бүдүүн араб хэллээ. “Энд нэгэн жингийн цуваа Эл-Фаюумийг зорин өнөөдөр хөдлөх гэж байна.”

“Гэвч би Египет орох гэж байгаа шүү дээ,” гэж хүү хэллээ. “Эл-Фаюум чинь Египетэд,” хэмээн араб эр хэллээ. “Хаашаа янзын араб бэ чи чинь?”

“Энэ ч азын совин шүү,” гэж арабыг гарсны дараагаар англи эр хэллээ. “Хэрвээ би чаддагсан бол аз болон тохиолдлын талаарх үгнүүдээр асар том нэвтэрхий толь бичихсэн. Эдгээр үгнүүдээр тэрхүү нэгдсэн хэл бичигдсэн юм.” Тэгээд тэр хүүд Урим болон Түмимээ атган танилцсаныг зүгээр нэг тохиолдлын хэрэг биш байсан гэж хэлээд хүүгээс мөн алхимичийн эрэлд яваа эсэхийг нь асуулаа.

“Би баялгийн эрэлд явна,” гэж хүү хэлснээ, тэр дороо хэлсэндээ харамслаа. Гэвч англи эр ер тоосон шинжгүй мэт байлаа. “Нэг талаас нь авч үзвэл, би ч мөн ялгаагүй” хэмээн тэр хэллээ.

“Би алхими гэж юу байдгийг нь ч мэдэхгүй” хэмээн хүү агуулахын эзнийг тэднийг гараад ирнэ үү хэмээн дуудах зуур хэллээ.

21-р хэсэг

“Би бол жингийн цувааны ахлагч” хэмээн сахалтай, хар нүдтэй эр хэллээ. “Надтай хамт явах хүмүүсийн амьд явах уу аль эсвэл үрэгдэх үү гэдэг нь надаас хамаарна. Элсэн цөл бол яг хорлогчин эм шиг бөгөөд заримдаа тэр хүмүүсийг галзууруулдаг юм.”

Тэнд барагцаагаар хоёр зуу орчим хүн, дөрвөн зуу орчим амьтан – тэмээ, морь, илжиг болон тахиа гэх мэт цугларсан байв. Цугласан хүмүүсийн дотор эмэгтэйчүүд, хүүхдүүд мөн бүсэндээ сэлэм зүүж, мөрөндөө буу үүрсэн нэлээд хэдэн эр байлаа. Англи эр номоор дүүргэсэн хэд хэдэн хайрцагтай ачаатай байв. Тэр хавьд маш шуугиантай байсан тул жингийн ахлагч хүн бүрт ойлгуулахын тулд дахин давтан ярих шаардлага гарч байв.

“Энд маш олон янз бүрийн хүмүүс цугларсан байгаа, хүн бүр өөрийн шүтдэг Бурхантай билээ. Гэвч би Аллах бурханыг шүтдэг бөгөөд элсэн цөлийг гатлахын тулд боломжтой бүхнийг хийх болно гэдгээ түүний нэрээр ахин тангараглаж байна. Мөн би хүн бүрийг шүтдэг бурхандаа миний тушаал ямар ч байсан хамаагүй дагах болно хэмээн амлахыг хүсч байна. Элсэн цөлд тушаал үл гүйцэтгэвэл тэр нь үхэл гэсэн л үг юм.”

Хүмүүс шуугилдаж эхлэв. Хүн бүр өөрсдийн бурхандаа амлан залбирч байв. Хүү Есүс Христэд андгайлав. Англи эр юу ч хэлсэнгүй. Тэгээд хүмүүсийн залбирах нь ердийн нэг дуугаралт биш удаан үргэлжлэв. Хүмүүс мөн хамгаалуулахаар тэнгэртээ залбирцгаав. Хүмүүс мордоцгоож эхлэв. Хүү болон англи эр тэмээнүүд худалдаж авсан ба эв дүй муутайхнаар мордлоо. Хүү англи эрийн тэмээг хараад өрөвдөж байлаа учир нь маш их ном ачсандаа бөхийсөн байлаа.

“Тохиолдлын зүйл гэж байдаггүй юм,” хэмээн англи эр агуулахад тасалдсан яриагаа үргэлжлүүлэхээр хэлээд “Миний энд байгаа нь нэг найз маань нэгэн араб эрийн талаар ...”

Гэвч жингийн цуваа хөдөлж эхэлсэн тул англи эрийн ярьж байгааг сонсох боломжгүй болов. Хүү түүний тайлбарлах гэсэн зүйлийг мэдэж байлаа, нэг зүйлийг нөгөөтэй холбосон тэрхүү хачирхалтай гинжин холбооны тухай, түүнийг хоньчин болгоход хөтөлсөн бас нөгөө давтагдсан зүүдийг зүүдлүүлсэн, Африкт ойролцоо хотод авчирсан, хаантантай учруулсан, болрын худалдаачинтай уулзуулахын тулд дээрэмдүүлсэн гэх мэт ... тэрхүү хачин холбоо. Хэн нэгэн хүн Хувийн бахархалаа биелүүлэхэд ойртох тутам нь тэрхүү Хувийн бахархал нь түүний орших жинхэнэ учир шалтгаан болох юм даа хэмээн хүү бодлоо.

Жингийн цуваа зүүн зүгийг чиглэн явж байв. Цуваа өглөөгүүр аялах ба нар хамгийн дээр хөөрөх үед зогсон үдээс хойш үргэлжлүүлэн аялж байв. Хүү англи эртэй маш бага ярилцаж байлаа, англи эр ихэнх хугацаанд номоо уншсаар л байдаг байв. Хүү хүмүүс болон амьтдын цөлийг гатлах явцыг чимээгүй ажиглан явав. Одоо анх хөдөлж байсан тэрхүү үймээн бужигнаантай, хүүхдүүдийн орилоон амьтдын янцгаах, буйлах чимээ хөтөч болон худалдаачдын бачимдуу зааварчилгаа бүхий байдлаас тэс өөр болсон байлаа. Цөлд зөвхөн мөнхийн

салхины чимээ болон амьтдын туурайн чимээ л сонсогдоно. Хөтөчүүд хүртэл хоорондоо маш ховор ярилцацгаана.

“Би элсэн цөлийг олон удаа гаталж байна,” хэмээн тэмээ хөтлөгчдийн нэг нь нэгэн шөнө хэлэв. “Гэхдээ цөл асар том, тэнгэрийн хаяа тэртээ хол байдаг тул хүмүүсийг жижиг хэмээн мэдрүүлж чимээгүй байх ёстой шүү хэмээх мэт байдаг.” Хүү өмнө нь цөлөөр аялж байгаагүй ч гэсэн түүний хэлснийг ухан ойлгож байв. Тэр далай юмуу аль эсвэл дүрэлзэх галыг харахаараа тэдгээрийн сүр хүчийг гайхашран чимээгүй болдог билээ. Би хонинуудаасаа болон болор эдлэлээс олон зүйлийг суралцсан гэж хүү бодлоо. Элсэн цөлөөс бас адил ямар нэгэн зүйлийг сурч чадна. Цөл хуучны бөгөөд цэцэн мэт санагдана. Салхи зогсохгүй байсаар хүү Тарифад мөн л адил ийм салхинд илбүүлэн хэрмийн орой дээр зогсож байснаа дурслаа. Энэ нь хүүд түүний хонинуудын ноосыг санагдуулав. Түүний хонинууд нь одоо Андалуизагийн тал нутгаар өвс ус хайн байнга урьдынх шигээ л явж байгаа. “Тэд одоо миний хонь биш болсон,” хэмээн тэр өөртөө сэтгэл хөдлөлгүйгээр хэллээ. “Тэд өөрсдийн шинэ хоньчиндоо дасчихсан, бараг л намайг мартсан болов уу. Тэр нь ч сайн хэрэг. Хонь гэх мэт амьтад аялахад дассан байдаг ч зөвхөн хөдөлж байна гэж л боддог.” Тэрээр нөгөө худалдаачны охины талаар бодсон ба тэр охин гэрлэсэн байх хэмээн итгэлтэй байв. Магадгүй талхчинтай аль эсвэл өөр нэгэн уншиж бас түүнд сонирхолтой түүх ярьж өгч чадах хоньчинтой ч юмуу – эцсийн эцэст хүү тэр охины хувьд цорын ганц нь биш юм. Гэвч тэрээр тэмээ хөтлөгчийн хэлснийг ухааран ойлгосондоо сэтгэл нь ихэд хөдөлсөн бөгөөд магадгүй хүү хүмүүсийн өнгөрсөн, одоог холбох нэгдмэл хэлийг сурж байгаа мэт. “Совингууд,” гэж түүний ээж нь тэдгээрийг нэрлэдэг байсан юм. Хүү хүний зөгнөн сэтгэх нь бүхий л хүмүүсийн түүх холбогдон байх тэрхүү нэгдмэл амьдралын урсгалын, сүнс рүү нэвтрэх гэнэтийн тохиол бөгөөд бид бүхнийг ойлгох боломжтой, яагаад вэ гэвэл бүхий л зүйл тэнд бичигдсэн байдаг гэдгийг ухаарч эхлэн байв.

“Мактүб,” хэмээн хүү хэлэнгээ болрын худалдаачныг саналаа.

Элсэн цөл зарим хэсгээрээ битүү элс, заримдаа хадархаг байв. Хэрвээ жингийн цуваа саадтай тулгарч бөглөгдвөл тойрч гарах шаардлагатай болно. Хадтай том хэсэг таарвал туулахад маш хэцүү саадтай байлаа. Элс нь амьтдын туурайд хэтэрхий нимгэдэж байвал арай зузаан элс бүхий замаар явна. Зарим хэсэгтээ газар, ширгэсэн нуурын давсаар хучигдсан байдаг байлаа. Амьтад нь тийм газрыг туулахад ядрах тул тэмээ хөтлөгчид тэдгээрийн ачааг буулган хөнгөлөх шаардлагатай болдог байв. Хөтөчүүд ачаагаа үүрч гаргаад буцаагаад тэмээндээ ачаална. Хэрвээ хэн нэгэн хөтөч өвдөх юм уу нас барвал, тэмээ хөтлөгчид хоорондоо шодон нэгийгээ сонгох ажээ. Гэхдээ эдгээр бүхий л зүйл ердөө ганцхан энгийн шалтгаанаас л болдог нь, хичнээн их саад тотгор туулж өөрчлөлт хийлээ ч жингийн цуваа луужингийн нэгэн ижил зүг рүү урагшлахад байлаа. Саадуудыг давсны дараагаар цуваа баянбүрдийн байрлалыг тодорхойлох одны зүг аялна. Хүмүүс тэрхүү одыг өглөөний тэнгэрт хармагцаа тэд ус, далдуу мод, хоргодох газар болон бусад хүмүүс байх зүг рүү явж байгаагаа мэддэг байв. Зөвхөн англи эр л энэ бүхнийг ажиглахгүй явсан бөгөөд ихэнх хугацаанд номнуудаа уншин бясалгаж явдаг байв. Хүү ч мөн адил өөрийн авч явсан номыг аялалын эхний хэдэн хоногт уншихаар оролдсон билээ. Гэвч тэрээр жингийн цувааг ажиглан салхины чимээг сонсон явах нь илүү сонирхолтой болохыг мэдэрсэн. Тэр тэмээгээ илүү сайн мэдэж, дасал

болмогцоо ном уншихаа орхисон юм. Хэдийгээр хүү номыг нээх бүрт ямар нэгэн чухал зүйл сурдаг хэмээн итгэдэг ч гэлээ зайлшгүй шаардлагатай биш хэмээн шийдсэн юм. Тэр ойролцоо явдаг тэмээ хөтлөгчтэй нэлээд дотно болов. Шөнөдөө түүдэг галын дэргэд суух зуураа хүү тэрхүү хөтөчид хоньчин байсан үеийнхээ адал явдлаас ярьдаг байлаа.

Нэгэн удаагийн яриан дээр хөтөч өөрийн амьдралын түүхийг өгүүлэв. “Би Кайр хотын ойролцоо амьдардаг байлаа,” гэж тэр хэлэв. “Би өөрийн харшдаа, эхнэр, хүүхдүүдтэйгээ үхэн үхтэлээ өөрчлөгдөхгүй мэт тийм амьдралаар амьдардаг байлаа. Тэр нэгэн ургац хамгийн сайтай жил бид бүгдээрээ Мекка явж би өөрийн биелүүлээгүй үлдсэн цорын ганц даалгавараа гүйцэтгэсэн юм. Би үхэхдээ ч баяртай байж чадах болсон тул сэтгэл хангалуун байлаа.” “Нэгэн өдөр газар дэлхий чичрэн хөдөлж Нил мөрөн эргээ халив. Энэ бол бусад хүмүүст л тохиолдох надад огт тохиолдохгүй зүйл хэмээн би боддог байж. Хөршүүд минь бүхий л оливын модоо үерт алдах нь хэмээн айцгааж байлаа, эхнэр бид хоёр хүүхдүүдээ алдах вий хэмээн айж байв. Миний эзэмшиж буй юм бүхэн устаж үгүй болж болох юм байна гэдгийг би ойлгосон билээ.” “Газар бүрмөсөн сүйдсэн тул би амьдрах өөр арга хайх ёстой болсон юм. Одоо би тэмээ хөтлөгч. Гэвч тэрхүү гамшиг надад Аллах тэнгэрийн үгийг ойлгоход тусалсан юм: хэрвээ хэрэгцээтэй болон хүсч буй зүйлдээ хүрэх чадвартай л бол хүмүүс тохиолдох үл мэдэгдэх аюулаас айх шаардлагагүй.” “Бид өмч хөрөнгө юмуу эзэмшил аль эсвэл амь насаа алдахаас айдаг. Гэвч тэрхүү айдас нь бидний амьдралын тохиолууд болон дэлхийн түүх нь нэг ижил мутраар бичигдсэн гэдгийг ойлгох цагт алга болдог юм.”

Заримдаа жингийн цуваа өөр цуваатай тааралдана. Нэг нь үргэлж нөгөөдөө хэрэгтэй зүйлийг агуулна нээрэн л нэг мутраар бичигдсэн мэт. Тэд галаа тойрон суухад тэмээ хөтлөгчид салхи шуурганы талаар ярилцах бөгөөд целийн түүхийг хүүрнэлдэцгээх бөлгөө. Заримдаа, хачирхалтай, халхавч зүүсэн эрс болох Бедоинууд жин тээх замын дагуу манаа хийж яваад тааралдана. Тэд хулгайчид болон зэрлэг омгийнхны талаарх сэрэмжлэх мэдээг хүргэдэг байв. Тэд чимээгүйхэн ирээд мөн адил буцах бөгөөд зөвхөн нүдээ ил гарган хар дээл, нөмрөг өмсөцгөөнө. Нэгэн шөнө хүү болон англи эрийг сууж байсан галын дэргэд ирсэн хөтөч “Омгуудын хооронд тулаан болж буй мэдээ байна” хэмээн хэлэв. Тэр гурав хэсэг чимээгүй болов. Хэн ч юу ч хэлээгүй боловч агаарт айдсын мэдрэмж байгааг хүү анзаарлаа. Ахиад л тэр нөгөөх үггүйгээр ойлголцох хэл ... нөгөөх нэгдмэл хэлтэй тохиолдох нь тэр ээ. Англи эр тэдэнд аюултай эсэхийг асуулаа. “Хэрвээ чи цөл рүү нэгэнт орсон бол ухрах газар гэж байдаггүй,” хэмээн тэмээ хөтлөгч хэллээ. “Хэрвээ чи нэгэнт ухарч чадахгүй бол чи зөвхөн урагшлах сайн арга замыг л бодох ёстой. Үлдсэн нь, аюул гамшиг ч гэсэн хамтдаа Аллахын мэдэлд байдаг.” Тэгээд тэр нөгөө хачирхалтай үгээ хэлэн төгсгөв: “Мактүб.”

“Чи жингийн цуваанд илүү анхаарал тавибал зүгээр дээ,” гэж хүү англи эрд, тэмээ хөтлөгчийг явсны дараа хэлэв. “Бид маш олон саадтай тааралдсан ч гэлээ үргэлж нэг зүгийг л чиглэн явж байгаа.” “Харин чи дэлхий ертөнцийн талаар илүү ихийг уншсан нь дээр дээ,” хэмээн англи эр хэллээ. “Ном гэдэг чинь тэр утгаараа цөлтэй л ижил,”

Хүмүүс болон амьтдын бөөгнөрсөн цуваа хурдан аялж эхэллээ. Өдөр бүхэн чимээгүй болсоор одоо бүр шөнө галын дэргэд ярилцахдаа дассан аялагчид ч гэсэн чимээгүй болсоор байлаа. Нэгэн өдөр ахлагч жингийн цувааг анхаарал татуулахгүй байхын тулд гал асаахыг хориглох шийдвэр гаргав. Аялагчид шөнөдөө амьтдаа тойруулан амраагаад дунд нь өөрсдөө орж цөлийн хүйтнээс хамгаалах дадалтай болцгоов. Ахлагч мөн зэвсэглэсэн харуулуудыг эргэн тойронд байрлуулдаг болов. Англи эр нэг шөнө нойр нь хүрсэнгүй. Тэрээр хүүг дуудаад буудалласан газрын орчим дахь толгодын дундуур алхлаа. Бүтэн сартай шөнө байсан бөгөөд хүү англи эрд өөрийн амьдралынхаа тухай ярьж өгөв. Хүүг болор эдлэлийн дэлгүүрт ажиллаж эхэлснээс хойш гарсан дэвшлүүдийг сонсоод англи эр ихэд баясан догдлов.

“Тэр бол бүхий л зүйлийг удирддаг тэр зарчим,” гэж тэр хэллээ. “Алхимид үүнийг Дэлхийн сүнс гэж нэрлэдэг. Хэрвээ чи ямар нэгэн зүйлийг бүхий л сэтгэлээрээ хүсвэл тэр нь чи Дэлхийн сүнсэнд хамгийн ойр байгаа нь юм. Энэ бол үргэлж эерэг хүч байдаг.” Тэр мөн энэ нь зөвхөн хүнд л зориулагдсан зүйл биш дэлхий дээрх эрдэс бодис, ургамал, амьтан тэр ч байтугай энгийн нэг бодол хүртэл өөрийн сүнстэй байдаг хэмээлээ. “Дэлхий дээрх бүхий л зүйл үргэлж хувирч өөрчлөгдөн байх ба учир нь Дэлхий амьд, өөрийн Сүнстэй юм. Бид бүхэн тэрхүү сүнсний нэгэн хэсэг бөгөөд тэр сүнс бидний төлөө зүтгэж байдаг гэдгийг ер нь анзаардаггүй. Гэхдээ болор эдлэлийн дэлгүүрт тэрхүү шилнүүд хүртэл чиний амжилтанд туслалцаж байсан гэдгийг чи магадгүй ухаарсан байх.”

Хүү сар болон цайрах элс рүү ширтэх зуураа энэ талаар бодлоо. “Би цөлийг гатлах зуураа жингийн цувааг ажиглалаа,” гэж хүү хэллээ. “Жингийн цуваа цөлтэй нэгэн ижил хэлээр ярилцах юм, тийм учраас цөл түүнийг нэвтрүүлж байна. Цөл жингийн цувааны алхам бүрийг шалгасаар хэрвээ цаг нь болвол бид баянбүрдэд хүрэх болно.” “Хэрвээ бидний аль аль нь энэ цуваанд энэхүү хэлийг ойлголгүйгээр зөвхөн өөрсдийн зоригоор холбогдсон бол энэ аялал маш хэцүү байх байсан болов уу.”

Тэд сарыг харан зогсоцгоолоо. “Тэр бол зөн совингийн гайхамшиг,” хэмээн хүү хэллээ. “Би хөтөчүүд цөлийн тэмдгүүдийг хэрхэн уншиж байгааг мөн цувааны сүнс цөлийн сүнстэй хэрхэн ярилцаж байгааг ажиглалаа.”

“Би ч жингийн цуваанд илүү анхаарал тавьсан нь дээр юм байна даа.” хэмээн англи эр хэллээ.

“Харин би чиний номноос уншсан нь дээр юм,” гэж хүү хэллээ.

22 - р хэсэг

Тэдгээр нь их хачин номнууд байлаа. Номонд мөнгөн ус, давс, луу, хаадуудын тухай гарах бөгөөд хүү алиныг нь ч ойлгохгүй байв. Гэвч ном бүхэнд нэгэн санаа дахин давтагдаад байх мэт санагдсан нь бүхий л зүйл зөвхөн нэг л зүйлийн хувирал юм гэсэн байв. Нэг номноос тэрээр алхимийн хамгийн чухал сургаал нь цөөхөн хэдэн мөрөөс бүтэх бөгөөд очир эрдэнийн ялтас дээр бичигдсэн байдаг хэмээн уншив.

“Энэ бол Эрдэнийн хүснэгт” хэмээн англи эр хүүд ямар нэгэн зүйл зааж өгч магадгүй болох нь хэмээн бахархалтайгаар хэллээ. “Тэгвэл яагаад ийм олон

ном хэрэгтэй гэж?” хэмээн хүү асуулаа. “Тэрхүү цөөн хэдэн мөрийг ойлгохын тулд” гэж англи эр тийм ч итгэлтэй бус байгаа маягтай хариуллаа.

Хүүгийн хамгийн их сонирхсон ном нь нэртэй алхимичдын адал явдлын тухай өгүүлж байв. Тэд бол бүхий л амьдралаа өөрсдийн байгууламждаа төмөрлөг цэвэршүүлэхэд зориулсан хүмүүс байлаа. Тэд хэрвээ төмөрлөгийг олон жил хайлуулах юм бол тэр нь агуулж буй бусад зүйлсээсээ ангижрах бөгөөд түүнд үлдэх зүйл нь Дэлхийн сүнс байх болно гэж итгэдэг байлаа. Тэрхүү Дэлхийн сүнс нь тэдэнд хорвоо дээрх бүхий л зүйлийг ойлгоход хэрэглэгдэх бөгөөд учир нь энэ нь бүх зүйлсийн хоорондоо ойлголцдог тэрхүү хэл юм. Тэд энэхүү ололтоо Мастер бүтээл гэж нэрлэх бөгөөд шингэн болон хатуу хэсгээс тогтоно.

“Энэ хэлийг сурахын тулд зүгээр л хүмүүс болон зөн совингуудыг ажиглаад байж болохгүй гэж үү?” хэмээн хүү асуулаа. “Чамд юм бүхнийг хялбарчлах гэсэн сонин зан байна,” гэж англи эр ундууцлаа. “Алхими бол маш хэцүү ухаан. Алхам бүрийг нь мастеруудын хийж байсантай адилаар гүйцэтгэх ёстой.” Хүү Мастер бүтээлийн шингэн хэсгийг Мөнхийн ус хэмээн нэрлэх бөгөөд тэр нь бүхий л өвчнийг анагаадаг мөн алхимичдийг хөгшрөхөөс хамгаалдаг гэдгийг мэдэж авав. Харин хатуу хэсэг нь Гүн ухаантны чулуу гэж нэрлэгддэг.

“Гүн ухаантны чулууг олох тийм ч хялбар бус,” гэж англи эр хэллээ. “Алхимичид өөрсдийн байгууламждаа төмөрлөг цэвэршүүлж буй галыг ажиглан он удаан жилийг өнгөрөөдөг. Тэд галын дэргэд маш удаан суусаар эцэстээ хорвоогийн хуурмаг чанарын өмнө бууж өгцгөөдөг юм. Тэд төмөрлөгийн цэвэршүүлэлт нь өөрсдийг нь цэвэршүүлэхэд хүргэдэг гэдгийг мэдэцгээсэн болно.”

Хүү болрын худалдаачны талаар дурслаа. Тэр хүүг болор эдлэл цэвэрлэсэн нь сайн боллоо тэгснээр сөрөг бодлоос өөрийг нь салгалаа хэмээсэн юм. Хүмүүс алхимийг өдөр тутмын амьдралаараа сурч болно гэдэгт хүү улам бүр итгэх болов. “Түүнчлэн Гүн ухаантны чулуу бол маш гайхамшигтай зүйл. Түүний жижиг хэсэг нь том хэмжээний төмөрлөгийг алт болгон хувиргаж чадна.” гэж англи эр хэлэв. Түүнийг сонсмогцоо хүү алхимийг улам ихээр сонирхох болов. Зүтгэл тэвчээр байвал юм бүхнийг алт болгон хувиргаж чаддаг болох юм байна хэмээн тэр бодлоо. Тэрээр үүнийг хийж чадсан хүмүүсийн амьдралын талаар уншлаа. Хелветиус, Илиас, Фулканелли болон Гебер. Тэд гайхамшигтай түүхтэй бүгд өөрсдийн Хувийн бахархалаа биелүүлэн амьдарцгаасан байв. Тэд аялцгаан, цэцэн мэргэдтэй уулзацгааж гайхамшигтай ид шид үзүүлэн Гүн ухаантны чулуу болон Мөнхийн усыг эзэмшицгээцсэн байв. Гэвч хүү Мастер бүтээлийг хэрхэн хийхийг судлах үедээ бүр учраа олохоо болиж эхлэв. Тэнд ердөө зурагнууд, түлхүүрлэгдсэн зааврууд болон ойлгомжгүй бичээсүүд л байлаа.

-***-

23 - р хэсэг

“Яагаад тэд юмсыг ийм төвөгтэй болгодог юм бол доо?” гэж хүү англи эрээс нэгэн шөнө асуулаа. Хүү англи эрийг ундууцсан бөгөөд номнуудаа санасан байдалтай байгааг ажиглав.

“Ойлгох чадвартайгуудад нь л ойлгуулахын тулд” гэж англи эр хэллээ. “Хүн бүхэн л хүдрийг алт руу хөрвүүлээд байна гэж төсөөлдөө. Алт үнэ цэнээ алдана

шүү дээ. Шургуу бөгөөд юмсыг гүнзгий судлахыг хүсдэг тэр л хүмүүс Мастер бүтээлд хүрдэг. Тийм ч учраас би энэ цөлийн дунд байна даа. Би тэрхүү нууцыг тайлахад минь туслах жинхэнэ алхимичийг хайж байна.”

“Хэзээ энэ номнууд бичигдсэн юм бэ?” гэж хүү асуулаа. “Олон зууны өмнө.” “Тэр үед хэвлэмэл номнууд байгаагүй шүү дээ,” хэмээн хүү мэтгэлээ. “Хүн бүр алхимийг мэдэх боломж байхгүй. Тэгсэн атал тэд яагаад ийм хачин хэллэг болон маш олон төрлийн зураг хэрэглэсэн юм болдоо?”

Англи эр түүнд шууд хариулж чадсангүй. Тэр хэлэхдээ сүүлийн хэдэн өдөр жингийн цуваа хэрхэн явж байгааг ажигласан ч гэлээ шинэ зүйл сурч чадсангүй хэмээв. Түүний анзаарсан цор ганц зүйл нь дайны талаарх яриа улам бүр ихээр сонсогдох болсон байв.

24 - р хэсэг

Тэгээд нэг өдөр хүү англи эрд номнуудыг нь буцаан өгөв.

“Чи ямар нэг зүйл сурав уу?” гэж англи эр ямар нэгэн зүйл сонсохыг хүлээсэн байдалтай асуулаа. Түүнд дайн болж магадгүй талаар бодохоос зугатаахын тулд ярилцах хүн хэрэгтэй байлаа.

“Дэлхий сүнстэй, тэрхүү сүнсийг ойлгосон бүхэн юмсын хоорондын хэлийг ойлгоно гэдгийг сурлаа. Олон алхимичид өөрсдийн Хувийн бахархалаа биелүүлж Дэлхийн сүнс, Гүн ухаантны чулуу болон Мөнхийн усыг нээн олж чадсаныг сурлаа. Гэвч, юуны өмнө эдгээр зүйлс нь маш энгийн бөгөөд маргад эрдэнийн ялтас дээр бичигдэж болохыг сурлаа.”

Англи эр сэтгэлээр уналаа. Олон жилийн судалгаанууд, шидэт тэмдэгүүд, хачин хэллэг болон байгууламжийн тоног төхөөрөмжүүд гэх мэтийн аль нь ч хүүд сэтгэгдэл төрүүлсэнгүй. Түүний сүнс нь иймэрхүү зүйлсийг ойлгоход хэтэрхий болхи байх гэж тэр бодлоо.

“Буцаад жингийн цуваагаа хардаа,” гэж англи эр хэллээ. “Тэр ч гэсэн надад юу ч заасангүй.”

Хүү цөлийн нам гүмийг болон амьтдын хөлөөр босох элсийг ажиглан бясалган явлаа. “Хүн бүхэн өөрийн гэсэн суралцах аргатай байх юм,” хэмээн тэр өөртөө хэллээ. “Түүний арга минийхтэй адил биш мөн минийх ч түүнийхтэй адил биш. Гэвч бид хоёулаа өөрсдийнхөө Хувийн бахархалын эрэлд явж байгаа тул түүнийх нь тулд би түүнийг хүндэлж байна.”

25 - р хэсэг

Жингийн цуваа өдөр шөнөгүй аялж эхэллээ. Халхавч зүүсэн Бедоинууд улам илүү давтамжтайгаар тааралдах болсон бөгөөд хүүгийн сайн найз болсон нөгөө тэмээ хөтлөгч омгуудын хоорондох дайн аль хэдийн эхэлсэн гэж хэлэв. Баянбүрдэд хүрч чадах юм бол маш азтай хэрэг болох болно. Амьтад ядарч туйлдацгааж, хүмүүс хоорондоо ярилцах нь багассаар л байлаа. Шөнө чимээгүй

байх нь хамгийн хэцүү байв, ердийн тэмээний буйлаан хүртэл өмнө нь зүгээр л тэмээний буйлаан байсан бол одоо хүн бүхнийг түгшээж байлаа учир нь дээрэмчдэд дохио болж болох юм.

Тэмээ хөтлөгч гэхдээ дайны аюулыг нэг их тоосон шинжгүй мэт байлаа. “Би амьд байна,” гэж тэр хүүд гал ч үгүй, сар ч үгүй нэгэн шөнө хэсэг навчаар хооллох зуураа хэллээ.

“Би хооллож байхдаа түүний тухай л боддог. Би аялж явбал аялахдаа л анхаардаг. Хэрвээ би байлдах болвол тэр өдөр үхэхэд бусад өдрүүдийн адил л сайн өдөр байх болно. Яагаад вэ гэвэл би өөрийн өнгөрсөн болон ирээдүйд амьдардаггүй. Би зөвхөн одоо болж байгаа зүйлийг л сонирхдог. Хэрвээ чи одоо болж байгаа зүйлд үргэлж анхаарч чадах юм бол аз жаргалтай нэгэн болох болно. Чи цөлд амьдрал өрнөж байгааг, тэнгэрт одод байгааг бас омгийн эрчүүд тулалдаж байгааг харах болно яагаад вэ гэвэл тэд хүний амьдралын нэгэн хэсэг л юм. Амьдрал чиний хувьд сайхан үдэшлэг, агуу баяр наадам мэт байна яагаад вэ гэвэл амьдрал гэдэг нь бидний яг одоо амьдарч байгаа тэр мөчүүд юм.”

Хоёр хоногийн дараа хүү унтах үедээ шөнө болгон дагаж явдаг нөгөө одоо ажиглалаа. Тэнгэрийн хаяа арай доошилчихсон мэт, учир нь однууд цөлд байгаа мэт санагдаж байв.

“Энэ бол баянбүрд,” гэж нөгөө тэмээ хөтлөгч хэллээ.

“Тэгээд бид яагаад тийшээ явахгүй байгаа юм бэ?” гэж хүү асуулаа.

“Яагаад вэ гэвэл бид унтах ёстой.”

-***-

26 - р хэсэг

Хүү өглөө нар мандахад сэрлээ. Тэнд, түүний нүдний өмнө, өчигдөрийн жижиг однууд байсан газарт төгсгөлгүй үргэлжлэх далдуу моднууд цөлийн дагуу үргэлжлэн байв.

“Бид хийж чадлаа!” гэж мөн эртлэн боссон англи эр хэллээ. Хүү чимээгүй байлаа. Хүү цөлийн нам гүмд гэртээ байгаа мэт дассан тул тэр зөвхөн моднуудыг л харж байсан юм. Тэр цаашаа пирамидууд руу хүрэх хол замыг туулах бөгөөд нэгэн өдөр энэ өглөө зөвхөн дурсамж л болон үлдэнэ. Гэвч яг одоо энэ мөчид – нөгөө хөтөчийн хэлсэнээр тансаг үдэшлэг тохиож буй тул хүү одоогийн энэ мөчид, өнгөрснөөс сурсан хичээлүүд болон ирээдүйн мөрөөдөл шиг амьдрахыг хүссэн билээ. Хэдийгээр далдуу мододын харагдах нь хэзээ нэгэн цагт дурсамж болон үлдэх гэлээ ч яг одоо эдгээр нь сүүдрэвч, ус болон дайнаас хоргодох газрыг илтгэж байх юм.

Өчигдөрхөн л тэмээний буйлаан аюулыг дагуулж байсан бол одоо далдуу модод гайхамшигийг бүтээлээ. Дэлхий олон хэлээр ярих юм хэмээн хүү бодлоо.

-***-

27 - р хэсэг

Цаг хугацаа ч хурдан өнгөрөх юм жингийн цуваа ч мөн адил юм даа хэмээн олон зуун хүн амьтан баянбүрдэд ирж буйг ажиглах зуураа Алхимич бодлоо.

Хүмүүс шинээр ирэгсэд рүү хашгиралдацгааж, цөлийн тэнгэрт тоос босон баянбүрдийн хүүхдүүд харийн хүмүүсийн ирж байгааг харан сэтгэл нь хөдөлцгөөн баясацгааж байв. Алхимич омгийн ахлагчид жингийн ахлагчтай мэндлэн, ярилцаж байхыг харлаа. Гэвч эдгээрийн аль нь ч Алхимичид сонин байсангүй. Тэрээр аль хэдийн олон хүн ирж буцахыг харсан бөгөөд цөл байсан хэвээрээ л үлддэг байв. Тэрээр хаадууд болон гуйлгачид цөлийн элсээр аялахыг харж байсан. Толгодууд салхиар байнга өөрчлөгдөх авч тэдгээр нь түүний хүүхэд байхаасаа л мэдэх тэр л элснүүд байлаа. Тэр үргэлж л хэдэн долоо хоногоор шаргал элс, цэнхэр тэнгэрээр аялсан аялагчид далдуу мододын ногоон өнгийг хараад баярлахыг харахдаа баясдаг байв. Магадгүй Бурхан хүмүүсийг далдуу мододод талархуулахын тулд цөлийг бүтээсэн ч юм болов уу, гэж тэр бодлоо.

Тэрээр илүү бодитой зүйлд анхаарахаар шийдэв. Тэр энэхүү цуваанд өөрийнхөө нууцын заримаас зааж өгөх нэгэн ирж байгааг мэдэж байв. Зөн совингууд түүнд ингэж хэлсэн билээ. Тэрээр хэн гэдгийг нь одоохондоо мэдээгүй ч гярхай нүдээрээ түүнийг хэзээ илрэх цагт нь таних болно. Тэрээр түүнийг өмнөх дагалдагч шавь шиг нь чадвартай хүн байгаасай хэмээн найдаж байв.

Яагаад эдгээр зүйл ам дамжин өвлөгдөх ёстой юм бол гэдгийг би мэдэхгүй юм даа гэж тэр бодлоо. Чухам яг үнэндээ эдгээр нь нууц зүйлүүд ч биш юм. Бурхан нууцаа өөрийн бүх л бүтээлүүддээ хялбархнаар илчилдэг. Юмс ийм замаар дамжигдах ёстой гэдэгт тэрээр ганцхан л тайлбар өгч чадна учир нь тэд цэвэр амьдралаар бүтээгдсэн бөгөөд тийм амьдрал зураг болон үгээр илэрхийлэгддэггүй. Хүмүүс зураг болон үгнүүдэд хэтэрхий татагдаад Дэлхийн хэлний талаар ор тас мартчихдаг юм.

28 - р хэсэг

Хүү харсан зүйлдээ итгэж ядан байлаа. Баянбүрд гэж хэдэн далдуу модоор хүрээлэгдсэн булаг, газарзүйн номноос нэг удаа харж байсан бол энэ нь Испаний зарим хотуудаас ч том ажээ. Гурван зуун булаг, тавин мянган мод болон тоолж баршгүй өнгийн асрууд тархан байрласан байв.

“Энэ ч яг л Мянга нэгэн шөнийн үлгэрт гардаг шиг л байна,” гэж англи эр Алхимичтай уулзахаар яаран байх зуураа хэллээ. Тэднийг ирж буй хүмүүс болон амьтдыг сонирхсон хүүхдүүд бүчлээ. Баянбүрдийн эрчүүд тэднийг ямар нэгэн тулаан харсан эсэхийг мэдэхийг хүссэн бол эмэгтэйчүүд нэг нь нөгөөгөөсөө өрсөн худалдаачдын авчирч буй даавуу болон үнэт чулуурууд руу хошуурна. Цөлийн нам гүм байдал холын зүүд шиг болж жингийн цувааны аялагчид хоорондоо эрчимтэйгээр ярилцацгаан, инээлдэж хашгиралдан оюун санааны ертөнцөөс эргээд хүний ертөнцөд орсон мэт байв. Тэд сэтгэл нь амарцгаан жаргалтай байлаа.

Цөлд тэд болгоомжтой явцгаадаг ч гэлээ нөгөө тэмээ хөтлөгчийн хэлснээр баянбүрдүүд үргэлж тайван газар нутагт тооцогддог, учир нь дийлэнх оршин суугчид нь эмэгтэйчүүд, хүүхдүүд байдаг. Баянбүрдүүд цөлд олон ч гэсэн эрчүүд цөлд тулалдацгааж баянбүрдүүдийг түшиц газар болгон үлдээдэг билээ.

Зарим хүндрэлтэйгээр жингийн ахлагч бүх хүмүүсээ цуглуулаад зааварчилгаа өглөө. Тэд омгийнхны хоорондох тулаан дуустал баянбүрдэд үлдэцгээх ажээ. Нэгэнтээ тэд зочид учраас тэнд амьдарч буй хүмүүстэй хамт амьдрах бөгөөд хамгийн сайн хүлээн авалтыг эдлэх болно. Энэ нь зочлох хууль байлаа. Тэгээд ахлагч, хүн бүрийг бүр өөрийн хамгаалагчдаа хүртэл зэвсэгнүүдээ омгийн ахлагчдын томилсон хүмүүст хураалгахыг шаардлаа. “Ингэх нь дайны цагийн дүрэм юм” гэж ахлагч тайлбарлав. “Баянбүрд цэргүүдийг агуулж болохгүй.”

Англи эр гангаар бүрсэн тонгорог цүнхнээсээ гаргаж ирээд зэвсэг цуглуулж буй хүмүүст өгөхөд хүү гайхав. “Яагаад заавал тонгорог гэж?” хэмээн хүү асуулаа. “Энэ бол намайг хүмүүст итгэхэд минь туслана” гэж англи эр хэллээ.

Энэ зуур хүү өөрийнхөө баялгийн талаар бодож байлаа. Тэр өөрийн мөрөөдөлөө биелүүлэхэд ойртох тутам юмс улам л хэцүү болох юм. Настай хаантаны хэлсэн эхлэгчдийн аз үйлчлэхээ болиж байх мэт санагдаж байлаа. Мөрөөдлийнхөө төлөө явахад тэр үргэлж л эр зориг болон тэвчээр хатуужлаа сорих болж байна. Тийм учраас хүү хэтэрхий яарах юмуу аль эсвэл тэвчээр алдаж болохгүй байлаа. Хэрвээ урагшаа хэтэрхий зүтгэвэл түүний явах замын дагуу Бурханы илгээсэн зөн совинг анзаарахгүй өнгөрөх болно. Бурхан тэднийг миний явах замын дагуу байрлуулсан байж. Тэрээр энэхүү бодолдоо гайхлаа. Энэ хүртэл хүү зөн совинг энэ ертөнцийн нэг л зүйл хэмээн боддог байв. Яг л хооллох, унтах аль эсвэл хайрлан дурлах юмуу ажил хайх гэхчлэн. Хүү тэднийг Бурхан юуг хийвэл зохилтой вэ гэдгийг үзүүлэхэд ашигладаг гэж хэзээ ч бодож байсангүй. “Хэзээ ч бүү тэвчээргүй загна,” гэж тэр өөртөө хэллээ. Энэ бол яг л тэмээ хөтлөгчийн хэлдэгээр “Идэх цаг болвол ид. Хөдлөх цаг нь ирвэл хөдөл” гэсэнтэй адил байлаа.

Анхны тэр өдөр хүн бүхэн ядарснаасаа болоод англи эр хүртэл унтан өнгөрөөцгөөв. Хүү найзаасаа нэлээд зайдуухан нэгэн майханд ойролцоо насны таван залуутай хамт хуваарилагдав. Тэд цөлийн хүмүүс тул том хотын амьдралын талаарх хүүгийн түүхүүдийг шимтэн сонсоцгооно. Хүү тэдэнд хоньчин байсан үеийнхээ амьдралыг өгүүлэн бараг л болор эдлэлийн дэлгүүрт ажилласнаа ярих гэж байх үед англи эр майханд орж ирлээ.

“Би чамайг бүхий л өглөөжингөө хайлаа,” хэмээн хүүг дагуулан гарах зуураа тэр хэллээ.

“Алхимич хаана байгааг олохын тулд чи надад туслах хэрэгтэй байна.”

Эхэндээ тэд түүнийг өөрсдөө олохоор оролдов. Алхимич ер нь баянбүрдийн бусад хүмүүсээс өөрөөр амьдрах ёстой, түүний асарт зууханд үргэлж л гал асч байх болов уу. Тэд газар сайгүй хайсан ч гэсэн баянбүрд тэдний төсөөлснөөс ч хамаагүй том байсан бөгөөд тэнд хэдэн зуун асар байлаа. “Бид бараг л бүтэн өдрийг үрчихлээ,” гэж англи эр хүүгийн хамт нэгэн булгийн дэргэд сууж байх зуураа хэллээ. “Бид хэн нэгнээс асуусан нь магадгүй дээр байх,” гэж хүү санал болголоо. Англи эр өөрийнхөө баянбүрдэд ирсэн шалтгаанаа бусдад хэлэхийг хүсээгүй тул шийдвэр гаргаж чадахгүй байв. Гэхдээ эцэст нь хүү түүнээс илүүтэйгээр арабаар ярьдаг тул түүнд зөвшөөрөв. Хүү булаг руу ямааны арьсанд ус авахаар ирсэн эмэгтэй рүү ойртон очлоо.

“Өдрийн мэнд, Би энэ баярбүрдэд Алхимич хаана нь амьдардагийг мэдэхээр хичээж байгаа юм.” Тэр эмэгтэй тийм хүний талаар огт сонсож байгаагүй гэж

хэлээд хурдхан холдов. Гэхдээ тэр явахаасаа өмнө хүүг хар хувцас өмссөн эмэгтэйчүүдтэй ярилцахгүй байсан нь дээр шүү учир нь тэд гэрлэсэн эмэгтэйчүүд хэмээн зөвлөв. Тэр уламжлалт ёсыг хүндэтгэвэл зохилтой. Англи эр сэтгэлээр унаж орхив. Тэрээр оргүй хоосон зүйлийн төлөө холын аялал хийсэн болж таарах нь. Хүү ч мөн адил гунигтай байв, түүний найз нь Хувийн бахархалынхаа эрэлд яваа шүү дээ. Тэгээд хэн нэгэн тийм эрэлд явж байвал бүхий л ертөнц түүнийг амжилт гаргахад тусладаг юм гэж настай хаантан хэлсэн билээ. Тэр худлаа хэлээгүй байлтай. “Би алхимичдийн талаар өмнө нь хэзээ ч сонсож байсангүй” гэж хүү хэллээ. “Магадгүй эндхийнхэн ч гэсэн тийм байх.”

Англи эрийн нүд нь гэрэлтээд ирэв. “Яг тийм. Магадгүй эндхийнхэн алхимич гэж хэн болохыг мэддэггүй байх. Хэн хүмүүсийн өвчнийг эмчилдэгийг олъё!”

Хараар хувцасласан хэд хэдэн бүсгүйчүүд ус авахаар булаг руу ирсэн боловч англи эрийн шаардахыг үл хайхран хүү тэдэнтэй ярилцсангүй. Тэгтэл нэгэн эр айсуй. “Та эндхийн хүмүүсийг анагаадаг хэн нэгнийг мэдэх үү?” гэж хүү асуулаа. “Аллах бурхан бидний өвчнийг анагаадаг,” гэж тэр эр харийн хүмүүсээс жийрхсэн байдалтай хэллээ. “Та нар чинь буруу номын шидтэнүүдийг хайж байгаа юм уу” Тэрээр Коран судрын зарим тарниас уншин цааш одов.

Өөр нэгэн хүн гарч ирлээ. Тэрээр настай хүн байсан ба жижиг сав барьсан байлаа. Хүү асуултаа давтлаа. “Та нар яагаад тийм хүнийг хайх болов?” гэж тэр араб эр асуулаа. “Яагаад вэ гэвэл миний найз тэр хүнтэй уулзахын тулд олон сараар аялсан юм,” гэж хүү хэллээ. “Хэрвээ тийм хүн энэ баянбүрдэд байдаг бол тэрээр маш хүчирхэг нэгэн байх ёстой,” гэж тэр эр хэсэг бодсоноо хэллээ. “Омгийн ахлагчид хүртэл хүссэн цагтаа түүнтэй уулзаж чаддаггүй юм. Зөвхөн тэр өөрөө хүссэн үед л.” “Дайн дуустал хүлээ. Тэгээд жингийн цуваатай хамт цааш аял. Баянбүрдийн амьдралд оролцохыг бүү хичээ,” гэж тэр хэлээд цааш алхав.

Гэвч англи эр баяртай байв. Тэд зөв замаар явж байна. Эцэст нь хар өнгийн хувцас өмсөөгүй нэгэн залуу бүсгүй ойртон ирлээ. Тэр мөрөн дээр сав үүрсэн толгойдоо алчуур зүүсэн боловч нүүрээ халхлаагүй байлаа. Хүү алхимичийн тухай асуухаар түүн рүү ойртлоо.

Яг тэр мөчид түүнд цаг хугацаа зогсох мэт санагдсан бөгөөд Дэлхийн сүнс түүн рүү нэвтрэх мэт байлаа. Хүү бүсгүйн хар нүд рүү ширтэн уруул нь инээмсэглэл болон нам гүм байдлыг илтгэн байхыг харах зуур хүү бүх дэлхийн ойлголцдог тэрхүү хэлний хамгийн чухал хэсгийг дэлхий дээрх хүн бүхэн зүрхэндээ ойлгох чадвартай тэрхүү зүйлийг сурлаа. Энэ бол ХАЙР байв. Энэ бол хүн төрөлхтнөөс, элсэн цөлөөс ч эртний зүйл юм. Тэрхүү булаг дээр тэр хоёрыг уулзахад үүссэнтэй адил хос харцнууд тулгарахад адилхан үүсдэг тэрхүү зүйлийг бүтээгч хүч.

Бүсгүй инээмсэглэлээ – тэр нь яах аргагүй зөн совин, хүүгийн өөрөө ч мэдэлгүй бүхий л насаараа хүлээсэн тэрхүү зөн совин байлаа. Хүүгийн хонинуудтайгаа, ном, болор эдлэлүүд болон цөлийн нам гүмд хайж байсан тэр л совин. Энэ бол цэвэр Дэлхийн хэл байв. Үүнд ямар ч тайлбар шаардлагагүй яг л орчлон ертөнц хязгааргүй цаг хугацаан дунд аялан байхад шалтгаан хэрэггүй байдагтай адил. Хүүгийн тэр мөчид мэдэрсэн зүйл нь гэвэл тэрээр өөрийн амьдрал дахь цор ганц бүсгүйнхээ өмнө зогсож байгаагаа мэдэрсэн бөгөөд ямар ч үгийн

шаардлагагүйгээр тэр бүсгүй бас түүнийг мэдэрсэн байлаа. Хүү энэ дэлхийн бусад бүх зүйлсээс илүүтэйгээр үүнд итгэлтэй байв. Тэрээр эцэг эх болон эмээ, өвөөгөөсөө хүн гэр бүл болохоосоо өмнө дурлаж бас тэр хүнээ сайн мэддэг болсон байх ёстой хэмээн заалгаж байсан билээ. Гэвч тэр замаар мэдэрдэг хүмүүс хэзээ ч нэгдмэл хэлийг ойлгодоггүй байх. Учир нь тэрхүү хэлийг мэддэг бол энэ ертөнц дээр хэн нэгэн чамайг хүлээж байгаа эсэхийг элсэн цөлийн дунд юм уу аль эсвэл том хотын хаа нэгтээ байгааг хялбарханаар ойлгож болно. Тэгээд тийм хос хоёр тааралдаж, тэдний харц тулгарахад өнгөрсөн болон ирээдүй тийм ч чухал биш юм. Зөвхөн тэр л агшинд, нарны доорх бүхий л зүйл зөвхөн нэг мутраар бичигдсэн гэдэг гайхамшигт нотолгоо оршдог. Энэ мутар л хайрыг өдөөж, дэлхийн хүн бүхэнд хос сүнсийг бүтээдэг. Ийм хайргүйгээр хэн нэгний мөрөөдөл ямар ч утга учиргүй зүйл байх билээ. Мактүб хэмээн хүү бодлоо.

Англи эр хүүг нудран “Алив, түүнээс асуугаач!” Хүү охин руу урагш алхан түүнийг инээмсэглэхэд хүү бас адилхан инээмсэглэв.

“Чиний нэрийг хэн гэдэг вэ?” гэж хүү асуулаа. “Фатима,” гэж охин хэлээд нүдээ цавчлан байв.

“Манай нутгийн зарим бүсгүйчүүд бас ийм нэртэй байдаг.”

“Энэ бол Зөнчийн охины нэр,” гэж Фатима хэллээ. “Дайчид энэ нэрийг газар сайгүй түгээсэн юм.”

Үзэсгэлэнт охин дайчидын талаар бахархалтайгаар өгүүлэв. Англи эр түүнийг шавдуулан хүү түүнээс хүмүүсийг хэн анагаадаг талаар асуулаа. “Тэр бол дэлхийн бүхий л нууцыг мэддэг хүн,” гэж тэр хэллээ. “Тэр цөлийн савдагуудтай ярилцаж чаддаг.” Савдагууд бол сайн болон муу талын сахиусууд юм.

Тэгээд охин өмнө зүгийг заан тэрхүү онцгой хүн хаана байдгийг зааж өглөө. Тэгээд тэр хувингаа усаар дүүргээд явлаа. Англи эр ч мөн адил Алхимичийг олохоор яаран одов. Харин хүү тэр булаг дээр удаан хугацаанд суун нэг өдөр Тарифад сэвшээ салхи энэ бүсгүйн сүрчигний үнэрийг түүнд авчирсаныг дурсан хүү энэ бүсгүйг байдаг эсэхийг нь мэдэхээсээ өмнө түүнд дурласан болохоо ухаарлаа. Хүү энэ бүсгүйг хайрласан хайр нь энэ дэлхийн бүхий л баялгийг илрүүлэн олох боломжийг түүнд нээж өгөхийг мэдсэн билээ.

Дараагийн өдөр нь хүү охинтой уулзахыг горьдон нөгөө булаг руу ахин ирлээ. Англи эр мөн тэнд цөлийг ажиглан байсанд хүү ихэд гайхав. “Би бүхий л өдөржингөө хүлээсэн,” гэж англи эр хэллээ. “Тэр үдэш эхний одод гарах үеэр ирсэн. Түүнд би юу хайж байгаагаа хэлэхэд тэр надаас, өмнө нь намайг хүдрийг алт болгож байсан эсэхийг асуусан. Би түүнд тэр бол миний энд суралцахаар ирсэн зүйл гэдгийг хэлсэн” “Тэрээр надад тэгвэл хийхээр оролдох ёстойг хэлсэн. Түүний хэлсэн үг нь гэвэл ердөө л ‘Яваад оролд.’”

Хүү юу ч хэлсэнгүй. Хөөрхий англи эр энэ хол замаар зөвхөн өөрийнхөө өмнө нь олон дахин хийж байсан зүйлээ давтан хийхийг хэлүүлэхийн тулд л аялсан байна. “Тэгвэл оролдоод үз л дээ,” гэж хүү англи эрд хэллээ. “Би тэгье л гэж бодож байна. Би яг одооноос эхлэх болно.”

Англи эрийг явах үед Фатима ирээд хувингаа усаар дүүргэлээ.

“Би чамд зөвхөн нэг зүйлийг хэлэхээр ирсэн юм.” хэмээн хүү хэллээ. “Би чамайг эхнэрээ болгохыг хүсч байна. БИ ЧАМД ХАЙРТАЙ.”

Охин саваа алдан ус цалгиллаа. “Би энд өдөр бүр чамайг хүлээж байх болно. Би цөлийг Пирамидуудын ойролцоо байх эрдэнэсийг олохын тулд гаталсан бөгөөд энэ дайн миний хувьд хараал идсэн мэт бодогдож байлаа. Гэвч одоо энэ адислал боллоо яагаад вэ гэвэл энэ дайн намайг чамтай учрууллаа.”

“Дайн нэг л өдөр дуусах болно шүү дээ,” гэж охин хэллээ. Хүү эргэн тойрныхоо мододыг харав. Тэр хоньчин байснаа эргэн санасан бөгөөд ахиад хоньчин болж ч болох юм. Фатима түүний баялгаас илүү чухал байлаа.

“Омгийн эрчүүд үргэлж л баялгийн эрэлд явж байдаг,” хэмээн охин түүнийг юу бодож байгааг таамагласан мэт хэллээ. “Тийм болохоор элсэн цөлийн бүсгүйчүүд эрчүүдээрээ бахархаж байдаг юм.” Тэгээд тэр хувингаа дүүргэж аваад яван одлоо.

Хүү Фатиматай уулзахын тулд өдөр бүр булаг руу ирдэг болов. Тэр түүнд хоньчин байсан тухайгаа, хаантны талаар бас болор эдлэлийн дэлгүүрийн талаар ярьж өгөв. Тэд найзууд болцгоосон бөгөөд охинтой уулзах арван таван минутаас бусад үед өдөр ердөө ч өнгөрөхгүй мэт санагдана.

Баянбүрдэд бараг сар орчим болоод байх үед жингийн цувааны ахлагч хамт яваа хүмүүсээ цуглуулан уулзацгаалаа. “Бид дайн хэзээ дуусахыг мэдэхгүй байгаа тул, аялалаа цааш үргэлжлүүлж болохгүй байна,” гэж тэр хэллээ. “Тулаан удаан хугацаагаар сунжирч ч магадгүй, магадгүй жилээр. Эсрэг талууд хоёулаа хүчирхэг бөгөөд энэ дайн хоёр талд хоёуланд нь чухал. Энэ тулаан бол сайн нь муугийн эсрэг тулаан биш юм. Энэ бол хүчний харьцаагаа тэнцүүлэхийн тулд байлдаж буй талуудын дайн болохоор бусдаас илүү удаан үргэлжилдэг – учир нь Аллах хоёр талд адилхан ханддаг.”

Хүмүүс байрласан газар руугаа буцацгаан хүү Фатиматай уулзахаар үдийн үеэр явлаа. Хүү түүнд өглөөний уулзалтын талаар ярив.

“Биднийг танилцсаны маргааш,” гэж Фатима хэлээд “та надад надад хайртай гэж хэлсэн билээ. Тэгээд та надад ямар нэгэн нэгдмэл хэл болон Дэлхийн сүнсний талаар зааж өгсөн. Түүнээс улбаалан би таны нэгэн хэсэг болчихсон байна.”

Хүү охины дууг сонсон байхдаа мододын дундах салхинаас ч илүү уянгалаг сайхан байна хэмээн бодлоо.

“Би таныг энэ баянбүрдэд удаан хүлээж байсан. Би өөрийн өнгөрүүлсэн амьдрал болон цөлийн эрчүүдийн эмэгтэй хүнийг ямар байвал зохилтой гэдэг уламжлалт ёсыг ч мартчихсан. Бүр хүүхэд байхаасаа эхлэн би элсэн цөл надад ямар нэгэн гайхамшигтай бэлэг авчирна хэмээн мөрөөддөг байсан. Одоо миний бэлэг надад ирлээ, энэ бол та.”

Хүү түүний гарыг атгахыг хүсч байлаа. Гэвч Фатима савныхаа бариулаасаа атгасан байв. “Та надад өөрийнхөө мөрөөдлийн тухай бас настай хаантан болон өөрийнхөө баялгийн тухай ярьсан. Тэгэхээр одоо би юунаас ч айхгүй байна, учир нь тэрхүү зөн совингууд таныг над дээр хөтлөн авчирсан байна. Тэгээд би таны мөрөөдлийн нэгэн хэсэг таны хэлдэгээр бол таны Хувийн бахархалын

нэгэн хэсэг юм байна. Тийм болохоор би таныг өөрийнхөө зорилгод хүрэхийн тулд үргэлжлүүлэхийг хүсч байна. Хэрвээ та дайн дуустал хүлээх шаардлагатай бол хүлээ. Гэхдээ та түүнээс өмнө явах шаардлагатай бол мөрөөдлийнхөө төлөө явах хэрэгтэй. Толгодууд салхиар өөрчлөгддөг ч гэлээ элсэн цөл хэзээ ч өөрчлөгддөггүй. Тэр бол бидний нэг нэгэндээ өгсөн хайртай адил.”

“Мактүб,” гэж охин хэллээ. “Хэрвээ би үнэхээр л таны мөрөөдлийн нэгэн хэсэг мөн бол та нэг өдөр л буцаж ирэх болно.”

Тэр өдөр түүнийг явсны дараа хүү гунигтай байлаа. Хүү бүхий л таньдаг гэрлэсэн хоньчидынхоо тухай бодлоо. Тэд хол газар одоодоо эхнэрүүдээ ятгах гэж их л хэцүүддэг байсан билээ. Хайр сэтгэл тэднийг хайртай хүнтэйгээ хамт байхыг шаарддаг байв.

Хүү Фатиматай дараагийн удаа уулзахдаа энэ тухай хэлэв. “Элсэн цөл манай эрчүүдийг авч одоод үргэлж бүгдийг нь буцаадаггүй,” гэж охин хэллээ. “Бид үүнийг мэддэг бөгөөд бид үүнд дассан. Буцаж ирээгүй хүмүүс нь үүлсийн нэгэн хэсэг, элсэн цөлд хэсүүчлэх амьтад болон газраас ундрах усны хэгэн хэсэг болцгоодог. Тэд юм бүхний нэгэн хэсэг ... тэд Дэлхийн сүнс болцгоодог.” “Зарим нь буцаж ирцгээдэг. Тэгэхээр бусад бүсгүйчүүд өөрийн хайртай хүн нь нэг л өдөр бас ирнэ хэмээн баярлацгаадаг. Би тэдгээр бүсгүйчүүдийг харж дассан бөгөөд тэдний аз жаргалд атаархаж явдаг. Одоо би өөрөө тэдгээр бүсгүйчүүдтэй адил хүлээсэн бүсгүй болох нь. Би цөлийн бүсгүй бөгөөд түүгээрээ бахархдаг. Би өөрийн эр нөхрөө толгодыг хэвшүүлэгч салхи шиг эрх чөлөөтэй байхыг хүснэ. Тэгээд хэрвээ шаардлагатай бол би түүнийгээ үүлний, амьтдын болон цөлийн усны нэгэн хэсэг болох тэр үнэнийг хүлээн зөвшөөрөх болно.”

Хүү англи эртэй уулзахаар хайлаа. Тэр түүнд Фатимагийн талаар хэлэхийг хүсч байв. Англи эр майхныхаа гадна зуух барисан байхыг хараад хүү ихэд гайхашрав. Тэр нь нэлээд хачин, мод түлдэг зуух бөгөөд нэгэн тунгалаг шингэн дээр нь буцалж байлаа.

Англи эр цөлийн зүг ширтэн байгааг харахад нүд нь номоо уншиж байснаасаа илүүтэйгээр гялалзан байлаа. “Энэ бол ажлын эхний хэсэг,” гэж тэр хэллээ. “Би хүхэрийг ялган тусгаарлах шаардлагатай. Үүнийг амжилттай хийхийн тулд би бүтэлгүйтэхээс айх аюулгүй байх шаардлагатай.” Намайг Мастер бүтээл гаргахаар оролдохоос холдуулж байсан эхний шалтгаан бол миний бүтэлгүйтэхээс айх айдас байж. Одоо би арван жилийн өмнө эхэлчих байсан зүйлээ эхэлж байна. Гэвч би ядаж хорин жил хүлээгээгүйдээ баярлаж байна.” Англи эр галаа үргэлжлүүлэн түлсээр, хүү тэнд нар шингэж цөлийг нил ягаан өнгөөр гэрэлтүүлтэл хүлээлээ.

Хүүд нам гүм байдал түүний асуултанд хариулах эсэхийг мэдэх эсэхийг үзэхээр цөлийн гүн рүү гарах мэдрэмж төрж байлаа. Тэр баянбүрдийн модод арай ч далдрахгүй газруудаар эргэн тойрон нэлээд алхлаа. Тэр салхины чимээг сонсон хөл дороо гишгэгдэх чулуунуудыг мэдрэн байлаа. Энд тэндгүй дун, хясаанууд байхыг харвал цөл эрт дээр үед далай байсан нь мэдэгдэж байв. Тэр нэгэн чулуун дээр суугаад тэнгэрийн хаяаг ширтэн түүнд уусан суулаа. Тэр хайрыг өмчлөлөөс ялгаатай авч үзэхийг хичээсэн боловч салган ойлгож чадахгүй

байлаа. Гэвч Фатима бол цөлийн бүсгүй тул хэрвээ ямар нэгэн зүйл түүнийг ойлгоход нь туслаж чадах бол тэр нь элсэн цөл өөрөө байх билээ.

Тэнд бодол болон суух зуур тэрээр дээгүүр нь ямар нэгэн зүйл хөдлөх шиг болохыг анзаарав. Хүү дээшээ харвал дээр хэсэг харцаганууд нисэлдэн байлаа. Тэр харцагануудыг ширтэн харлаа. Тэдний нислэг нь хэдийгээр эмх замбараагүй байсан ч хүүд ямар нэгэн мэдрэмж төрүүлэв. Гэхдээ хүү яг юу гэдгийг нь ойлгож чадахгүй байлаа. Хүү шувуудын хөдөлгөөнийг дагуулан харж ямар нэгэн зүйлийг тайлахаар хичээв. Магадгүй цөлийн шувууд түүнд өмчлөлгүй хайрын утгыг тайлбарлаж чадах ч юм билүү. Тэр зүүрмэглэх мэт байлаа. Зүрхэндээ тэрээр сэрүүн байхыг хүсч байсан ч бас унтахыг хүсч байлаа. “Би Дэлхийн хэлнээс суралцаж байгаа тул харцагануудын нислэгээс эхлээд юм бүхэн утга учиртай санагдаж эхэлж байна.” гэж тэр өөртөө хэллээ. Тэгээд тэр хайр дурлалд автсандаа баярлаж байлаа. Хэрвээ хүн хайр сэтгэлд умбах юм бол юмс илүү их утга учиртайгаар мэдэгддэг юм байна гэж тэр бодлоо.

Гэнэт нэгэн харцага агаарыг зүсэн нөгөө нэг рүү гээ довтоллоо. Яг энэ үед хүүд сэлэм далайсан цэргүүд баянбүрд рүү дайран ирж буй дүрслэл харагдан өнгөрлөө. Тэр дүрслэл агшин зуур алга болсон авч энэ нь түүнийг сэрээж орхив. Хүү хүмүүс зэрэглээний талаар ярилцахыг зөндөө сонсож байсан бөгөөд өөрөө ч заримыг нь харж байсан боловч ер нь тэдгээр нь хүмүүсийн хүчтэй хүслийн дагуу цөлийн элсээр бүтээгдсэн байдаг билээ. Харин хүү баянбүрд рүү дайсны цэргүүд довтолохыг хүсээгүй нь тодорхой. Хүү тэр зурвас дүрслэлийн талаар мартаж, бясалгалын тайван байдалдаа буцан орохыг хүсч байлаа. Тэр ахиад цөлийн ягаан сүүдрүүд болон чулуунуудыг анхаарахаар оролдов. Гэвч зүрхэнд нь ямар нэгэн зүйл тэгэхийг зөвшөөрөхгүй байлаа. “Зөн совинг үргэлж анхаарч бай,” гэж настай хаантан хэлсэн билээ. Хүү юу харснаа эргэн санаад энэ нь үнэндээ тохиолдох гэж байна гэдгийг мэдэрлээ.

Тэр босоод далдуу мододын буцан зүг алхлаа. Ахин нэг удаа тэрээр юмсын олон хэлний талаар ажигласан бөгөөд энэ удаад цөл аюулгүй харин баянбүрд аюулд орохоор байв. Нөгөө тэмээ хөтлөгч модны ёзоор дээр суугаад нар шингэхийг ажиглан байв. Тэрээр хүүг толгодын нөгөө талаас ирж байхыг харлаа.

“Дайсан ирж байна,” гэж хүү хэллээ. “Надад тэгэж совин татлаа.”

“Цөл эрчүүдийн зүрхийг совин, зөгнөлөөр дүүргэдэг юм,” гэж тэмээ хөтлөгч хариуллаа.

Гэвч хүү түүнд харцагануудын талаар, тэдний нислэгийг ажиглан байхдаа гэнэт Дэлхийн сүнсэнд нэвтэрсэн мэт мэдрэгдсэнээ ярилаа. Тэмээ хөтлөгч хүүгийн хэлж байгааг ойлгож байв. Тэрээр дэлхий дээрх аль ч зүйл бүх юмсын түүхийг илтгэж болно гэдгийг мэдэж байлаа. Зарим нь номын хуудсыг нээж, зарим нь хүний алганы хээгээр, зарим нь хөзрөөр аль эсвэл шувуудын хөдөлгөөнийг ажиглан гэх мэтээр тэрхүү ажигласан зүйлээрээ дамжуулан одоогийн мөчтэй холбоо илрүүлж чадна. Үнэн хэрэгтээ тэрхүү зүйлс нь ямар нэг зүйлийг хэлээд байгаа биш тэр хүмүүс орчиндоо юу болж байна вэ гэдгийг хараад Дэлхийн сүнсэнд нэвтрэх аргыг олж чадаж байгаа юм.

Дэлхийн сүнсэнд нэвтрэхдээ дадамгай тул түүгээрээ амьдардаг олон хүмүүс элсэн цөлд амьдардаг байлаа. Тэднийг төлөгчид гэх бөгөөд эмэгтэйчүүд болон настайчууд тэднээс эмээцгээх бөлгөө. Эрчүүд тэдэнтэй зөвлөлдөхөөс бас цааргалдаг яагаад вэ гэвэл тулаанд үхэх тавилантайгаа мэдчихвэл дайчин байлдах боломжгүйд хүрнэ. Омгийн эрчүүд тулааны амтыг, үр дүнг нь мэдэхгүй байхыг илүүд үзэх ба ирээдүй аль хэдийн Аллах бурханы мутраар бичигдсэн, түүний бичсэн нь үргэлж хүмүүний сайн сайхны төлөө байдаг билээ. Тийм учраас цөлийн эрчүүд зөвхөн одоо болж байгаа мөчид л амьдардаг яагаад вэ гэвэл одоо цаг сонирхолтой зүйлсээр дүүрэн байдаг бөгөөд тэд олон зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг. Дайсны илд нь хаана байна? Морь нь хаана байна? Амьд үлдэхийн тулд дараачийн цохилтоо яаж хийх вэ? гэх мэтээр.

Тэмээ хөтлөгч дайчин эр биш учраас төлөгчидтэй ярилцдаг байв. Ихэнхийнх нь хэлсэн нь таардаг ч гэлээ зарим нь буруу хэлдэг л байв. Нэгэн өдөр тэмээ хөтлөгчтэй тааралдсан төлөгчдөөс хамгийн хөгшин бөгөөд хамгийн их аймшигтай төлөгч түүнээс яагаад ингэж их ирээдүйг сонирхдог юм бэ хэмээн асуужээ.

“Ммм ... Би юмсыг хийхийн тулд” гэж тэмээ хөтлөгч хэллээ. “Тэгээд надад тохиолдуулахыг хүсэхгүй байгаа тэр зүйлсийг өөрчилж чадна шүү дээ.”

“Гэвч тэгвэл тэд чиний ирээдүйн нэг хэсэг биш болно шүү дээ,” гэж төлөгч хэлэв.

“Тэгвэл би ирж байгаа зүйлд өөрийгөө бэлдэхийн тулд л ирээдүйг мэдэхийг хүсч байна.”

“Хэрвээ сайн зүйлс ирж байгаа бол тэд тааламжтай бэлэг болно,” гэж төлөгч хэллээ. “Хэрвээ муу зүйлс тохиолдох бөгөөд чи түүнийг урьдчилан мэдэх юм бол түүнийг тохиолдохоос ч өмнө маш ихээр шаналан зовох болно.”

“Би эр хүн учраас ирээдүйд юу болохыг мэдэхийг хүсч байна,” гэж тэмээ хөтлөгч төлөгчид хэлэв. “Эрчүүд үргэлж ирээдүйдээ суурилсан амьдралаар амьдардаг юм.”

Төлөгч мөчрөөр хийсэн саваагаар мэргэлдэг байсан бөгөөд тэднийгээ газарт орхин яаж унасныг нь харж байгаад тайлал хийв. Тэр өдөр төлөгч юм хэлсэнгүй. Төлөгч саваануудаа хэсэг даавуунд ороогоод цүнхэндээ хийлээ.

“Би хүмүүсийн ирээдүйг таамаглаж амьдралаа залгуулдаг,” гэж тэр хэллээ. “Би саваагаар мэргэлэх ухааныг мэднэ, тэднийг ашиглан хэрхэн бүхий л зүйл бичигдсэн тэр газар руу нэвтрэхийг мэднэ. Тэнд би өнгөрснийг уншиж, юу мартагдсан байсныг танин илрүүлж бас одоо болж байгаа зөн совингуудыг тайлж ойлгодог.”

“Хүмүүс надаар мэргэлүүлэхэд, би үнэндээ бол ирээдүйг уншаад байгаа юм биш, ирээдүйг би таамаглаж байгаа юм. Ирээдүй бол Бурханд хамаарах бөгөөд зарим маш чухал тохиолдолд л тэр үүнийг илчилдэг. Ирээдүйг би хэрхэн таамагладаг вэ? Одоогийн мөчид тохиолдож буй зөн совингуудад үндэслэдэг. Нууц нь яг энэ одоо цагт байдаг. Хэрвээ чи одоо болж буй бүхэнд анхаарал тавиж чадвал чи үүнийг сайжруулж болно. Хэрвээ чи одоо болж буй зүйлсийг сайжруулж чадвал ирээдүйд ирэх зүйл чинь мөн адил сайжрах болно. Ирээдүйн талаар мартаад өдөр бүрийг Бурхан өөрийн үрсээ хайрладаг гэсэн сургаалд

итгэлтэйгээр амьдар. Өдөр бүр өөртөө мөнхийн амьдралыг агуулсан байдаг юм.”

Тэмээ хөтлөгч ямар нөхцөлд Бурхан төлөгчид ирээдүйг харахыг зөвшөөрдөгийг нь асуусан юм. “Зөвхөн Бурхан өөрөө илчлэх үед. Бурхан маш ховор тохиолдолд л ирээдүйг илчилдэг юм. Хэрвээ илчилвэл зөвхөн ганцхан шалтгаанаар, энэ бол магадгүй өөрчлөгдөж болохоор бичигдсэн ирээдүй байдаг.”

Бурхан хүүд ирээдүйн нэгэн хэсгийг харуулсан байна гэж тэмээ хөтлөгч бодлоо. Яагаад тэр хүүг өөрийн элч болгохыг хүссэн юм болоо?

“Омгийн ахлагчдад очиж хэл,” хэмээн тэмээ хөтлөгч хэллээ. “Тэдэнд ойртон ирж буй дайсны талаар очиж хэл.”

“Тэд намайг шоолох болно.”

“Тэд бол цөлийн эрчүүд , цөлийн эрчүүд зөн совинг ажиглаж сурсан байдаг юм.”

“Тэгвэл тэд аль хэдийн мэдэж байгаа байлгүй дээ.”

“Тэд одоогоор түүнд анхаарал тавихгүй байгаа. Хэрвээ тэд ямар нэгэн зүйл мэдэх шаардлагатай болвол, Аллах бурхан ямар нэгэн зүйл тэдэнд мэдэгдэхийг хүсвэл хэн нэгэн тэдэнд энэ тухай хэлэх болно гэдэгт итгэцгээдэг. Энэ зүйл өмнө нь олон удаа тохиолдож байсан. Харин энэ удаад тэр хүн нь чи.”

Хүү Фатимагийн талаар бодлоо. Тэгээд тэр омгийн ахлагчид руу очихоор шийдлээ.

-***-

29 - р хэсэг

Хүү баянбүрдийн төвд байх том цагаан асрын өмнөх харуулд ойртон очлоо.

“Би ахлагчидтай уулзах гэсэн юм. Би цөлөөс зөн совингуудыг авчирлаа.” Харуул хариу хэлсэнгүйгээр асар руу орсон тул хүү тэнд хэсэг зогслоо. Тэр гарч ирэхдээ алтаар чимэглэсэн цагаан хувцас бүхий залуухан арабтай хамт гарч ирэв. Хүү тэр залууд харсан зүйлсээ яритал тэр хүүг эндээ хүлээж байхыг хүсээд асар руу буцан оров.

Шөнө боллоо, хоорондоо маргалдсан худалдаачид болон эрчүүд асарт орж гарсаар л байв. Нэг нэгээрээ түүдэг галууд унтарсаар баянбүрд яг цөлийн адил чимээгүй болов. Зөвхөн тэр том асрын гэрэл л үлдлээ. Энэ бүх хугацаанд хүү Фатимагийн талаар бодсоор байсан бөгөөд тэр одоог хүртэл хамгийн сүүлд түүнтэй өрнүүлсэн ярианы учрыг ойлгоогүй л байлаа. Хэдэн цаг хүлээсний эцэст харуул хүүг орохыг дохив. Хүү дотор ороод харсан зүйлдээ үнэхээр гайхлаа. Энэ элсэн цөлийн дунд ийм асар байна гэж хэзээ ч төсөөлж байсангүй. Шалыг нь хүүгийн өмнө нь алхаж байсан хивснүүдээс хамгийн үзэсгэлэнтэй хивсээр хучиж, асрын дээд хэсгээр алтаар хийсэн хоргонд лаанууд асаасан байлаа. Ахлагчид асрын хойморт хагас тойрог болон сууцгааж, уран шаглаа бүхий торгон дэрүүд дээр тухласан байв. Үйлчлэгчид мөнгөн дийзэн дээр амттан болон цай барьцгаан нааш цааш хөлхөлдөнө. Зарим үйлчлэгчид араб гаансан дахь галыг асаацгаана. Асрын доторх орчин утааны анхилам үнэртэй холилдон ууссан байлаа. Тэнд найман ахлагч байсан боловч хүү алт болон цагаан өнгөөр

хувцаслаж хагас тойргийн голд суусан арабыг тэдний хамгийн чухал хүн болохыг хараад л мэдэв. Түүний хажууд хүүтэй өмнө нь ярилцаж байсан нөгөө залуу араб байлаа.

“Зөн совингийн талаар ярьдаг энэ харийн хүн чинь хэн бэ?” гэж нэгэн ахлагч хүү рүү харан асуулаа. “Тэр бол би,” гэж хүү хариуллаа. Тэгээд тэр харсан зүйлээ ярилаа.

“Яагаад цөл биднийг энд удам дамжин амьдарсан гэдгийг мэдсээр байж тийм зүйлсийг харийн хүнд илчилдэг билээ?” гэж өөр нэг ахлагч хэлэв. “Яагаад гэвэл миний нүд одоохондоо цөлд дасч амжаагүй байна,” гэж хүү хэллээ. “Цөлд дасал болсон нүдээр харж чадаагүй зүйлсийг би харж болох юм.” Мөн бас яагаад гэвэл би Дэлхийн сүнсний талаар мэддэг болохоор гэж тэр дотроо бодлоо.

“Баянбүрд бол төвийг сахидаг газар. Хэн ч баянбүрд рүү дайрдаггүй,” гэж гутгаар ахлагч хэлэв. “Би зөвхөн харсан зүйлээ л та бүхэнд хэлж чадна. Хэрвээ та бүхэн надад итгэхийг хүсэхгүй бол энэ талаар юу ч хийх шаардлагагүй шүү дээ.”

Эрчүүд бие бие рүүгээ дохин ярилцаж эхлэв. Тэд хүүгийн ойлгохгүй араб хэллэгээр ярилцаж байсан ба хүү гарахыг завдтал харуул түүнийг байж байхыг сануулав. Хүүд айдас төрж эхэлсэн бөгөөд зөн совин түүнд ямар нэгэн зүйл буруу болсныг хэллээ. Тэр цөлд харсан зүйлийнхээ талаар тэмээ хөтлөгчтэй ярилцсандаа харамсаж байв. Гэнэт голд суусан настай ахлагч үл мэдэгдэм инээмсэглэсэнд хүүгийн дотор арай дээрдэв. Тэр хүн ярианд оролцохгүй байсан бөгөөд үнэндээ тэр мөчийг хүртэл нэг ч үг дуугараагүй билээ. Гэвч хүү Дэлхийн хэлний талаар ойлгож дассан тул тайван байдлын мэдрэмж асраар түгэхийг мэдэрч байв. Одоо түүнд энд ирсэн нь зөв хэмээн мэдрэгдэж байв. Хэлэлцүүлэг дууслаа. Ахлагчид нөгөө настай ахлагчийн хэлэхийг сонсоцгоон хэсэг чимээгүй болов. Тэгээд тэр хүн хүү рүү харав: энэ удаад тэр хүйтэн бас хөндий байдалтай байв.

“Хоёр мянган жилийн өмнө, нэгэн алс холын нутагт мөрөөдөлдөө итгэгч нэг эр гянданд хоригдож, боол болон зарагдсан түүхтэй,” гэж тэр настай хүн хүүд ойлгогдох аялгуугаар хэллээ. “Манай худалдаачид тэр эрийг худалдан аваад Египетэд авчирсан юм. Бид бүгдээрээ хэрвээ хэн нэгэн хүн мөрөөдөлд итгэдэг бол түүнийг хэрхэн тайлбарлахыг мөн мэдэх ёстой гэж боддог.” Тэгээд тэр настан үргэлжлүүлэн “Тэр үед Фарон тарга тэвээрэг сайтай үхэр болон туранхай үхрийн талаар зүүдэлсэн бөгөөд миний ярьж буй энэ хүн Египетийг өлсгөлөнд нэрвэгдэхээс аварсан билээ. Түүний нэрийг Жосеф гэдэг байсан. Тэр мөн чам шиг харийн хүн, харийн нутагт бас магадгүй чиний хирийн настай байсан болов уу.”

Тэр хэсэг саатав, түүний харц нь хүйтэн хөндий хэвээрээ л байлаа. “Бид үргэлж Уламжлалыг ажиглаж байдаг. Уламжлал тэр үед Египетийг өлсгөлөнгөөс аварч Египетчүүдийг хамгийн баян хүмүүс болгосон юм. Уламжлал эрчүүдийг хэрхэн цөлийг гатлахыг, хэрхэн тэдний үр сад, гэр бүл болж байхыг хэлдэг. Уламжлал баянбүрдийг дундын амгалан бүс гэж хэлдэг, учир нь хоёр тал хоёулаа баянбүрдүүдтэй, хоёулаа л аюулд учрах боломжтой.” Хэн ч үг дуугарсангүй, настан үргэлжлүүллээ. “Гэвч Уламжлал биднийг цөлийн мэдээнд итгэх ёстойг

мөн хэлдэг. Бидний мэдэх юм бүхэн цөлөөр заагддаг.” Настан дохио өгмөгц бүгд бослоо.

Зөвлөлгөөн дууслаа. Тамхи бүхий том гаанснуудыг унтрааж, харуулууд сонор сэрэмжтэйгээр зогсоцгоов. Хүү гарахаар бэлдсэн боловч настан ахин яриж эхлэв. “Маргааш бид баянбүрдийн хүмүүс зэвсэгтэй байж болохгүй гэсэн хоригийг зөрчих болно. Бүтэн өдрийн турш бид дайсан ирэхийг харан сэрэмжтэй байна. Нар шингэхэд бүх эрчүүд зэвсгээ надад буцаан хураалгана. Дайсны алагдсан арван хүн тутамд чамайг хэсэг алтаар шагнах болно.” “Гэхдээ зэвсэгийг тулаанд оруулалгүйгээр буцаан хуйлж болдоггүй. Зэвсэг бол цөлийн адил хилэнцэт хортой тул хэрвээ тэд ашиглагдаагүй бол дараагийн удаад ажиллахгүй байх боломжтой. Зэвсгийн аль нэг нь маргааш орой гэхэд ашиглагдахгүй бол нэгийг нь чамд хэрэглэх болно.”

Хүү асрыг орхин явахад баянбүрд зөвхөн бүтэн сарны гэрэлд туяаран байв. Тэр майхандаа хүртэл хориод минут явах зайтай агаад хүү тийшээгээ гэлдэрч байлаа. Сая тохиолдсон зүйлд хүү цочирдсон байв. Тэрээр Дэлхийн сүнсэнд амжилттай хүрч чадсан бөгөөд үүний төлөөс нь магадгүй түүний амьдрал байж болохоор байлаа. Энэ бол аймшигтай бооцоо байв. Гэвч хүү хонио заран Хувийн бахархалынхаа төлөө тэмцэж эхэлснээс хойш эрсдэлтэй алхмуудыг хийсээр ирсэн билээ. Тэгээд тэмээ хөтлөгчийн хэлснээр маргааш үхэх бол бусад өдөр үхэхээс тийм муу зүйл биш. Өдөр бүхэн л хэн нэгний амьдрах эсвэл энэ хорвоогоос буцахыг тэмдэглэдэг шүү дээ. Бүх л зүйл нөгөө үгээс хамаарах юм. “Мактүб.”

Нам гүм дунд ганцаар алхан байх зуур түүнд харамсах зүйл огтхон ч байхгүй байлаа. Хэрвээ тэр маргааш үхэх бол Бурхан ирээдүйг өөрчлөхийг хүсээгүй л гэсэн үг. Тэр үгүй ядахдаа тэнгисийн хоолойг гатлан, болор эдлэлийн дэлгүүрт ажиллаж, цөлийн нам гүм болон Фатимагийн нүдийг мэдрэсний дараа үхэх нь. Тэрээр гэрээ орхин гарснаас хойш өдөр бүрийг эрчимтэйгээр амьдарсаар ирсэн юм. Хэрвээ тэр маргааш үхэх юм бол тэр аль хэдийн бусад хоньчидоос илүүг харж үзсэн байх тул түүгээрээ бахархаж байв.

Гэтэл гэнэт түүнд аянга дуугарах мэт чимээ сонсогдож тэр өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй их салхины хүчинд цохигдон газарт уналаа. Орчин тойрны газарт хүчтэй тоос бужигнан сарны гэрлийг хааж орхив. Түүний өмнө асар том цагаан морь цоройн аймшигтай чангаар янцгаан байлаа. Нүд харанхуйлам тоос арай намдахад хүү харсан зүйлдээ салганан чичрэв. Морины нуруун дээр тас хараар хувцаслан зүүн мөрөн дээрээ шонхор шувуу суулгасан эр мордсон байлаа. Тэр турбан өмссөн бөгөөд нүднээс бусадаа хар өнгийн унжлагаар халхалсан байв. Түүнийг харахад цөлөөс ирсэн элч мэт байсан бөгөөд гэхдээ жирийн нэг элчийг бодоход илүү хүчирхэг сүртэй харагдаж байлаа. Үл таних морьтон эмээлэндээ бэхэлсэн хуйнаас асар том махир сэлэм сугалан гаргалаа. Сэлмийн ир нь сарны гэрэлд гялалзан харагдав.

“Харцагануудын нисэлтийг тайлан уншихийг зүрхэлсэн хүн хэн бэ?” гэж тэрээр маш чангаар Эл-Фаюум баянбүрдийн тавин мянган далдуу модод бүхэн давтан цуурайтах мэт шаардан асуулаа. “Би тэгж зүрхэлсэн билээ,” гэж хүү хэлэв. Хүү гэгээн Сантьяго Матаморос цагаан мориныхоо нуруун дээр мордоод туурайных нь доор бүдүүлэг омгийнхон сөхрөн байдаг зургийг эргэн саналаа.

Энэ эр яг түүн шиг харагдсан бөгөөд энэ удаад харин дүрүүд нь солигдсон болж байна.

“Би тэгж зүрхэлсэн билээ,” гэж хүү ахин хэлээд сэлмийн цохилтыг хүлээн авахаар толгойгоо бөхийлгөв. “Олон хүний амь аврагдах болно, учир нь би Дэлхийн сүнсэнд нэвтрэн харах боломжтой байсан билээ.” Сэлэм цавчсангүй. Харин түүний оронд үл таних эр сэлмээ алгуурхнаар доошлуулан үзүүрийг нь хүүгийн духанд хүргэв. Хүүгийн духнаас цус дуслав. Морьтон хөдөлгөөнгүй болсон бөгөөд хүү ч мөн адил хөдөлсөнгүй. Хүүд зугатаая гэсэн бодол ч ер төрсөнгүй. Зүрхнийхээ гүнд тэрээр хачирхалтай баярт мэдрэмжийг мэдрэн байлаа. Тэр өөрийнхөө Хувийн бахархалын эрэлд явсаар үхэхэд ойртож байна. Мөн Фатимагийн төлөө. Зөн совингууд эцсийн эцэст үнэн байж. Энд хүү дайсантайгаа нүүр тулан байгаа ч үхэхэд санаа зовох зүйл ер алга, Дэлхийн сүнс түүнийг хүлээж байгаа бөгөөд удалгүй хүү түүний нэгэн хэсэг болно. Тэгээд маргааш түүний дайсан нь мөн тэрхүү сүнсний нэгэн хэсэг болох болно.

Үл таних эр сэлмээ хүүгийн духанд хүргэсэн хэвээр л байлаа. “Чи яагаад шувуудын нислэгийг уншсан юм бэ?” “Би зөвхөн шувууд надад юу хэлэхийг хүссэнийг л уншсан. Тэд баянбүрдийг хамгаалахыг хүссэн. Маргааш танайхан бүгдээрээ үхэх болно, учир нь баянбүрдэд та нараас илүү олон эрчүүд бий.” Сэлэм байсан газраасаа хөдөлсөнгүй. “Аллах бурханы хүслийг өөрчлөх чи хэн бэ?” “Аллах бурхан цэргүүдийг мөн харцагуудыг бүтээсэн. Аллах бурхан надад шувуудын хэлийг заасан. Бүх зүйл нэгэн мутраар бичигдсэн,” гэж хүү тэмээ хөтлөгчийн үгийг санан хэллээ.

Үл таних эр сэлмээ хүүгийн духнаас буцаан авахад хүү тэр дороо тайвшрав. Гэвч тэр зугатааж чадахгүй л байлаа. “Чи өөрийнхөө таамаглалдаа болгоомжтой ханд,” гэж үл таних эр хэллээ. “Хэрвээ ямар нэг зүйл бичигдсэн бол түүнийг өөрчлөх ямар ч арга байдаггүй юм.” “Миний харсан бүх зүйл бол цэргүүд,” гэж хүү хэлэв. “Би тулааны үр дүнг хараагүй билээ.” Үл таних эр хариултанд сэтгэл нь ханасан бололтой байв. Гэвч тэр сэлмээ гартаа атгасаар л байлаа.

“Үл таних хүн чи харийн нутагт юу хийж яваа билээ?”

“Би өөрийн Хувийн бахархалаа биелүүлэхийн төлөө явж байна. Энэ бол таны ойлгох зүйл биш л дээ.” Үл таних эр сэлмээ буцаан хуйнд нь хиймэгц хүү бүр тайван болов.

“Би чиний эр зоригийг шалгах шаардлагатай байлаа,” гэж үл таних эр хэлэв. “Эр зориг бол Дэлхийн хэлийг ойлгоход хамгийн чухал шаардлагатай зан чанар.”

Хүү ихэд гайхав. Үл таних эр маш цөөхөн хүмүүсийн мэддэг зүйлийг ярьж байлаа. “Чи ийм хол явсан ч гэлээ хэрхэвч зөөлөрч болохгүй,” гэж тэр өгүүллээ. “Чи цөлийг хайрлах ёстой ч гэсэн хэзээ ч бүрэн итгэж болохгүй. Яагаад вэ гэвэл цөл бүх эрчүүдийг сорьдог бөгөөд алхам бүрийг нь шалган, сатаарсныг нь хөнөөж орхидог юм.” Түүний хэлсэн үг хүүд настай хаантныг санагдуулж байв. “Хэрвээ дайсны цэргүүд маргааш ирээд нар шингэх үед чиний толгой мөрөн дээрээ байж байх юм бол намайг хайгаад очоорой,” гэж үл таних эр хэллээ.

Түрүүний сэлэм барьж байсан гар одоо ташуур атгалаа. Морь нь ахин цоройн бөөн тоос бужигнуулав.

“Та хаана амьдардаг юм бэ?” гэж хүү морьтныг цааш давхих зуур хашгирлаа.

Ташуур барьсан гар өмнө зүгийг заав.

Хүү Алхимичтэй уулзсан байлаа.

30 - р хэсэг

Маргааш өглөө нь хоёр мянган зэвсэглэсэн эрчүүд Эл-Фаяум баянбүрдийн дал модод дунд таран бүглээ. Нар хамгийн өндөр цэгтээ хүрэхээс өмнө таван зуу гаруй цөлийн эрчүүдийн бараа үзэгдэв. Тэр цэргүүд баянбүрдийн хойд талаас ирсэн бөгөөд найрсаг зочлолт мэт харагдаж байсан ч гэлээ тэд зэвсгээ хувцасныхаа цаана нууцгаасан байлаа.

Тэд баянбүрдийн голд байх цагаан асарт хүрмэгц буу зэвсгээ гарган ирцгээлээ. Тэгээд тэд эзэнгүй асар руу дайран орцгоов. Баянбүрдийн эрчүүд тэднийг цөл талаас бүслэн хагас цагийн дотор зөвхөн нэг халдан ирэгчээс бусад нь амь үрэгдэв.

Хүүхдүүдийг далдуу модод бүхий гүвээний цаана аваачсан байсан тул болсон явдлын талаар юу ч харцгаасангүй. Эмэгтэйчүүд майхнууддаа үлдэцгээн эрчүүдийнхээ төлөө залбирцгааж байсан тул тулааны талаар мөн харцгаагаагүй билээ. Газарт байх цогцосуудыг эс тооцвол баянбүрдийн жирийн нэг өдөр мэт л байлаа.

Амьд үлдээсэн цор ганц хүн бол цэргүүдийн ахлагч байв. Үдээс хойш түүнийг омгийн ахлагчидын өмнө авчран яагаад Уламжлалыг зөрчсөнийг нь асуув. Тэрхүү ахлагч хэлэхдээ түүний цэргүүд олон хоногийн тулаанд туйлдан, өлсөж цангацгаасан байсан тул баянбүрдийг эзлэн авч буцан байлдах хүчээ сэлбэхээр шийдсэн гэлээ. Омгийн ахлагч нар түүний цэргүүдийн төлөө харамсал илэрхийлээд Уламжлалыг ямар ч үед хүндэтгэх ёстойг сануулав.

Тэд цэргүүдийн ахлагчийг нэр төргүйгээр үхэх ял оноолоо. Сумаар юмуу сэлмээр егүүтгэхийн оронд түүнийг хувхай дал модноос дүүжлэн түүний цогцос нь цөлийн салхинд ганхан байх болно. Омгийн ахлагчид хүүг дуудан авчирч тавин хэсэг алт өгөв. Тэр Жосефийн тухай түүхийг дахин өгүүлээд хүүг баянбүрдийн хүндэт зөвлөх болох санал тавилаа.

31 - р хэсэг

Нар жарган анхны одод түгэж эхлэх тэр үед хүү өмнө зүгийг чиглэн алхлаа. Явсаар бусдаас онцгой байх нэг майхныг олж харсан бөгөөд хажуугаар зөрж өнгөрсөн арабууд тэр майханд шидтэн амьдардаг гэдгийг хэллээ. Хүү тэнд суугаад хүлээв.

Сар дээр хөөрөхөөс өмнө алхимич хүрч ирэв. Тэр агнасан хоёр харцагаа мөрөн дээрээ тохсон байлаа.

“Би энд байна,” гэж хүү хэллээ.

“Чи энд байх ёсгүй л баймаарсан,” гэж алхимич хариулаад “Аль эсвэл чиний Хувийн бахархал энд хөтлөж ирэв үү?”

“Омгуудын хооронд дайн гарснаас цөлийг гатлах боломжгүй болсон билээ. Тэгээд л би энд ирсэн юм.”

Алхимич мориноосоо буун хүүг хамтдаа майханд орохыг дохив. Майхан нь баянбүрдэд байх бусад майхнууд шиг л майхан байв. Хүү эргэн тойрондоо алхимид хэрэглэгддэг зуух болон бусад төхөөрөмжүүдийг хайсан боловч юу ч олсонгүй. Тэнд ердөө хэсэг ном өрсөн, бас нэг жижиг зуух, этгээд хачин хээ бүхий хивснүүд л байв.

“Суу даа. Хоёулаа жаал юм уугаад энэ харцагануудаар хоол хийж идье,” гэж алхимич хэллээ. Хүү тэдгээрийг өчигдрийн харсан харцаганууд байх гэж таамагласан боловч юм дуугарсангүй. Алхимич галаа асаан, удалгүй хамар цоргисон сайхан үнэр майхнаар дүүрэв. Энэ нь гаансны гашуун үнэрээс илүү сайхан байлаа.

“Та яагаад надтай уулзахыг хүссэн юм бэ?” гэж хүү асуулаа. “Яагаад вэ гэвэл зөн совингуудаас болоод.” гэж Алхимич хариулав. “Салхи надад чамайг ирж байгааг мөн чамд тусламж хэрэг болохыг хэлсэн юм.”

“Салхи миний тухай яриагүй болов уу. Тэр бол харийн англи эр. Таныг хайж байгаа хүн тэр билээ.”

“Түүний хувьд өөр зүйлсийг эхлээд хийх шаардлагатай. Гэхдээ тэр зөв замаар явж байгаа. Тэр цөлийг ойлгохоор оролдож эхэлсэн.”

“Миний хувьд та юу хэлэх вэ?”

“Хэрвээ хүн ямар нэг зүйлийг үнэхээр хүсвэл бүх л ертөнц түүнийг мөрөөдлөө биелүүлэхэд нь тусалдаг юм.” гэж алхимич настай хаантны үгийг давтан хэллээ.

Хүү ойлгов. Түүнийг Хувийн бахархалаа биелүүлэх замд нь өөр нэгэн туслах ёстой аж. “Тэгэхээр та надад заавар өгөх үү?”

“Үгүй. Чи өөрөө мэдэх шаардлагатай бүхнийг аль хэдийн мэдсэн. Би чамайг өөрийн баялгийн чинь зүг чиглүүлж өгөх болно.”

“Гэвч омгуудын хооронд дайн болж байна,” гэж хүү дахин хэлэв.

“Би цөлд юу болж байгааг мэдэж байна.”

“Би аль хэдийн өөрийнхөө баялгийг олсон. Надад тэмээ, болор эдлэлийн дэлгүүрээс олсон мөнгө бас тавин хэсэг алт байна. Нутагтаа бол би баян хүнд тооцогдох болно.”

“Гэвч чи алиныг нь ч Пирамидуудаас олоогүй шүү дээ,” гэж алхимич хэллээ.

“Надад бас Фатима байна. Тэр бол миний олсон юм бүхнээс илүү эрдэнэс минь.”

“Түүнийг ч гэсэн бас л Пирамидуудаас олоогүй шүү дээ.”

Тэд чимээгүйгээр хооллолцгоолоо. Алхимич нэгэн лонх онгойлгон улаан шингэн хүүгийн аяга руу хийв. Энэ бол хүүгийн амсаж байсан хамгийн амттай дарс байлаа.

“Дарсыг энд хориглодог биш билүү?” гэж хүү асуулаа.

“Эр хүний ам руу орж байгаа нь ад чөтгөр биш юм,” гэж алхимич хэлээд “Түүний амнаас гарч байгаа нь ад чөтгөр.”

Алхимич бага зэрэг аймаар санагдаж байсан ч хүү дарс уугаад тайвшрав. Тэд хооллож дууссанаа дараа майхны гадна ододыг ч бүдэг мэт харагдуулах гэрэлт сарны доор сууцгаав.

“Уу өөрийгөө баясга,” гэж алхимич хүүг жаргалтай байгааг ажиглангаа хэллээ.

“Өнөө шөнө дайнд бэлдэж буй дайчны адилаар сайхан амарч хоно. Хаана чиний зүрх байна, тэндээс чи баялгаа олох болно гэдгийг санаж яваарай. Чи баялгаа хайх ёстой, тэгэхээр чиний замдаа сурсан бүхэн чинь утга учиртай болж ирнэ. Маргааш тэмээгээ зараад морь худалдаж ав. Тэмээнүүд хуурамч байдаг: тэд хэдэн мянган алхам ядарсан шинжгүй алхацгаана. Тэгээд гэнэтхэн л тэд өвдөг сөхрөх бөгөөд амь тавьдаг. Харин морь бага багаар ядарна. Чи тэднээс хир ихийг шаардахаа үргэлж мэдэж чадна, тэгээд тэд хэзээ амь тавихад ойртсон байна гэдгийг ч мэдэх болно.”

-***-

32 - р хэсэг

Маргааш орой нь хүү алхимичийн майханд морь унан хүрч ирэв. Алхимич бэлэн байсан бөгөөд өөрийн аргамаг хүлэгэндээ мордон шонхороо зүүн мөрөн дээрээ суулгав. Тэр хүүд “Цөлд хаана амьдрал байгааг надад харуул. Зөвхөн амьдралын тэрхүү тэмдэгнүүдийг ажиглагчид л баялгийг олох чадвартай байдаг” хэмээлээ.

Тэд элсэн толгодын оройгоор явах зуур сар тэдний замыг гэрэлтүүлэн байлаа. Би цөлөөс амьдрал олох чадвартай эсэхээ мэдэхгүй байна даа гэж хүү бодов. Би цөлийг тийм сайн мэдээгүй байгаа шүү дээ. Тэр энэ тухай алхимичид хэлэхийг хүссэн боловч хүү түүнээс эмээж байлаа. Тэд хүүгийн харцагануудыг тэнгэрт харсан хадархаг газар хүрч очсон бөгөөд одоо энд зөвхөн нам гүм болон салхи л эзэгнэн байлаа.

“Би цөлд амьдралыг хэрхэн хайж олохоо мэдэхгүй байна,” гэж хүү хэллээ. “Би энд амьдрал байгаа гэдгийг мэдэж байвч хаанаас хайхаа мэдэхгүй байна.”

“Амьдрал амьдралаа татдаг юм,” гэж алхимич хариулав. Тэгмэгц хүү ойлголоо. Тэр мориныхоо хазаарыг султгахад морь нь хад болон элсний дээгүүр урагш тэмүүлэн явав. Алхимич хүүгийн морийг хагас цаг шахам даган явлаа. Тэд баянбүрдийн дал мододоос хараа тасарсан бөгөөд зөвхөн асар том сар дээр нь гэрэлтүүлж түүний мөнгөлөг туяа нь цөлийн чулуунууд дээр тусан ойсон байлаа.

Гэнэтхэн тодорхой шалтгаангүйгээр хүүгийн морь удааширч эхлэв. “Энд амьдрал байна,” гэж хүү алхимичид хэллээ. “Би цөлийн хэлийг мэдэхгүй ч миний

морь амьдралын хэлийг мэдэж байна.” Тэд мориноосоо бууцгаалаа, алхимич юм дуугарсангүй. Аажуухан алхсаар тэд чулуунуудын дундуур хайцгаав.

Алхимич гэнэт зогсоод газар руу бөхийв. Чулуунуудын дунд нэгэн нүх байлаа. Алхимич гараа нүхэнд шургуулснаа, улам цаашлуулан мөрөө хүртэл хийв. Ямар нэг зүйл тэнд хөдлөж байсан бөгөөд хүү алхимичийн нүднээс хичээж байгааг нь харж байв. Түүний гар нь нүхэн дотор ямар нэг зүйлтэй тэмцэлдэн байгаа мэт байлаа. Тэгээд хүүг гайхашруулсан хөдөлгөөнөөр тэр гараа сугалаад хөлдөө авчрав. Тэр гартаа нэгэн могойг сүүлнээс нь атгасан байлаа. Хүү мөн адил дэвхрэн алхимичаас жаал холдов. Могой галзуу мэт тэмцэлдэн цөлийн нам гүмийг зүссэн исгэрэх чимээ гарган байлаа. Энэ бол хүнийг хэдхэн хоромд үхүүлж чадах хор бүхий наж могой байлаа.

“Түүний хорноос болгоомжил,” гэж хүү хэлэв. Гэхдээ алхимич нүхэнд гараа шургуулсан байх үедээ аль хэдийн хатгуулсан байж болох ч гэлээ тайван харагдаж байв. “Алхимич хоёр зуун настай,” гэж англи эр түүнд хэлсэн билээ. Тэр цөлийн могойнуудтай хэрхэн харилцахаа мэдэх ёстой. Хүү алхимичийг морь руугаа очин тахир сэлмээ авчрахыг нь харж байлаа. Сэлмийн үзүүрээр тэр элсэн дээр тойрог зураад могойг дотор нь тавив. Могой тэр дороо тайвширлаа.

“Бүү санаа зов,” гэж алхимич хэллээ. “Тэр тойргоос гарахгүй. Чи цөлөөс амьдрал олж надад хэрэгтэй байсан зөн совинг харууллаа.”

“Яагаад тэр ийм чухал байсан юм бэ?”

“Яагаад вэ гэвэл Пирамидууд цөлөөр хүрээлэгдсэн байдаг.”

Хүү Пирамидуудын талаар ярихыг хүссэнгүй. Түүний зүрх нь хөндүүр байсан бөгөөд урьд шөнөөс хойш уйтгарлан байгаа билээ. Өөрийн баялгийнхаа төлөө үргэлжлүүлнэ гэдэг нь Фатимаг орхиж явна гэсэн үг юм. “Би чамайг цөлөөр газарчлах болно,” гэж алхимич хэлэв.

“Би баянбүрдэд үлдмээр байна,” гэж хүү хариуллаа. “Би Фатимаг олсон, миний бодлоор тэр баялгаас илүү үнэтэй.”

“Фатима бол цөлийн эмэгтэй,” гэж алхимич хэлэв. “Тэр эрчүүд буцаж ирэхийн тулд аянд явах ётой гэдгийг мэднэ. Тэгээд тэр аль хэдийн баялгаа олсон, тэр нь чи. Одоо тэр чамайг хайж байгаа зүйлээ олохыг хүсч байгаа.”

“Тэгвэл, хэрвээ би үлдэхээр шийдвэл яах вэ?”

“Чамд юу тохиолдохыг хэлэхийг минь сонсоно уу. Чи баянбүрдийн хүндэт зөвлөх болно. Чамд олон хонь болон тэмээд худалдан авахад хангалттай алт байна. Чи Фатиматай гэрлэх бөгөөд та хоёр жилийн турш жаргалтай байна. Чи цөлийг хайрлаж сурна, чи эндхийн тавин мянган мод нэг бүрийг мэддэг болно. Тэднийг ургаж байгааг чи харж дэлхий ертөнц үргэлж өөрчлөгдөж байдгийг анзаарна. Мөн чи зөн совинг ойлгохдоо илүү сайн болох бөгөөд учир нь цөл хамгийн сайн багш юм.”

“Хоёр дахь жилд нь чи баялгийн тухай эргэн санах болно. Зөн совингууд үүний тухай завсаргүй ярих ба чи үл тоохыг оролдоно. Чи өөрийн мэдлэгээ баянбүрдийн тайван амгалан болон оршин суугчдын төлөө ашиглах болно. Омгийн ахлагчид чиний хийж байгаа зүйлд талархана. Тэгээд чиний тэмээнүүд чамд эд баялаг болон эрх мэдэл, хүч авчирна.”

“Гурав дахь жилийн туршид зөн совингууд чиний баялаг болон Хувийн бахархалын тухай үргэлжлүүлэн ярих болно. Чи шөнөөр, баянбүрдээр алхах бөгөөд үүнд Фатима аз жаргалгүй байна яагаад вэ гэвэл тэр чиний эрлийг тасалдуулсан нь би шүү дээ гэж өөртөө мэдрэх болно. Гэвч чи түүнийг хайрлана оронд нь тэр бас чамайг хайрлана. Чи түүнийг чамайг үлд гэж хэлээгүйг эргэн санана яагаад гэвэл цөлийн бүсгүйчүүд өөрийн эрээ хүлээх ёстой гэдгийг мэддэг. Тийм болохоор чи түүнийг зэмлэхгүй. Гэвч олон удаа чи цөлийн элсээр алхан, магадгүй би явсан бол Фатимаг хайрласан хайрандаа илүү их итгэсэн бол гэж бодох болно. Яагаад гэвэл чамайг баянбүрдэд үлдээсэн зүйл нь чиний өөрийн би ахиж буцан ирэхгүй байж магадгүй гэсэн айдас юм. Тэр цагт зөн совингууд чамд чиний баялаг үүрд булшлагдсан гэдгийг хэлэх болно.”

“Тэгээд дөрөв дахь жилийн тэртээ зөн совингууд чамайг орхих болно, учир нь чи тэднийг сонсохоо болино. Омгийн ахлагчид үүнийг харах бөгөөд чамайг хүндэт зөвлөхөөс чинь огцруулна. Гэвч тэр үед чи олон тэмээтэй, эд бараа ихтэй баян худалдаачин болсон байна. Чи үлдсэн амьдралаа Хувийн бахархалаараа замнаагүй бөгөөд одоо хэтэрхий оройтсон байна гэдгээ мэдэрсээр өнгөрөөх болно.”

“Чи хайр хэзээ ч эр хүнийг Хувийн бахархалаараа замнахад нь саад болдоггүй гэдгийг ойлгох ёстой. Хэрвээ тэр тэрхүү оролдлогоосоо няцвал энэ нь жинхэнэ хайр ... Дэлхийн хэлээр ярилцдаг тэр хайр биш гэсэн үг юм.”

Алхимич элсэн дээрх тойргийг арилгахад могой хадан дундуур мөлхөн алга боллоо. Хүү Мекка явахыг үргэлж хүсдэг нөгөө болрын худалдаачны тухай бас алхимичийн эрэлд явсан англи эрийн тухай эргэн дурслаа. Тэр бас цөлд итгэдэг бүсгүйн тухай бодлоо. Тэгээд тэр хайртай бүсгүйтэй нь учруулсан цөлийн зүг ширтлээ. Тэд мориндоо мордоцгоож энэ удаад хүү алхимичийг даган баянбүрдийн зүг явав. Салхи баянбүрдийн чимээг авчирч хүү Фатимагийн дуу хоолойг сонсохыг хичээж байлаа. Тэр шөнө хүү тойрогт орсон наж могойг харж байх зуур мөрөн дээрээ шонхор суулгасан жигтэй эр хайр, баялаг, элсэн цөлийн бүсгүй болон түүний Хувийн бахархалын талаар ярьсан билээ.

“Би таньтай хамт явна,” гэж хүү хэллээ. Тэгээд тэр тэрхэн дороо зүрх нь тайвширч амгалан болохыг мэдрэв.

“Бид маргааш өглөө нар мандахаас өмнө хөдлөх болно,” гэсэн нь алхимичийн хэлсэн цорын ганц хариу байлаа.

-***-

33 - р хэсэг

Хүү шөнийг унталгүй өнгөрүүллээ. Үүр цайхаас хоёр цагийн өмнө тэр майханд унтаж байгаа хөвгүүдийн нэгийг Фатима хаана амьдардагийг заалгахаар сэрээв. Тэд Фатимагийн майхан руу явсан бөгөөд хүү түүнд хонь худалдаж авахад хангалттай алт өгөв. Тэгээд хүү түүнийг Фатимагийн унтаж байгаа майханд ороод түүнийг сэрээж хүүг гадаа хүлээж байгаа гэдгийг хэлэхийг хүслээ. Залуу араб хүүгийн хэлснийг гүйцэтгээд ахин нэг хонь авахад хангалттай алт авлаа.

“Одоо биднийг орхино уу,” гэж хүү залуу арабд хэлэв. Араб эр баянбүрдийн хүндэт зөвлөхөд тусалсан бас хэсэг хонь худалдаж авах мөнгөтэй болсондоо баяртайгаар майхандаа очиж унтахаар буцлаа. Фатима майхны үүдээр гарч

ирэв. Тэр хоёр дал мододын дундуур алхлаа. Хүү энэ бол Уламжлалд харш зүйл гэдгийг мэдэж байсан хэдий ч энэ нь одоо түүнд хамаагүй билээ.

“Би явах гэж байна,” гэж тэр хэлэв. “Тэгээд би эргэж ирнэ гэдгийг чамайг мэдээсэй гэж хүсч байна. Би чамд хайртай яагаад гэвэл ...”

“Юу ч битгий хэл,” гэж Фатима үгийг нь тасалдуулав. “Хүн хайртай болдог яагаад вэ гэвэл хайртай болохоороо. Хайрлахад шалтгаан хэрэггүй.”

Гэвч хүү үргэлжлүүлэн “Надад мөрөөдөл байсан тэгээд би хаантантай уулзсан. Би болор эдлэл худалдаалсан бас цөлийг гаталсан. Омгууд хоорондоо дайн зарласан байсан тул би булаг руу алхимичийг хайхаар явсан. Тэгээд би чамд хайртай яагаад вэ гэвэл бүх л ертөнц чамайг олоход надад тусалсан.”

Тэр хоёр тэврэлдлээ. Энэ бол анх удаагаа тэр хоёр бие биедээ хүрсэн нь байлаа.

“Би буцаж ирэх болно,” гэж хүү хэллээ.

“Үүнээс өмнө би цөлийг үргэлж сэтгэл түгшин ширтдэг байсан,” гэж Фатима хэллээ. “Одоо харин итгэл өвөрлөн харах болно. Миний аав нэг өдөр алсад явсан боловч ээжид минь буцан ирсэн ба түүнээс хойш тэр үргэлж л буцаж ирдэг болсон.”

Тэд ахиж юм ярилцсангүй. Тэд дал мододын дундуур цааш жаахан алхаж байгаад хүү түүнийг майхны үүдэнд нь хүргэж ирлээ.

“Би чамдаа яг л танай аав ээжид чинь буцаж ирсэн шиг ирэх болно,” гэж хүү хэлэв. Тэр Фатимагийн нүд нулимсаар дүүрсэн байхыг харлаа.

“Чи уйлж байна шүү дээ?”

“Би бол цөлийн бүсгүй,” гэж тэр хэлээд нүдээ цавчлав. “Гэвч юунаас түүнд би эмэгтэй хүн.”

Фатима майхандаа буцан орсон бөгөөд гэгээ ороход тэрээр өдөр бүхэн хийдэг зүйлсээ хийхээр гарлаа. Гэвч юм бүхэн өөрчлөгдсөн байлаа. Хүү баянбүрдэд байхгүй ба баянбүрд ердөө өчигдөр байсантайгаа адил утгатай ахиж хэзээ ч байхгүй билээ. Баянбүрд тавин мянган дал модод, гурван зуун булагтай мөргөлчид ирж урт хугацааны аяллын алжаалаа тайлдаг газар биш болжээ. Энэ өдрөөс эхлээд баянбүрд түүний хувьд эзгүй газар мэт. Энэ өдрөөс эхлээд цөл түүнд чухал болсон юм.

Тэр өдөр бүр цөлийг ширтэн хүү өөрийн эрдэнэсийн эрэлдээ аль одыг даган явж байгааг таахыг хичээх болно. Тэр үнсэлтээ салхиар дамжуулан хүүгийн хацарт хүрээсэй гэж найдан түүнийг амьд байгаа гэдгийг дамжуулаарай хэмээн илгээх болно. Тэр хүүг хүлээж, өөрийн баялгийнхаа эрэлд явж байгаа зоригт эрийг хүлээж буй бүсгүй юм. Тэр өдрөөс эхлээд цөл түүнд зөвхөн ганц зүйлийг л, хүүг эргэж ирнэ гэсэн найдварыг л дүрслэх болно.

“Ард орхисон зүйлийнхээ тухай бүү бод,” гэж алхимич цөлийн элсэн дундуур аялах зуураа хүүд хэллээ. “Бүх зүйл Дэлхийн сүнсэнд бичигдсэн бөгөөд тэндээ үүрд хадгалагдах болно.”

“Эрчүүд аянд мордохоосоо илүүтэйгээр харих тухайгаа боддог,” гэж хүү хэллээ. Тэр аль хэдийн цөлийн нам гүмд ахин дасал болсон байлаа.

“Хэрвээ чиний олсон зүйл чинь хольцгүй цэвэр зүйлээс бүтсэн бол хэзээ ч зэврэхгүй. Тэгэхээр хүн үргэлж буцаж очиж болно. Хэрвээ чиний олсон зүйл чинь зөвхөн гэрлийн хором, яг л одны харвалтын гялбаа шиг байвал чи буцахдаа юу ч олохгүй.” Тэр алхимийн хэлээр ярьж байлаа. Гэвч хүү түүнийг Фатимагийн талаар ярьж байгааг мэдэж байв.

Ард орхисон зүйлээ бодохгүй байх гэдэг нь хэцүү зүйл байлаа. Цөл, түүний төгсгөлгүй нэгэн хэвийн байдал нь хүүг мөрөөдөхөд хүргэнэ. Хүү дал мододыг, булагнуудыг бас хайртай бүсгүйнхээ царайг харсаар л байв. Тэр бас англи эрийг туршилтаа хийж байгааг бас өөрөө ч мэдэлгүй энэ ухааны багш болсон тэмээ хөтлөгчийг харж байлаа. Магадгүй алхимич хэзээ ч дурлаж байгаагүй байх гэж хүү бодлоо.

Алхимич шонхороо мөрөн дээрээ суулган хүүгийн өмнө явна. Шонхор нь цөлийн хэлийг сайн мэдэх бөгөөд тэд амрах бүрт ан хийхээр нисэн одно. Эхний өдөр тэр туулай авчирсан бөгөөд дараагийн өдөр нь хоёр шувуутай ирсэн юм. Шөнө тэд хөнжилөө дэвсэн галаа нууцаар түлэх бөлгөө. Цөлийн шөнүүд хүйтэн болсоор сарны эргэлтийг даган улам бүр харанхуй болсоор байлаа. Тэд долоо хоногийн турш аялахдаа омгуудын хооронд өрнөсөн тулаанаас зайлсхийхийн тулд шаардлагатай алхмуудын тухай л зөвхөн ярилцаж байв. Байлдаан үргэлжилсээр заримдаа салхи цусны нялуун, бөөлжис цутгамаар үнэрийг авчирна. Тулаанууд тэдэнтэй ойрхон болж байсан бөгөөд салхи хүүд зөн совингийн хэл байдаг гэдгийг түүний нүдээрээ ажиглаж чадаагүй зүйлсийг харуулахад үргэлж бэлэн байдаг гэдгийг сануулж байв.

Долоо дахь өдөр алхимич ердийнхөөсөө илүү эрт буудаллахаар шийдэв. Шонхор ан хийхээр нисэн одож алхимич хүүд өөрийнхөө усны дашмагийг өглөө.

“Чи өөрийн аялалынхаа төгсгөлд нь бараг ирчихээд байна,” гэж алхимич хэллээ. “Чамайг Хувийн бахархалынхаа замаар замнасанд баяр хүргэе.”

“Та надад энэ хугацаанд юу ч хэлсэнгүй шүү дээ,” гэж хүү хэлэв. “Би таныг өөрийнхөө мэддэг зүйлсээс заримыг нь заах болов уу гэж бодсон. Хэсэг хугацааны өмнө би цөлөөр алхимийн номнуудтай хүнтэй хамт аялж байсан боловч тэднээс ямар нэгэн зүйл сурах чадваргүй байсан билээ.”

“Сурах ганц л арга байдаг юм,” гэж алхимич хариулав. “Энэ бол үйл ажиллагаагаар. Чи аяллынхаа туршид мэдэх шаардлагатай бүхнээ сурсан. Одоо чи зөвхөн нэг зүйлийг л сурах дутуу байна.”

Хүү тэр зүйл нь юу болохыг мэдэхийг хүссэн боловч алхимич тэнгэрийн хаяаг ширтэн шонхороо хайж байв.

“Яагаад таныг алхимич гэж дууддаг юм бэ?”

“Яагаад вэ гэвэл би тийм болохоор.”

“Тэгвэл алт гаргаж авахаар оролдсон боловч хийж чадаагүй бусад алхимичдын хувьд юу нь буруу болсон юм бэ?”

“Тэд зөвхөн алтыг хайж байсан,” гэж хүүгийн хамтрагч нь хариуллаа. “Тэд өөрсдийн Хувийн бахархалын баялгаа, Хувийн бахархалаараа амьдрахыг хүсэлгүйгээр хайцгаасан байдаг юм.”

“Миний мэдэх шаардлагатай тэр зүйл юу вэ?” гэж хүү асуулаа.

Гэвч алхимич үргэлжлүүлэн тэнгэрийн хаяа руу харсаар байлаа. Эцэст нь шонхор тэдний зоогийг авчирав. Тэд дөлний гэрлийг харагдуулахгүйн тулд нүх ухаж галаа түүндээ асаалаа. “Би бол алхимич зүгээр л би алхимич учраас,” гэж алхимич хоол бэлдэх зуураа хэлэв. “Би энэ ухааныг өвөөгөөсөө, өвөө маань ааваасаа гэх мэтчилэн уламжилсаар ертөнцийн үүсэл хүртэл үргэлжилсэн. Тэр цагт Мастер бүтээл ердөө маргад эрдэнэ дээр бичиж болохоор хялбар байжээ. Гэвч хүмүүс хялбар энгийн зүйлсийг тоомсорлохоо болиж нууцлал, орчуулгууд, гүн ухааны судалгааг бичиж эхэлсэн. Тэд бас бусдаас илүү арга замыг мэдэж буй мэтээр бодоцгоож эхэлцгээсэн байна. Гэлээ гэхдээ Маргад эрдэнийн хүснэгт одоо ч гэсэн амьд байдаг.”

“Маргад эрдэнийн хүснэгтэн дээр юу бичигдсэн байдаг юм бэ?” хэмээн хүү мэдэхийг хүслээ. Алхимич элсэн дээр зурж эхлэн, зургаа таван минут хүрэхгүй хугацаанд дуусгав. Түүнийг зурж байх хооронд хүү настай хаантны талаар түүнтэй зах дээр уулзаж байсан тухайгаа бодож байсан бөгөөд тэр явдал олон жилийн өмнө болсон мэт санагдаж байлаа.

“Энэ бол Маргад эрдэнийн хүснэгтэн дээр бичигдсэн зүйл,” гэж зурж дуусмагцаа алхимич хариуллаа. Хүү элсэн дээр юу бичигдсэнийг уншихаар хичээв.

“Энэ нууц түлхүүр байна,” гэж хүү гунигтайгаар хэлэв. “Энэ бол англи эрийн номон дээрээс харсантай ижилхэн зүйл бололтой.”

“Үгүй,” хэмээн алхимич хариуллаа. “Энэ бол яг тэр хоёр харцагын нислэг шиг, зөвхөн шалтгааныг дангаар нь ойлгож болохгүй зүйл. Маргад эрдэнийн хүснэгт бол Дэлхийн сүнсэнд нэвтрэх шууд хаалга юм.”

“Мэргэн ухаантнууд энэ бодит хорвоо бол диваажингийн дүрслэл бөгөөд хуулбар юм гэдгийг ойлгоцгоосон. Энэ ертөнц оршин байна гэдэг нь ердөө төгс орчлон оршин байдаг гэдгийн баталгаа юм. Бурхан дэлхийг бүтээхдээ, түүний үзэгдэх бодит зүйлсээр хүмүүст өөрийн цэцэн ухааны гайхамшиг болон оюунлаг сургаалуудыг ойлгуулах гэсэн билээ. Түүнийг л би зөвхөн үйл ажиллагаагаар сурдаг гэж хэлээд байгаа юм.”

“Би Маргад эрдэнийн хүснэгтийг ойлгох ёстой юу?” гэж хүү асуулаа.

“Магадгүй, чи алхимийн лабораторид байсан бол Маргад эрдэнийн хүснэгтийг судлаж эхлэх тохиромжтой цаг байж болох юм. Гэвч чи одоо цөлд байна. Тиймээс өөрийгөө цөлд уусга. Цөл чамд дэлхийн тухай ойлголтыг өгч чадна, үнэндээ дэлхий дээр байгаа дурын зүйл бүхэн үүнийг илэрхийлнэ. Чи цөлийг ч ойлгох шаардлагагүйгээр зөвхөн элсний ширхэгийг тунгаан бодоход л ертөнцийн үүслийн гайхамшигийг олж харах болно.”

“Хэрхэн би өөрийгөө цөлд уусгах вэ?”

“Зүрхээ чагна. Тэр бүх зүйлийг мэддэг яагаад вэ гэвэл тэр Дэлхийн сүнснээс ирсэн бөгөөд нэг өдөр тийшээгээ буцах болно.”

-***-

35 - р хэсэг

Тэд цөлөөр ахин хоёр өдрийн турш нам гүмхэн аяллаа. Алхимич улам илүү хянуур болсон бөгөөд учир нь тэд хамгийн ширүүн тулаан болж байгаа хэсгүүд рүү дөхөж байлаа. Аялах зуураа хүү өөрийнхөө зүрхийг чагнахыг оролдож байв. Энэ нь тийм ч хялбар зүйл биш байлаа, эхэндээ түүний зүрх нь үргэлж л өөрийн түүхийг ярихад бэлэн байсан боловч сүүлдээ тэгсэнгүй. Заримдаа түүний зүрх нь хэдэн цагийн турш өөрийнхөө гунигийн талаар ярьж өөр үеүдэд хөөрөн, цөлийн нар шингэх үед маш их догдлон хүү нулимсаа нуухад хүргэж байлаа. Түүний зүрх нь баялгийн тухай ярихдаа хамгийн хурдан цохилж бас цөлийн эцэс төгсгөлгүй хязгаарыг ажиглан байхад илүү удааширч байв. Гэвч түүний зүрх нь ердөө ч чимээгүй байсангүй бүр алхимич болон хүү хоёулаа чимээгүйд умбасан үед ч гэлээ.

“Яагаад бид өөрсдийнхөө зүрхийг чагнах ёстой юм бэ?” гэж тэр өдөр буудаллах үедээ хүү асуулаа.

“Яагаад вэ гэвэл хаана чиний зүрх байна, тэндээс чи өөрийнхөө баялгийг олох болно.”

“Гэвч миний зүрх тавгүй байна,” гэж хүү хэллээ. “Тэр өөрийн мөрөөдөлтэй, догдлолтой бас цөлийн бүсгүйг бодохоороо урам зоригоор дүүрэн байна. Тэр надаас юмсын тухай асууж тэр бүсгүйн тухай бодох бүрт олон шөнийг нойргүй өнгөрөөхөд хүргэж байна.”

“За тэгвэл сайн байна. Чиний зүрх чинь амьд байна. Түүний юу хэлэхийг нь үргэлжлүүлэн сонс.”

Дараагийн гурван өдрийн туршид хоёр аялагч маань хэд хэдэн зэвсэглэсэн цөлийн эрчүүдийн хажуугаар зөрсөн бөгөөд нэлээдийг тэнгэрийн хаяаны тэртээд харсан билээ. Хүүгийн зүрх айдсын тухай ярьж эхлэлээ. Тэр хүүд Дэлхийн сүнснээс сонссон түүхүүдийн тухай баялгийнхаа эрэлд явсан боловч амжилт олоогүй эрчүүдийн тухай түүхүүдийг ярьж байлаа. Заримдаа тэр хүүг өөрийнхөө баялгийг хэзээ ч олохгүй байж магадгүй аль эсвэл цөлд үхэж магадгүй хэмээн айлгаж байв. Заримдаа тэр хүүд жаргалтай байгаагаа хайр болон мөнгө хөрөнгө олсон гэдгийг хэлж байлаа.

“Миний зүрх урвагч болжээ,” гэж морьдоо амраахаар зогсох зуураа хүү алхимичид хэллээ. “Тэр намайг үргэлжлүүлэхийг хүсэхгүй байна.”

“Одоо л учир ургаж байна,” гэж алхимич хариуллаа. “Жамаараа бол мөрөөдлөө биелүүлэхээр замнах явцдаа чамайг олсон бүхнээ алдаж магадгүй хэмээн зүрх чинь айж байгаа юм.”

“Тэгвэл би яагаад зүрхээ сонсох шаардлагатай гэж?”

“Яагаад вэ гэвэл чи түүнийг ахин чимээгүй байлгаж хэзээ ч чадахгүй. Хэдийгээр чи түүний хэлж байгааг сонсоогүй мэт дүр үзүүллээ ч гэсэн тэр чиний дотор

байх бөгөөд дэлхий ертөнц болон амьдралын талаар чиний юу бодож байгааг давтсаар л байх болно.”

“Та тэгвэл тэр хичнээн хуурамч байлаа ч гэсэн би сонсох ёстой гэж байгаа гэж үү?”

“Урвалт бол гэнэт гарч ирдэг цохилт юм. Хэрвээ чи зүрхээ сайн мэддэг бол тэр хэзээ ч чамд тийм зүйл хийхгүй. Яагаад вэ гэвэл чи түүний мөрөөдөл хүслийг мэдэрч, хэрхэн тэдэнтэй харьцахаа мэднэ.”

“Чи хэзээ ч өөрийн зүрхнээсээ зугатааж чадахгүй. Тийм учраас түүний юу хэлэх гэснийг нь сонссон нь илүү дээр. Ийм замаар чи хэзээ ч гэнэтийн санамсаргүй цохилтоос айх шаардлагагүй юм.”

Хүү цөлийг гатлах зуураа зүрхээ үргэлжлүүлэн чагнасаар л байлаа. Тэр түүний арга мэх болон хөдөлгөөнийг мэдэрч, түүнийг байгаагаар нь хүлээж авлаа. Тэр өөрийн айдсаа орхиж баянбүрд рүү буцан очих хэрэгтэй тухайгаа мартсан бөгөөд яагаад вэ гэвэл нэг өдөр түүний зүрх нь түүнд жаргалтай байгаагаа хэлсэн билээ. “Хэдийгээр би заримдаа гомдоллодог ч гэлээ,” гэж тэр хэлээд “учир нь би хүний зүрх, хүний зүрхнүүд угаасаа тийм байдаг. Хүмүүс өөрсдийн хамгийн чухал мөрөөдөлүүдээрээ замнахаас айдаг, учир нь тэд түүнийгээ хүртэх гавъяагүй хэмээн мэдэрдэг юмуу аль эсвэл түүндээ хүрэх чадваргүй байдаг. Бид, тэдний зүрхнүүд хайртай хүн нь алсад үүрд одох аль эсвэл сайхан байж болох байсан ч болоогүй мөчүүд эсвэл олдож болох байсан ч үүрд элсэнд булагдсан баялгуудын талаар бодоход л айдастай болдог. Яагаад вэ гэвэл эдгээр зүйлс тохиолдоход бид маш ихээр шаналдаг.”

“Миний зүрх тэр өөрөө шаналах ёстой болно гэж айж байна,” гэж нэгэн шөнө саргүй тэнгэрийн зүг харж байх зуураа хүү алхимичид хэллээ. “Өөрийн зүрхэндээ шаналалын тухай айдас нь шаналалаас өөрөөс нь ч долоон дор байдаг гэж хэл. Тэгээд ямар ч зүрх өөрийнхөө мөрөөдлийн төлөө эрэлд явж байхдаа шаналдаггүй яагаад гэвэл уг эрлийн хором бүр Бурхан болон мөнхийн амьдралтай уулзах хором байдаг.”

“Эрлийн хором бүр Бурхантай уулзах учрал,” хэмээн хүү өөрийнхөө зүрхэнд хэллээ. “Би өөрийнхөө баялгийг жинхэнээсээ хайж байх үед, өдөр бүр гэгээлэг байсан, яагаад вэ гэвэл цаг бүр миний хүрэх мөрөөдлийн нэгэн хэсэг гэдгийг мэдэрч байсан. Би өөрийн баялгаа жинхэнээсээ хайж байх үедээ шинэ зүйлсийг танин илрүүлж энгийн нэг хоньчны хувьд боломжгүй санагдах зүйлсийг хийх зориг тэвчээрийг олж харсан билээ.”

Тэгээд түүний зүрх нь өдрийн туршид чимээгүй байлаа. Тэр шөнө хүү гүн нойрссон бөгөөд түүнийг сэрэхэд зүрх нь түүнд Дэлхийн сүнснээс ирсэн зүйлсийг хэлэв. Тэрээр аз жаргалтай бүх хүн дотроо Бурханыг агуулж байдаг ба алхимичийн хэлснээр аз жаргал цөлийн элсний ширхэгээс ч олдож болно гэж хэллээ. Яагаад вэ гэвэл элсний ширхэг бол бүтээлийн нэгэн мөч, хорвоо ертөнц хэдэн сая жил түүнийг бүтээхэд зарцуулсан юм. “Дэлхий дээрх хүн бүр өөрийг нь хүлээж буй баялагтай байдаг,” гэж түүний зүрх нь хэллээ. “Бид хүмүүсийн зүрхнүүд тэдгээр баялгийн талаар маш ховорхон удаа л хэлдэг яагаад вэ гэвэл хүмүүс тэдний эрэлд явахыг цаашид хүсэхээ больдог. Бид тэр тухай зөвхөн хүүхдүүдэд л ярьдаг. Хожим нь бид зүгээр л амьдрал цаашаа өөрийн чиглэл, жам ёсоороо авч явахыг нь зөвшөөрөн орхидог. Гэвч харамсалтай нь маш

цөөхөн хүн түүнд зориулсан замаар замнадаг, тэр зам буюу тэдний Хувийн бахархалын болон аз жаргалын зам. Ихэнх хүмүүс дэлхийг аймшигтай газар гэж төсөөлдөг тэгснээрээ үнэн хэрэгтээ тэдэнд дэлхий аймшигтай газар болон хувирдаг.” “Тэгээд бид тэдний зүрхнүүд улам илүү эелдэгээр ярьж эхлэдэг. Бид хэзээ ч ярихаа зогсоодоггүй боловч бидний үг сонсогдохгүй байгаасай гэж найдаж эхлэдэг, бид хүмүүсийг зүрхээ дагаагүйгээсээ болж шаналаасай гэж хүсдэггүй.”

“Яагаад хүмүүсийн зүрх нь тэдэнд өөрсдийн мөрөөдлөө үргэлжлүүл гэж хэлдэггүй юм бэ?” гэж хүү алхимичээс асуулаа.

“Яагаад гэвэл тэр нь зүрхийг маш ихээр шаналуулан зовоодог, зүрхнүүд шаналах дургүй юм.”

Тэр мөчөөс хойш хүү зүрхээ ойлгов. Тэр зүрхнээсээ хэзээ ч түүнтэй ярихаа зогсоохгүй байгаарай хэмээн гуйлаа. Хэрвээ тэр мөрөөдлөөсөө холдон төөрвөл түүний зүрх нь түүнийг шахан анхаарлын дохио өгч байгаарай хэмээн хүслээ. Хүү тэрхүү дохиог сонсох бүрт хэлж буй зүйлсийг нь үргэлжлүүлэх болно гэж амлав. Тэр шөнө хүү энэ бүхнийг алхимичид хэлсэн юм. Алхимич хүүгийн зүрх нь Дэлхийн сүнс рүү буцан ирснийг ойлголоо.

“Тэгээд би одоо юу хийх ёстой вэ?” гэж хүү асуув.

“Пирамидуудын зүг үргэлжлүүл,” гэж алхимич хэлэв. “Мөн зөн совингоо үргэлжлүүлэн ажиглаж байгаарай. Чиний зүрх чинь хаана баялаг байгааг заах чадвартай хэвээрээ байна.”

“Энэ тэгээд миний мэдэх шаардлагатай нөгөө зүйл мөн үү?”

“Үгүй,” гэж алхимич хариуллаа. Чиний мэдэх шаардлагатай зүйл гэвэл мөрөөдөл биелэгдэхийн өмнө Дэлхийн сүнс чиний энэ замаараа явахдаа сурсан бүхий л зүйлийг шалгадаг. Тэр муу санаатай учраас үүнийг хийдэг юм биш харин бид үүнийг давсанаараа өөрсдийн мөрөөдлийг биелүүлэхийн зэрэгцээгээр тэрхүү мөрөөдлийн төлөө тэмцэхдээ сурсан хичээлүүдээ эзэмшиж чадах ёстой. Энэ бол ихэнх хүмүүсийн бууж өгдөг тэр хэсэг юм. Энэ хэсэг бол цөлийнхний хэлдэгээр “тэнгэрийн хаяанд дал модод гарч ирэхэд цангаснаасаа болж үхэх” гэдэгтэй адил.

“Бүх л эрэл Эхлэгчдийн азаар эхэлдэг. Тэгээд бүх эрэл ялагч хатуу ширүүн шалгууруудыг давсанаар дуусдаг.”

Хүү нутгийнхаа нэгэн зүйр үгийг эргэн саналаа. Тэр нь шөнийн хамгийн харанхуй хугацаа нь үүр цайхын өмнөхөн тохиолддог гэдэг билээ.

-***-

36 - р хэсэг

Дараагийн өдөр аюулын хамгийн эхний илэрхий тэмдэг тохиолдов. Зэвсэглэсэн гурван эр ирээд хүү болон алхимичийг энд юу хийж явааг асуув.

“Би шонхортойгоо ан хийж явна,” гэж алхимич хариуллаа. “Бид та нарыг зэвсэгтэй яваа эсэхийг шалгах болно,” гэж нэг нь хэллээ. Алхимич алгуурхнаар мориноосоо буухад хүү адил буулаа.

“Та нар яагаад мөнгө авч яваа юм бэ?” гэж хүүгийн богцыг үзэнгээ тэр асуулаа. “Би Пирамидууд руу очиход хэрэг болно,” гэж хүү хариулав. Нөгөө эр алхимичийн богцноос шингэнээр дүүргэсэн жижиг болор лонх болон тахианы өндөгнөөс арай том хэмжээтэй шар шилэн өндөг хоёр гаргаж ирлээ.

“Эд нар юу вэ?” гэж тэр асуулаа. “Энэ бол Гүн ухаантны чулуу болон Мөнхийн ус. Эдгээр нь алхимичидийн Мастер бүтээл. Энэ шингэнээс уусан хүн ахиж өвдөж зовохгүй бөгөөд энэхүү чулууны жижиг хэлтэрхий нь ямар ч төмөрлөгийг алт болгон хувиргах болно.”

Тэрхүү арабууд түүн рүү инээлдэхэд алхимич ч гэсэн цуг инээлдэв. Тэд түүний хариултыг адтай хэмээн бодоцгоосон бөгөөд хүү болон алхимичийг эд зүйлсийн хамтаар цаашаа аялахыг нь зөвшөөрөв.

“Та чинь галзуурав уу?” гэж хүү цааш хөдлөхдөө алхимичаас асуулаа. “Яагаад та тэгж хэлсэн юм бэ?”

“Чамд амьдралын энгийн хичээлүүдээс нэгийг нь харуулах гэж,” хэмээн алхимич хариуллаа. “Хэрвээ чи өөртөө агуу их баялгийг агуулаад түүнийгээ бусдад хэлэхээр оролдоход цөөхөн нь л чамд итгэдэг.”

Тэд цөлөөр үргэлжлүүлэн явлаа. Өдөр өнгөрөх тутамд хүүгийн зүрх улам л чимээгүй болсоор байв. Зүрх нь өнгөрсөн болон ирээдүйн талаарх зүйлсийг мэдэхийг хүсэхээ болж зөвхөн цөлийг эргэцүүлэн бодож Дэлхийн сүнснээс ирсэн зүйлсийг хүүтэй хамт амталж байв. Хүү болон түүний зүрх нь хоорондоо найз болцгоож аль нь ч хэн нэгнийгээ хуурахааргүй болов. Түүний зүрх хүүд урам зориг өгөх үедээ л ярих бөгөөд хүүгийн хүчийг сэлбэнэ, учир нь цөлийн нам гүмд өдрүүдийг өнгөрүүлэх нь хэцүү билээ. Зүрх нь аль нь хүүгийн хамгийн хүчтэй чанарууд болох тухай түүний хонио орхин өөрийн Хувийн бахархалаар амьдрах болсон зориг тэвчээрийг, хүүгийн болор эдлэлийн дэлгүүрт ажиллаж байхдаа гаргасан өөдрөг, бадрангуй сэтгэлгээний тухай ярьж байлаа. Түүнчлэн түүний зүрх нь хүүгийн анзаарч байгаагүй бусад зүйлсийг, хүүд учирч болох байсан боловч ажиглагдаагүй өнгөрсөн аюулуудын тухай ярилаа.

Хүүгийн зүрх нь нэг удаа ааваасаа авсан бууг хүү өөрийгөө шархдуулж магадгүй хэмээн нуусан тухайгаа яриу. Мөн тэр, хүүд нэг удаа өвчин тусч, хээр огиулж байснаа нам унтсан өдрийг нь эргэн сануулав. Тэр үед хүүгийн замыг тосон хоёр хулгайч хонийг нь дээрэмдэж хүүг алахаар хүлээж байсан байна. Гэвч хүү ирээгүй тул тэд хүүг замаа сольсон байна гэж бодоод явцгаасан ажээ.

“Хүний зүрх нь үргэлж түүнд тусладаг уу?” гэж хүү алхимичаас асуулаа.

“Ихэнхдээ Хувийн бахархалаа биелүүлэхээр тэмцэж байгаа хүмүүсийн зүрх тэгдэг. Гэвч тэд хүүхдүүд, согтуучууд бас настангууд ч гэсэн тусладаг.”

“Тэгэхээр би аюулд хэзээ ч орохгүй гэсэн үг үү?”

“Энэ бол зөвхөн зүрх юу чадахаа л хийдэг гэсэн үг,” гэж алхимич хэллээ.

Нэгэн өдөр үдийн хирд тэд омгуудын нэгнийх нь хуарангийн хажуугаар өнгөрлөө. Хуарангийн булан бүрт гоёмсог цагаан дээл өмсөж, зэвсгээ барьсан арабууд зогсох бөлгөө. Эрчүүд гаансаа татацгаан, тулалдааны талаарх түүхүүдийг ярилцах ажээ. Хэн ч тэр хоёр аялагчийг анхаарахгүй байлаа.

“Энд ямар ч аюул алга,” гэж хуарангийн хажуугаар өнгөрмөгцөө хүү хэллээ. Алхимич ууртайгаар “Өөрийнхөө зүрхэнд итгэ, гэвч хэзээ ч цөлд байгаа гэдгээ мартаж болохгүй. Хэрвээ эрчүүд нэг нь нөгөөтэйгээ байлдвал Дэлхийн сүнс зөвхөн байлдааны чимээг л сонсдог. Энэ нарны доор хэн ч гэсэн үйлийн үрээс зугатааж чаддаггүй.” хэмээн хэлэв.

Бүх л зүйл нэг юм даа гэж хүү бодлоо. Тэгтэл цөл алхимичийн зөв гэдгийг харуулах гэсэн мэт хоёр морьтон тэдний араас нэхэн ирэв.

“Та нар цаашаа явж болохгүй,” гэж тэдний нэг нь хэллээ. “Та нар байлдаан болж байгаа газарт байна.”

“Би хол явахгүй,” гэж алхимич хэлээд морьтоны нүд рүү эгцлэн харлаа. Тэд хэсэг чимээгүй байснаа хүү болон алхимичийг цааш нь явахыг зөвшөөрөв. Хүү тэдний ярилцахыг гайхан харж байлаа. “Та тэр морьтонуудыг харцаараа давамгайлчихлаа,” гэж хүү хэлэв.

“Чиний нүд чиний сүнсний чадлыг харуулдаг юм,” гэж алхимич хариуллаа. Тэр ч үнэн шүү гэж хүү бодлоо. Саяны өнгөрсөн хуарангийн дундаас хэн нэгэн тэр хоёр руу маш анхааралтайгаар харж байсныг хүү ажигласан билээ. Тэр маш хол нүүр нь ч харагдахааргүй хол байсан ч гэсэн хүү өөрсдийг нь ажиглаж байна гэдэгт итгэлтэй байлаа.

Эцэст нь тэд тэнгэрийн хаяа хүртэл сунасан уулын бэлийг хөндлөн гатласны дараа алхимич Пирамидууд хүртэл ердөө хоёрхон өдөр үлдсэн гэдгийг хэлэв.

“Бид өөрсдийн замаар салан одох дөхөж байна,” гэж хүү хэлээд “тэгээд та надад алхимийн тухай зааж өгөөч.”

“Чи алхимийн тухай аль хэдийн ойлгосон шүү дээ. Энэ бол Дэлхийн сүнс рүү нэвтрэн орж тэнд чамд зориулан бэлдсэн баялгийг нээх тухай юм.”

“Үгүй дээ, би түүний тухай ярих гэсэнгүй. Би хэрхэн тугалгыг алт болгох тухай ярьсан юм.”

Алхимич хэсэг зуур цөл шиг л чимээгүй болсноо зөвхөн тэд хоол идэхээр зогссоны дараа л хүүд хариуллаа. “Ертөнц дээрх бүхий л зүйл хувирч өөрчлөгдөж байдаг,” гэж тэр хэлэв.

“Ухаант мэргэн хүмүүсийн хувьд алт гэдэг бол хамгийн дээд цэгтээ хүртэл хувирсан төмөрлөг юм. Яагаад гэдгийг нь надаас бүү асуу, учир нь яагаад гэдгийг нь би мэдэхгүй. Би зөвхөн Уламжлал үргэлж зөв байдаг гэдгийг л мэднэ.”

“Хүмүүс мэргэдийн сургаалыг хэзээ ч ойлгож байсангүй. Тэгээд алт хувьсал өөрчлөлтийн тэмдэгийн оронд сөргөлдөөн тэмцлийн үндэс болсон байна.”

“Юмсаар илэрхийлэгдэх олон төрлийн хэл байдаг юм билээ,” гэж хүү хэлэв. “Надад тэмээний буйлаан зөвхөн тэмээний буйлаанаараа байх үе ч тохиолдож байсан. Тэгснээ аюул дуудсан дохио болж ч байсан. Тэгээд эцэстээ ахин ердийн тэмээний буйлаан болж билээ.” Гэвч тэгснээ хүү зогслоо. Алхимич тэрийг аль хэдийн мэдэж байгаа байх л даа.

“Би жинхэнэ алхимичдийг мэднэ,” гэж алхимич үргэлжлүүлээ. “Тэд өөрсдийгөө лабораторидоо хориод алттай адилаар хувьсан өөрчлөгдөхийг хүсдэг. Тэгээд тэд Гүн ухаантны чулууг олцгоодог учир нь тэд хэрвээ ямар нэг зүйл өөрчлөгдвөл тэр зүйлийн орчинд байгаа бүх зүйл адилхан хувиран өөрчлөгддөг гэдгийг мэддэг.”

“Зарим нь тохиолдлоор тэр чулууг нээдэг. Тэд байгалийн авъяастай, тэдний сүнснүүд нь ийм зүйлд бусдыг бодвол илүү бэлэн байдаг. Гэвч тэд маш цөөхөн.”

“Тэгээд үлдсэн хэсэг нь зөвхөн алт гаргаж авахад л сонирхсон хүмүүс байдаг. Тэд хэзээ ч нууцыг тайлж чаддаггүй. Тэд тугалга, зэс болон төмөр өөр өөрсдийн Хувийн бахархалтай түүндээ хүрэхийг хичээдэг гэдгийг мартдаг. Бусдын Хувийн бахархалтай зөрчилддөг хэн нэгэн хэзээ ч өөрийнхөө Хувийн бахархалыг нээж олдоггүй юм.”

Алхимичийн үг яг л тарни мэт цуурайтан байлаа. Тэр тонгойн газраас нэгэн дун шүүрч авав.

“Нэгэн цагт цөл далай байсан,” гэж алхимич хэллээ.

“Би түүнийг ажигласан,” гэж хүү хариулав. Алхимич хүүд дунг чихэндээ ойртуулахыг хүсэв. Тэр хүүхэд байхдаа олон удаа үүнийг хийж байсан ба далайн чимээг сонсдог байсан билээ.

“Далай энэ дунгийн дотор амьдарч байна, учир нь тэр бол үүний Хувийн бахархал юм. Тэгээд энэ цөл ахин усаар дүүртэл тэр үүнийгээ зогсоохгүй.”

Тэд мориндоо мордоцгоон Египетийн Пирамидуудын зүг хөдөллөө.

37 - р хэсэг

Нар жаргах үед хүүгийн зүрх аюулын дохио дуугаргалаа. Тэд асар том толгодоор хүрээлэгдсэн байсан бөгөөд хүү алхимичийг ямар нэг зүйл мэдэрсэн болов уу хэмээн харав. Гэвч тэр аюулыг мэдэрсэн шинжгүй байлаа.

Таван минутын дараа хүү хоёр морьтон тэдний өмнө хүлээн байхыг харав. Тэрээр ямар нэг зүйл алхимичид хэлж амжихаас өмнө морьтонгууд арав, тэгээд зуун хүн болцгоолоо. Тэд толгодын энд тэндгүй байлаа. Тэд хөх өнгөөр хувцаслаж турбан малгайдаа хар цагариг ороосон омгийнхон байв. Тэдний царай нь хөх унжлаганыхаа ард нууцгай байх ба зөвхөн нүдээ ил гаргацгаажээ. Хэдий хол зайтай байсан ч гэлээ тэдний нүд нь сүнснийх нь хүчийг илтгэж байлаа.

Тэгээд тэдний нүд нь үхлийн харцаар ярьж байв.

38 - р хэсэг

Тэр хоёрыг ойролцоох цэргийн хуаранд авчирлаа. Нэгэн цэрэг хүү болон алхимичийг цэргүүдийн ахлагч зөвлөлгөөн хийж байсан майханд оруулав.

“Эд нар туршуулууд байна,” гэж тэнд байсан хүмүүсийн нэг нь хэлэв.

“Бид жирийн л аялагчид байна,” гэж алхимич хариуллаа.

“Та нар гурван өдрийн өмнө дайсны хуаранд харагдсан. Тэгээд тэнд байсан нэг цэрэгтэй ярьж байсан шүү дээ.”

“Би бол цөлөөр аялж оддыг шинждэг жирийн л нэг хүн,” гэж алхимич хэллээ. “Би цэргүүд болон омгийнхны байрлал, хөдөлгөөний талаар мэдэх зүйлгүй. Би зөвхөн найздаа туслан газарчилж байгаа билээ.”

“Найз чинь хэн билээ?” гэж ахлагч асуулаа. “Алхимич,” гэж алхимич хэллээ. “Тэр байгалийн хүчийг ойлгодог. Тэгээд тэр танд өөрийн гайхамшигт хүчийг үзүүлэхийг хүссэн билээ.”

Хүү чимээгүй бас эмээн сонсож байлаа. “Энэ харийн эр энд юу хийж яваа юм бэ?” гэж өөр нэг эр асуулаа. “Тэр танай цэргүүдэд мөнгө авчирсан юм,” гэж хүүг үг дуугарч амжихаас өмнө алхимич хэллээ. Тэгээд хүүгийн богцыг шүүрэн авч алтан зооснуудыг ахлагчид өгөв. Ахлагч үг дуугарсангүйгээр зооснуудыг авав. Тэнд зэвсэг олныг худалдаж авахад хангалттай мөнгө байлаа.

“Алхимич гэж хэн билээ?” гэж ахлагч эцэст нь асуулаа. “Энэ бол байгаль болон дэлхийг ойлгодог хүн. Хэрвээ тэр хүсэх юм бол энэ хуаранг зөвхөн салхины хүчээр л устгаж чадна.” Эрчүүд инээлдлээ. Тэнд дайны гарз хохиролд дасцгаасан бөгөөд салхи тийм хүчтэй аюул учруулж чадахгүй гэдгийг мэдэцгээж байв. Гэхдээ тэдний зүрх нь илүү хүчтэй цохилохыг хүн бүр мэдэрч байсан. Тэд цөлийн эрчүүд тийм учраас шидтэнгүүдээс жийрхцгээдэг билээ.

“Би түүнийг хийхийг нь хармаар байна,” гэж ахлагч хэлэв. “Түүнд гурван өдөр хэрэгтэй,” гэж алхимич хариулав. “Тэр хүч чадлаа харуулахын тулд өөрийгөө салхи болгон хувиргах болно. Хэрвээ тэр ингэж чадахгүй бол бид өөрсдийн амийг таны дайчдын алдрын төлөө өргөхөд бэлэн байна.”

“Чи надад аль хэдийн минийх болсон зүйлийг амлаж болохгүй,” гэж ахлагч дээрэнгүйгээр хэллээ. Гэвч тэр аялагчдад гурван өдрийн хугацаа өгөв.

Хүү айснаасаа болон салгалан байтал алхимич түүнийг майхнаас гарахад нь туслав. “Тэдэнд айж байгаагаа бүү үзүүл,” гэж алхимич хэллээ. “Тэд бол зоригтой эрчүүд, тэд хулчгаруудыг жигшдэг.” Гэвч хүү ярьж ч чадахгүй байлаа. Тэд хуарангийн төвд ирэх үед л хүү ярихтайгаа болов. Тэднийг хорих шаардлагагүйгээр арабууд морьдыг нь л хурааж авав. Дэлхий ахиад л өөрийн олон хэлний нэгийг үзүүлсэн бөгөөд цөл хэсэг хугацааны өмнө эцэс төгсгөлгүй, эрх чөлөөтэй байсан бол одоо нэвтрэшгүй ханан хэрэм боллоо.

“Та тэдэнд надад байсан бүх зүйлийг өгчихлөө!” гэж хүү хэллээ. “Миний амьдралынхаа туршид хураасан бүхнийг шүү!”

“За яахав, гэхдээ чи үхэх болвол тэр юуных нь сайн байх вэ?” алхимич хариулав. “Чиний мөнгө бидэнд гурван өдрийг авчирлаа. Мөнгө үргэлж хүний амийг аварч чаддаггүй юм.”

Гэвч хүү сургаал үг сонсох чадваргүйгээр айн цочирдсон байлаа. Тэр өөрийгөө хэрхэн салхи болгон хувиргах талаар юу ч мэдэхгүй байлаа. Тэр алхимич биш шүү дээ. Алхимич цэргүүдийн нэгнээс цай олж авчран хүүгийн бугуйн дээр гоожуулав. Тайвшралын мэдрэмж хүүгийн биеэр тархаж алхимич хүүгийн ойлгохгүй үгсийг шивнэв.

“Өөрийн айдсандаа бүү бууж өг,” гэж алхимич хачирхалтай зөөлөн дуугаар хэллээ. “Хэрвээ чи тэгвэл зүрхтэйгээ ярьж чадахгүйд хүрнэ.”

“Гэвч би өөрийгөө салхи болгон хувиргах талаар юу ч мэдэхгүй байна.”

“Хэрвээ хүн өөрийн Хувийн бахархалаараа амьдарч л байгаа бол тэр мэдэх шаардлагатай бүх л зүйлээ мэддэг. Мөрөөдөлдөө хүрэхэд боломжгүй болгодог ганц л зүйл байдаг нь бүтэлгүйтлээс айх айдас юм.”

“Би бүтэлгүйтэхээс айхгүй байна. Би зөвхөн яаж өөрийгөө салхи болгон хувиргахаа л мэдэхгүй байна.”

“Тэгвэл чи сурах шаардлагатай болж дээ, чиний амьдрал үүнээс хамаарна.”

“Гэвч хэрвээ би чадахгүй бол?”

“Тэгвэл чи өөрийн Хувийн бахархалаа биелүүлэх замдаа үхэх болно. Тэгсэн ч гэсэн өөрийн Хувийн бахархалаа юу болохыг нь ч мэдэлгүйгээр үхэж буй сая сая хүмүүсээс хавьгүй илүү байх болно.” “Гэвч бүү санаа зов,” гэж алхимич үргэлжлүүлээ.

“Үхлийн аюул тулгарах нь хүмүүст өөрсдийн амьдралынх нь тухай их зүйлийг бодуулдаг юм.”

39 - р хэсэг

Эхний өдөр өнгөрлөө. Ойролцоохон том тулаан болж байсан бөгөөд шархдагсадыг хуаран руу авчирч байлаа. Амь үрэгдсэн цэргүүдийг бусад цэргүүд орлон амьдрал үргэлжилсээр байх ажээ. Үхэл юуг ч өөрчилдөггүй юм байна гэж хүү бодлоо.

“Чи хожим үхэж ч болох байсан шүү дээ,” гэж нэгэн цэрэг андынхаа цогцос руу харан хэллээ. “Чи амар тайван амьдрал ирсний дараа үхэх байсан юм. Гэхдээ ямар ч тохиолдолд чи минь үхэх л болно.”

Тэр өдрийн үдэш хүү алхимичийг олохоор явлаа, тэр шонхороо аван цөл рүү явсан байсан билээ.

“Би одоо ч гэсэн өөрийгөө хэрхэн салхи болгон хувиргах талаар ямар ч санаа алга,” гэж хүү давтлаа.

“Чамд хэлсэн зүйлийг минь эргэцүүлж сайн бод. Энэ хорвоо бол зөвхөн Бурханы нүдэнд харагдах бодит хэсэг. Тэгээд алхимийн хийдэг зүйл нь болохоор оюунлаг төгс зүйлийг бодит зүйлсэд нэвтрүүлэн хүргэх юм.”

“Та юу хийж байгаа юм бэ?”

“Шонхороо л тэжээж байна.”

“Хэрвээ би өөрийгөө салхи болгон хувиргаж чадахгүй бол бид үхэх болно шүү дээ,” гэж хүү хэллээ. “Яагаад та шонхороо тэжээж байгаа юм бэ?”

“Чи л үхэж магадгүй хүн шүү дээ,” гэж алхимич хэллээ. “Би өөрийгөө хэрхэн салхи болгон хувиргахаа хэзээний мэднэ.”

40 - р хэсэг

Хоёр дахь өдөр нь хүү хуарангийн ойролцоо байх хадан цохионы орой дээр гарлаа. Харуулууд түүнийг тийшээ очихыг зөвшөөрсөн бөгөөд тэд аль хэдийн өөрийгөө салхи болгон хувиргаж чадах шидтэний талаар сонссон тул түүний ойролцоо байхыг хүсэхгүй байлаа.

Ямар ч тохиолдолд цөл туулшгүй билээ. Хүү тэр өдрийг бүхэлд нь цөлийн зүг ширтэн, зүрхээ сонсон өнгөрөөлөө. Хүү цөл түүний айдсыг мэдэрч байгааг ухаарав.

Тэд нэгэн ижил хэлээр ярилцаж байлаа.

41 - р хэсэг

Гурав дахь өдөр толгойлогч цэргийн тушаалтнуудтайгаа уулзалдлаа. Тэр алхимичийг уулзалтанд дуудан “За явж хүүг өөрийгөө салхи болгон хувиргахыг нь харцгаая.” гэж хэллээ. “Тэгье,” хэмээн алхимич хариулав. Хүү тэднийг өмнөх өдөр нь очсон хадан цохио тийш аваачлаа. Хүү тэдэнд бүгдийг нь суухыг хүслээ.

“Энэ жаахан удах болно,” гэж хүү хэлэв. “Бид яараагүй байна,” гэж толгойлогч хариулав. “Бид бол цөлийн эрчүүд.” Хүү тэнгэрийн хаяа руу ширтлээ. Тэнд алсад уулнууд харагдаж байлаа. Бас толгод, хадан цохио болон амьдрах ямар ч боломжгүй мэт газарт ургасан ургамлууд харагдана. Тэнд бас хүүгийн олон сараар аялсан цөл харагдана, гэхдээ энэ хугацаанд хүү зөвхөн өчүүхэн хэсгийг нь л мэдэж авсан билээ. Тэрхүү жижиг хэсэгт тэр англи эрийг, жингийн цувааг, омгуудын хоорондын дайныг, бас тавин мянган дал мод, гурван зуун булаг бүхий баянбүрдийг олсон.

“Өнөөдөр чи энд юу хүсч байна?” гэж цөл түүнээс асуулаа. “Чи өчигдөр намайг хангалттай харсан биш бил үү?”

“Та хаа нэгэн газраа миний хайртай хүнийг агуулж байгаа билээ,” гэж хүү хэллээ. “Тиймээс би таны элсийг харахаараа бас түүнийгээ хардаг юм. Би түүндээ буцан очихыг хүсч байна, тийм болохоор би өөрийгөө салхи болон хувиргахад таны тусламж хэрэгтэй байна.”

“Хайр гэж юу юм бэ?” гэж цөл асуулаа. “Хайр гэдэг бол таны элсэн дээгүүр нисэлдэх шонхорын нислэг. Яагаад гэвэл түүний хувьд та бол үргэлж антай буцдаг ногоон талбай нь юм. Тэр таны цохионуудыг, толгодуудыг бас уулсыг мэднэ, бас та түүнд өгөөмөр ханддаг.”

“Шонхорын хошуу надаас эмтлэн авч оддог,” гэж цөл хэллээ. “Олон жилийн туршид би түүний агнах анг арчлан, байгаа жаахан уснаасаа өгөн тэжээнэ, тэгээд шонхорт хаана ан байгааг харуулдаг. Тэгээд нэг л өдөр би тэрхүү ан миний гадаргуу дээр тэмцэж, шонхор агаараас шумбан ирээд миний бүтээсэн зүйлийг авч явахыг харан баясдаг.”

“Гэвч үүний тулд л та анг эхлэн бүтээсэн шүү дээ,” гэж хүү хариуллаа. “Шонхорыг тэжээхийн тулд. Шонхор хүнийг тэжээнэ. Эцэст нь хүн таны элсийг тэтгэнэ, тэгээд тэнд ахин ан сэргэн хөгжинө. Энэ бол хорвоо хэрхэн үргэлжилдэг жам билээ.”

“Тэгээд энэ хайр гэж үү?”

“Тиймээ, энэ бол хайр. Энэ бол анг шонхор болгож, шонхорыг хүн болгож, хүнийг цөл болгож байгаа тэр зүйл. Энэ бол тугалгыг алт болгож, алтыг дэлхийд нь эргэн буцаадаг тэр зүйл.”

“Чи юуны тухай ярьж байгааг би ойлгохгүй байна,” гэж цөл хэллээ.

“Гэвч та ямар ч гэсэн элсний тань хаа нэгтээ нэгэн бүсгүй намайг хүлээж байгаа гэдгийг ойлгож чадна. Тийм учраас би өөрийгөө салхи болгон хувиргах хэрэгтэй байна.”

Цөл хэсэг хугацаагаар хариу хэлсэнгүй. Тэгснээ тэр хүүд хэлсэн нь “Би чамд үлээх салхинд туслуулахаар элсээ өгье, гэвч ганцаараа би юу ч хийж чадахгүй. Чи салхинаас тусламж эрэх шаардлагатай.”

Зөөлөн салхи хөдөлж эхлэв. Эрчүүд хүүг алсаас харан хүүгийн ойлгохгүй хэлээр ярилцацгаан байв. Алхимич инээмсэглэлээ. Салхи хүрч ирэн хүүгийн нүүрийг илбэлээ. Тэр хүүгийн цөлтэй ярилцсан яриаг сонссон бөгөөд учир нь салхи бүгдийг мэддэг билээ. Тэд дэлхийгээр үүссэн хугацаа, үхэх газаргүйгээр хөндлөн гулд тэнүүчлэнэ.

“Надад туслаач,” гэж хүү хэллээ. “Нэг өдөр та миний хайртай хүний дуу хоолойг надад авчирч байсан билээ.”

“Хэн чамд цөл болон салхины хэлээр ярихыг зааж өгөв?” “Миний зүрх,” гэж хүү хариуллаа.

Салхи маш олон нэртэй. Дэлхийн энэ хэсэгт түүнийг сирокко гэж нэрлэдэг учир нь тэр далайн чийглэгийг дорно зүгт авчирдаг. Хүүгийн ирсэн алсын нутагт түүнийг левантер гэж нэрлэдэг яагаад гэвэл тэд цөлийн элс болон Мүрийн дайны хашгирааныг авчирдаг хэмээн итгэдэг юм. Магадгүй түүний хонинуудын бэлчээрээс цааших нутагт хүмүүс салхийг Андалуизагаас ирдэг хэмээн боддог байх. Гэвч үнэндээ салхи ямар ч газраас ирдэггүй бас өөр газар руу явдаггүй, тиймдээ ч цөлөөс илүү хүчирхэг байдаг. Хэн нэгэн хүн элсэн цөлд нэг өдөр мод тарьж, бүр хонь нутагшуулан хариулж магадгүй ч гэлээ салхийг бүрэн эзэгнэж чадахгүй юм.

“Чи салхи болж чадахгүй,” гэж салхи хэллээ. “Бид хоёр тэс өөр зүйлс шүү дээ.”

“Тэр үнэн биш,” гэж хүү хэллээ. “Би алхимичдын нууцаас аян замдаа суралцсан. Би дотроо салхинуудыг, цөлүүдийг, далай тэнгисийг, оддыг, орчлон ертөнцийн бүтээсэн бүхнийг агуулсан билээ. Бид бүгд л нэгэн мутраар бүтээгдсэн бид нэг ижил сүнстэй. Би таньтай адилхан болохыг хүсч байна, тань шиг дэлхийн өнцөг булан бүрт хүрч, тэнгис далайг гатлан, миний баялгийг бүрхэн байгаа элсийг үлээн зайлуулж бас хайртай бүсгүйнхээ хоолойг дамжуулдаг болмоор.”

“Би чамайг дээр нэг өдөр алхимичтай ярилцаж байхыг сонссон,” гэж салхи хэллээ. “Тэр, юм бүхэн өөрийн Хувийн бахархалтай байдаг гэж хэлсэн. Гэвч хүмүүс өөрсдийгөө салхи болгон хувиргаж чадахгүй.”

“Зүгээр л надад салхи шиг байхыг хэсэг хугацаанд зааж өгөөч,” гэж хүү хэллээ. “Тэгээд хоёулаа хүмүүс болон салхинуудын хязгааргүй боломжийн талаар ярилцаж чадна шүү дээ.”

Салхины сониуч зан нь хөдлөв, өмнө нь хэзээ ч байгаагүй зүйл түүнд тохиолдлоо. Тэр эдгээр зүйлсийн талаар ярилцахыг хүссэн боловч хэрхэн хүнийг салхи болгон хувиргахаа мэдэхгүй байлаа. Гэтэл салхины хийхийг нь мэддэг тоо томшгүй зүйлсийг сана л даа. Салхи цөлийг бүтээж, хөлөг онгоцуудыг живүүлж, ой шугуйг шуугиулан хөгжмийн аялгуу болон шуугианаар дүүрсэн хотуудын дундуур зугаална. Түүнд боломжгүй зүйл байхгүй мэт санагдаж байтал одоо харин салхины хийвэл зохилтой бусад зүйлс байгааг хэлүүлэн байна.

“Энэ бол бидний хайр гэж хэлдэг зүйл,” хэмээн хүү салхи түүний хүссэн зүйлийг биелүүлэхэд ойртож байгааг ажиглангаа хэллээ. “Хэрвээ хайртай болсон бол юм бүхнийг бүтээж чадна. Хэрвээ хайрласан бол юу болж байгааг бүгдийг ч ойлгох шаардлагагүй, яагаад вэ гэвэл бүх л зүйл чиний дотор тохиолдож тэр ч байтугай хүн салхи болон хувирч ч болно. Гэхдээ мэдээжээр салхи туславал шүү дээ.”

Салхи бол бардам нэгэн бөгөөд хүүгийн хэлсэнд тааламжгүй болов. Тэр улам илүү хүчлэн шуугиж цөлийн элсийг хөөргөлөө. Гэвч эцэст нь тэр дэлхийгээр хэсэн тэнүүчлэдэг ч гэлээ хүнийг хэрхэн салхи болгон хувиргаж чадахгүйгээ ухаарлаа. Тэгээд тэр хайрын талаар юу ч мэддэггүйгээ ойлгов.

“Дэлхийгээр хэрэн аялах замдаа би, ихэнхдээ хүмүүс хайрын тухай болон диваажин руу тэмүүлэн байхыг үзэж байсан билээ,” гэж салхи өөрийн чадлын хэмжээг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйдээ ууртайгаар хэллээ.

“Магадгүй дээд тэнгэрээс асуусан нь дээр байх.”

“За тэгвэл, түүнийг хийхэд надад тусла л даа,” гэж хүү хэллээ. “Энэ газрыг хүчтэй шороон шуургаар цохиж нарыг халхалж өгнө үү. Тэгээд би дээд тэнгэр рүү нүдээ сохруулалгүйгээр харж чадах болно.”

Тэгтэл салхи хамаг хүчээрээ шууран тэнгэр элсээр дүүрлээ. Нар алтан шар таваг мэт болов. Хуаранд юм харахад хэцүү болж байлаа. Цөлийн эрчүүд аль хэдийн энэ салхитай танил билээ. Тэд үүнийг симум гэж нэрлэх бөгөөд энэ нь тэнгисийн шуурганаас ч долоон дор юм. Морьд нь янцгааж, бүх зэвсэгнүүд нь элсээр дүүрэв.

Өндөр дээр байгаа хүмүүсээс нэгэн ахлагч, толгойлогч руу харан “Бид одоо үүнийг зогсоосон нь дээр байх!” гэж хэллээ. Тэд хүүг харахтай үгүйтэй л байлаа. Тэдний нүүр нь хөх даавуугаар халхлагдсан, нүдэнд нь айдас харагдаж байв.

“Үүнийг одоо зогсооё,” гэж өөр нэг ахлагч хэлэв.

“Би Аллах бурханы агуу их чадлыг харахыг хүсч байна,” гэж толгойлогч хүндэтгэлтэйгээр хэллээ. “Би хүн өөрийгөө хэрхэн салхи болгон хувиргахыг харахыг хүсч байна.” Харин дотроо тэр айдсаа илэрхийлсэн хоёр хүний нэрийг

тогтоож авсан юм. Салхи зогссоны дараагаар тэр хоёрыг тушаалаас нь буулгах болно, учир нь жинхэнэ цөлийн эрчүүд айдаггүй билээ.

“Салхи таныг хайрын тухай мэддэг гэж надад хэллээ,” хэмээн хүү нар руу хандан хэллээ. “Хэрвээ та хайрын тухай мэддэг бол та бас Дэлхийн сүнсийн талаар мэдэх ёстой яагаад вэ гэвэл тэр хайраар бүтээгдсэн билээ.”

“Миний байгаа энэ газраас,” хэмээн нар хэлээд “Би Дэлхийн сүнсийг харж чадна. Тэр миний зүрхтэй холбогдон бид хамтдаа ургамал ургах, хонь нөмөр газрыг хайх нөхцлийг нь бүрдүүлдэг. Миний байгаа газраас дэлхий хүртэл алс зайд би хэрхэн хайрлахаа сурсан юм. Хэрвээ би жаахан ч гэсэн дэлхийд илүү ойртох юм бол тэнд байгаа бүхэн амь үрэгдэж Дэлхийн сүнс оршихоо болино гэдгийг мэднэ. Тиймээс бид бие биенийгээ тунгаан бодож биенийгээ хүсэн, би түүнд амьдрал болон дулааныг бэлэглэж тэр надад миний амьдрах шалтгаан, учир утгыг өгдөг.”

“Тэгэхээр та хайрын тухай мэддэг байх нь,” гэж хүү хэллээ.

“Мөн би Дэлхийн сүнсийг мэддэг, яагаад вэ гэвэл бид хорвоо ертөнцөөр аялах эцэс төгсгөлгүй аялалдаа хоорондоо удаан ярилцсан. Тэр надад түүний хамгийн том асуудал бол одоог хүртэл зөвхөн чулуулаг болон ургамал л бүх зүйл нэг гэдгийг ойлгодог гэж хэлдэг. Тэгээд төмөр зэс шиг болох, эсвэл зэс алт шиг болох ямар ч шаардлагагүй гэдгийг. Бүгд өөрийн онцлог давтагдашгүй үүргийг гүйцэтгэж бүх зүйл найрсгаар зохицоцгоох байлаа, хэрвээ энэ бүхнийг бүтээсэн мутар тав дахь өдрөө зогссон бол.”

“Гэвч зургаа дахь өдөр гэж байсан билээ,” хэмээн нар үргэлжлүүлэв.

“Та мэргэн юм, яагаад вэ гэвэл та бүхнийг алсаас ажигладаг учраас,” гэж хүү хэллээ. “Гэвч та хайрын тухай мэддэггүй юм байна. Хэрвээ зургаа дахь өдөр гэж байгаагүй бол хүн төрөлхтөн гэж байхгүй байх байсан. Зэс үргэлж л зэс хэвээрээ, тугалга тугалгаараа л байх байсан. Юм бүхэн Хувийн бахархалтай гэдэг нь үнэн боловч нэг өдөр тэрхүү Хувийн бахархал нь биелүүлэгдэх болно. Тэгээд юм бүхэн өөрийгөө ямар нэгэн илүү зүйлд хувиргах ёстой ба шинэ Хувийн бахархал эзэмшиж, нэгэн өдөр Дэлхийн сүнс зөвхөн нэг зүйл болтол, үргэлжлүүлнэ.”

Нар тэр тухай бодсоноо улам илүү хурцаар гэрэлтэхээр шийдлээ. Салхи энэхүү ярианд хөгжин хүүгийн харааг нар гэмтээхээс хамгаалан улам илүү хүчээр шуурав.

“Энэ бол яагаад алхими оршдогийн учир нь,” гэж хүү хэллээ. “Хүн бүхэн өөрийн баялгаа эрэн хайж, түүнийгээ олохоороо өмнө нь байснаасаа илүү сайн байхыг хүсдэг. Тугалга өөрийн үүргээ дэлхий ахин тугалганы хэрэггүй болтол гүйцэтгэх бөгөөд тэр үед тугалга өөрийгөө алт болгон хувиргах болно.”

“Энэ бол алхимичдийн хийдэг зүйл. Тэд, хэрвээ бид байгаагаасаа улам илүү болохын төлөө тэмцэх тутам бидний эргэн тойронд байгаа бүхэн мөн адил илүү сайн болж өөрчлөгддөг, гэдгийг харуулдаг.”

“За тийм байж, гэхдээ яагаад чи намайг хайрын тухай мэддэггүй гэж хэлсэн юм бэ?” гэж нар хүүгээс асуулаа.

“Яагаад вэ гэвэл цөл шиг хөдөлгөөнгүй байх, эсвэл салхи шиг дэлхийгээр хэрэн тэнүүчлэх нь хайр биш юм. Мөн тань шиг бүхнийг зайнаас ажиглах нь бас хайр биш юм. Хайр бол өөрчлөлтийг үүсгэн Дэлхийн сүнсийг сайжруулж байгаа тэр хүч юм. Анх би түүнд нэвтрэн очихдоо Дэлхийн сүнсийг төгс сайхан юм гэж бодож байсан билээ. Гэвч хожим нь тэр бас л бусад бүтээлүүдийн адилаар өөрийн хүсэл зориг, зөрчилтэй болохыг харсан юм. Тэгээд бид Дэлхийн сүнсийг тэжээдэг бөгөөд бидний амьдарч буй энэ дэлхий маань бид өөрсдөө сайн эсвэл муу болохоос хамааран сайжрана бас доройтоно. Эндээс л хайрын хүч гарч ирдэг. Яагаад вэ гэвэл бид хайрлаж байхдаа үргэлж байгаагаасаа илүү сайн болохоор тэмцдэг билээ.”

“Тэгээд чи надаас юу хүсч байгаа юм бэ?” гэж нар асуулаа.

“Би таныг намайг салхи болон хувирахад туслаач гэж хүсч байна,” гэж хүү хариуллаа.

“Байгаль намайг бүтээгдсэн зүйлсийн хамгийн ухаантай нь гэдгийг мэднэ,” гэж нар хэлэв. “Гэвч би чамайг хэрхэн салхи болгон хувиргахыг мэдэхгүй.”

“Тэгвэл би хэнээс асуувал зохилтой вэ?”

Нар минут хиртэй бодлоо. Салхи ойртон сонсч, дэлхийн өнцөг булан бүрт нарны цэцэн ухаанд хүртэл хязгаар байдгийг, нар дэлхийн хэлээр яригч хүүтэй мэтгэлцэж чадахгүй байгааг хэлэхийг хүсч байлаа.

“Бүгдийг бичсэн тэр мутартай ярь даа,” гэж нар хэллээ. Салхи баясан шуугиж өмнө байгаагүйгээр хүчтэй үлээлээ. Майхнууд гадаснаасаа мултран хийсч, амьтад уяанаасаа алдуурав. Цохионы дэргэд эрчүүд хийсэхгүйн тулд нэг нэгнээсээ барив. Хүү энэ бүгдийг бичсэн мутрын зүг хандлаа. Түүнийг ингэх зуур хүү бүх л ертөнц чимээгүйд умбахыг мэдэрсэн бөгөөд тэрээр ярихгүй байхаар шийдлээ.

Хайрын урсгал түүний зүрхнээс цацрахад хүү залбирч эхэллээ. Энэ бол тэр өмнө нь хэлж байгаагүй залбирал байлаа, учир нь энэ бол үггүй бас ямар нэг зүйл хүсээгүй залбирал байлаа. Түүний залбирал нь түүний хонин сүрэг шинэ бэлчээр олсонд баярласан биш хүү улам илүү болор эдлэл зарахын төлөө бус мөн түүний танилцсан бүсгүй нь түүнийг буцан ирэхийг хүлээж байгаасай гэж хүссэнгүй. Нам гүм дунд хүү цөл, салхи, болон нар бүгд л тэр мутраар бичигдсэн тэмдгүүдийг ойлгохыг хичээж байгааг өөрсдийн замаараа замнахыг, маргад эрдэнийн талст дээр юу бичигдсэнийг ойлгохыг хичээж байгааг ухаарлаа.

Хүү зөн совингууд дэлхийгээр болон хязгааргүй орон зайгаар тархан байгааг тэдний оршин байгаад ямар нэг шалтгаан болон ач холбогдол агуулагдаагүй байдгийг цөл, салхи, нар болон хүмүүсийн аль нь ч тэд яагаад бүтээгдсэн гэдгээ мэддэггүй гэдгийг харлаа. Гэвч тэрхүү мутар л энэ бүгдэд шалтгаан бий болгож тэрхүү мутар л гайхамшийгийг бүтээж эсвэл далайг цөл, хүнийг салхи болгон хувиргаж чадах билээ. Яагаад вэ гэвэл зөвхөн тэр мутар л Мастер бүтээл болон хувирсан зургаан өдрийн бүтээл нь бүхий л ертөнц болон түгэн дэлгэрсэн агуу загварыг ойлгодог юм. Хүү Дэлхийн сүнсэнд нэвтрэн очиж тэр нь Бурханы сүнсний нэгэн хэсэг болохыг харав. Тэр мөн Бурханы сүнс нь түүний өөрийнх нь сүнс болохыг ойлголоо. Тэгээд тэр, энгийн нэг хүү, гайхамшигийг бүтээж чадах болно.

42 - р хэсэг

Тэр өдөр симум өмнө нь хэзээ ч тохиолдож байгаагүйгээр хүчтэй салхиллаа. Одооноос эхлэн арабчууд цөлийн хамгийн хүчирхэг толгойлогчийн барьцаанд байхдаа өөрийгөө салхи болгон хувиргаж цэргийн хуаранг бараг сүйрүүлэх дөхсөн хүүгийн түүхийг дурсан ярьцгаах болно.

Симум зогссоны дараа бүгд хүүгийн зогсож байсан газар руу харлаа. Гэвч хүү тэнд байсангүй, тэр хуарангийн нөгөө захад элсээр бүрхэгдсэн нэгэн харуулын хажууд зогсож байв. Эрчүүд түүний ид шидээс гайхан цочирдоцгоов.

Гэвч тэнд хоёр хүн инээмсэглэж байлаа. Нэг нь алхимич, өөрийн гаргуун шавиа олсондоо нөгөө нь толгойлогч, тэрхүү шавь нь Бурханы агуу чадлыг ойлгосонд билээ. Дараа өдөр нь толгойлогч хүү болон алхимичийг үдэн гаргаж өгөөд дуртай газартаа хүртэл хамгаалуулаарай хэмээн бараа бологчдыг дагалдуулав.

43 - р хэсэг

Тэд бүтэн өдрийн турш аяллаа. Оройхон тэд нэгэн Коптик сүмд хүрэлцэн очив. Алхимич мориноосоо буугаад дагаж явсан бараа бологчдыг хуаран руугаа буцаж болно гэлээ.

“Эндээс эхлэн чи ганцаараа аялах болно” гэж алхимич хэлээд “Чи Пирамидуудаас ердөө гуравхан цагийн зайтай газар байна.”

“Баярлалаа,” хэмээн хүү хэллээ. “Та надад Дэлхийн хэлийг зааж өглөө.”

“Би ердөө чиний аль хэдийн мэддэг зүйлсийг чинь л сэргээж өгсөн билээ.”

Алхимич сүмийн хаалгыг тогшив. Хар өнгөөр хувцасласан нэгэн хувраг хаалгаар гарч ирлээ. Тэд хэдэн мөчийн турш Коптик аягуугаар ярилцсаны эцэст алхимич хүүг орохыг урив. “Би түүнээс гал тогоогоо түр хэрэглүүлэхийг гуйсан юм,” гээд алхимич инээмсэглэв. Тэд сүмийн хойд хэсэгт байх гал тогооны өрөө рүү явлаа. Алхимич гал түлэн, хувраг түүнд хэсэг тугалга авчирч өгөхөд алхимич богцноосоо нөгөө этгээд шар өндөгөө гаргаж ирлээ. Тэр түүнээс үс мэт нимгэхэн хэсгийг огтлон авч, лааны тосоор ороогоод тугалга хайлж байсан саванд хийлээ. Холимог бараг л цус мэт улаан өнгөтэй болов. Алхимич савыг гал дээрээс авч хөргөхөөр тавилаа. Энэ зуураа тэрээр хуврагтай омгуудын дайны талаар ярилцаж байв.

“Дайн нэлээд сунжрах байх гэж би бодож байна,” хэмээн алхимич хуврагт хэллээ. Хувраг дайнаас залхсан янзтай харагдана. Жингийн цуваанууд Гизад хэсэг хугацаанд саатан дайныг дуусахыг хүлээж байгаа. “Гэвч Бурханы хүсэл биелэгдэх л ёстой,” гэж хувраг хэллээ.

“Яг үнэн,” гэж алхимич хариулав.

Саван дахь зүйл хөрсний дараагаар хувраг болон хүү харсан зүйлдээ гайхан балмагдав. Тугалга савны хэлбэрээр хатсан боловч тугалга байхаа больсон байлаа. Тэр алт болон хувирсан байв.

“Хэзээ нэгэн цагт би үүнийг яаж хийхийг сурах болов уу?” гэж хүү асуулаа.

“Энэ бол чинийх биш миний Хувийн бахархал байсан,” гэж алхимич хариулав. “Гэвч би чамд энэ боломжтой зүйл гэдгийг харуулахыг хүссэн юм.”

Тэд сүмийн хаалга руу буцан явцгаалаа. Тэнд алхимич дугуй алтыг дөрвөн хэсэг болгон хуваав.

“Үүнийг чамд,” гэж алхимич хэлээд нэг хэсгийг нь хуврагт өгөв. “Энэ бол чиний мөргөлчдөд үзүүлсэн өгөөмөр зангий чинь шан.”

“Гэвч энэ шагнал миний өгөөмөр зангаас хэтэрхий давсан байна,” гэж хувраг хариуллаа.

“Ахиж битгий тэгэж хэлж байгаарай. Амьдрал магадгүй сонсчихоод дараагийн удаа чамд багыг өгнө.”

Алхимич хүү рүү хандлаа.

“Энийг чамд. Генералд өгсөн зүйлсийн чинь оронд.” Хүү генералд өгснөөс хавьгүй илүү юм байна гэж хэлэхээ шахав. Гэвч тэр чимээгүй байлаа учир нь алхимич хуврагт юу гэж хэлснийг сонссон билээ.

“Энэ бол надад,” гэж алхимич хэлээд нэг хэсгийг нь авав. “Яагаад гэвэл би дайн болж байгаа газраар явж цөлд буцан очих болно.” Тэр дөрөв дэх хэсгийг хуврагт өглөө.

“Үүнийг хүүд, хэрвээ түүнд хэзээ нэгэн цагт шаардлагатай болвол.”

“Гэхдээ би өөрийнхөө баялгийн төлөө явж байгаа шүү дээ,” гэж хүү хэллээ. “Би одоо маш ойрхон ирээд байна.”

“Тиймээ, би чамайг баялагаа олно гэдэгт итгэлтэй байна,” гэж алхимич хэллээ.

“Тэгээд яагаад үүнийг хийж байгаа юм бэ?”

“Яагаад гэвэл чи өөрийнхөө хураасан хөрөнгөө хоёр удаа алдсан. Нэг удаа хулгайчид, бас нэг удаа генералд. Би бол настай, сүсэг бишрэлтэй араб бөгөөд өөрсдийн зүйр үгнүүдэд итгэдэг. Нэг ийм сургаал үг байдаг юм. ‘Нэг удаа тохиолдсон зүйл хэзээ ч ахин тохиолддоггүй. Гэвч харин хоёр удаа тохиолдсон зүйл гурав дахь удаагаа заавал тохиолддог.’”

Тэд мориндоо мордоцгоолоо.

44 - р хэсэг

“Би чамд зүүдний тухай түүх ярьж өгье,” гэж алхимич хэллээ. Хүү морио ойртууллаа.

“Эртний Ромд, Тибериус хааны үед хоёр хүүтэй нэгэн сайн хүн амьдарч байж гэнэ. Нэг хүү нь цэргийн жанжин бөгөөд эзэнт гүрний хамгийн алс хязгаар руу томилогджээ. Нөгөө хүү нь яруу найрагч агаад бүх л Ром түүний уянгалаг шүлгүүдийг уяран сонсдог байж.”

“Нэгэн шөнө, эцэг нь зүүдэлж гэнэ. Тэнгэр элч түүний өмнө гарч ирээд түүний нэг хүүгийнх нь хэлсэн үг сургаал болон дэлхийгээр түгэн тархаж, хойч үеийнхэн дахин давтсаар байх болно гэж хэлжээ. Тэр зүүднээс сэрээд талархан нулимс дуслуулж, учир нь амьдрал өгөөмөр байж түүнд ямар ч эцэг мэдэхдээ бахархах зүйлийг илчилсэнд баярлажээ.”

“Түүнээс хойш удалгүй, тэр эцэг сүйх тэрэгний дугуйд дайрагдах байсан хүүхдийг аврах гэж байгаад насан өөд болжээ. Тэр бүхий л амьдралаа зөв шударга амьдралаар амьдарсан тул диваажин руу илгээгдэж тэнд зүүдэндээ уулзсан нөгөө тэнгэр элчтэйгээ тааралджээ.”

“‘Чи үргэлж сайн хүн байсан,’ гэж тэнгэр элч түүнд хэлжээ. ‘Чи өөрийн амьдралаа бахархмаар амьдарч, нэр төртэйгээр насан эцэслэсэн байна. Би чиний хүссэн нэгэн хүслийг биелүүлэе.’”

“‘Амьдрал надад сайхан байсан,’ гэж тэр хүн хариулжээ. ‘Та миний зүүдэнд ирэхэд миний зүтгэл шагнагдсан мэт санагдсан учир нь миний хүүгийн шүлгүүд хойч үеийнхэнд уншигдсаар байх болно. Би өөртөө хүсэх зүйл алга. Гэвч ямар ч эцэг жаахан байхад нь хайрлан өсгөж, нас биед хүртэл нь хүмүүжүүлж, сургасан үрийнхээ алдар цуугаар нь бахархах билээ. Алсын ирээдүйн аль нэгтэй, би хүүгийнхээ үгнүүдийг сонсмоор байна.’”

“Тэнгэр элч түүний мөрөнд нь хүрэхэд тэд алсын ирээдүй рүү нисчээ. Тэд мянга мянган хүн хачин хэлээр ярьж байгаа газарт очсон байна. Тэр хүн аз жаргалдаа бялхан уйлж гэнэ.”

“‘Миний хүүгийн шүлгүүд үхэшгүй мөнх гэдгийг би мэдэж байсан,’ гэж тэр тэнгэр элчид хэлжээ. ‘Та аль хүүгийн минь шүлгийг энэ хүмүүс давтан байгааг хэлж өгөөч?’”

“Тэнгэр элч түүнийг ойролцоох вандан сандал руу хүндэгтгэлтэйгээр хөтлөн очоод, сууцгааж.” “‘Таны яруу найрагч хүүгийн шүлгүүд Ромд маш их нэр хүндтэй байсан,’ гэж тэнгэр элч хэлэв. ‘Хүн бүр тэдэнд дуртай байж баясан цэнгэцгээдэг байсан. Гэвч Тибериусын хаанчлалын үе дуусмагц түүний шүлгүүд мартагдсан. Одоо таны сонсож буй эдгээр үгнүүд бол цэргийн албанд зүтгэсэн хүүгийн чинь үг.’”

“Тэрээр, тэнгэр элчийг гайхсан байдалтайгаар харжээ.”

“‘Таны хүү хол хязгаар нутагт алба хаахаар яваад цэргийн жанжин болсон. Тэр шударга, сайн хүн байсан. Нэг өдөр түүний туслах нь өвчин тусан хүндэрч, улмаар удалгүй үхэхэд ойртсон байна. Хүү чинь хүний өвчнийг анагаадаг нэгэн номтой багшийн тухай сонсоод түүнийг олохоор олон хоног явжээ. Тэр замдаа хайж байгаа хүн нь Бурханы хүү болохыг олж мэджээ. Эрлийн явцдаа түүний эмчилсэн бусад хүмүүстэй уулзсан бөгөөд тэд хүүд чинь тэр багшийн сургаалуудыг заасан байна. Тэгээд хэдийгээр тэр Ромын цэргийн жанжин байсан ч гэлээ шүтлэгээ сольсон байна. Удалгүй тэр хайж байсан хүнээ айлчилж байгаа газарт очжээ.’”

“Хүү чинь тэр багшид нэг туслах нь хүндээр өвчилсөн тухай хэлэхэд номт багш хамт явахаар болжээ. Хүү чинь үнэнч итгэлтэй хүн байсан бөгөөд номт багшийн нүд рүү хараад үнэхээр Бурханы хүү болохыг нь мэдсэн байна.

‘Тэгээд энэ бол хүүгийн чинь хэлсэн зүйл,’ гэж тэнгэр элч, тэр хүнд хэлжээ.

‘Эзэн минь, та миний гэрт зочлохоор гавъяатай хүн би биш билээ. Гэвч та зөвхөн үг хэлэхийн төдийд л миний туслах эмчлэгдэх болно’ хэмээн номтой багшид хэлсэн бөгөөд эдгээр үгс нь хэзээ ч мартагдаагүй билээ.”

“Юу хийдэг байлаа ч гэсэн хамаагүй, газар дээрх хүн бүхэн дэлхийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Тэгээд тэд үүнийгээ ер нь бол мэддэггүй юм.” хэмээн алхимич хэллээ.

Хүү инээмсэглэлээ. Тэр хэзээ ч амьдралын тухай асуудлууд нь жирийн хоньчинд тийм чухал байна гэж төсөөлж байсангүй.

“Баяртай,” хэмээн алхимич хэлэв.

“Баяртай,” хэмээн хүү хэллээ.

45 - р хэсэг

Хүү цөлийн дундуур хэдэн цагийн туршид зүрхнийхээ юу хэлэхийг идэвхтэйгээр сонсон аяллаа. Түүний зүрх нь хүүгийн баялаг хаана нуугдаж байгааг хэлэх билээ. “Хаана чиний баялаг байна, тэнд чиний зүрх байна,” гэж алхимич түүнд хэлж байсан.

Гэвч хүүгийн зүрх нь өөр бусад зүйлсийн талаар ярьж байлаа. Тэр сүргээ орхин хоёр дахин зүүдлэсэн зүүднийхээ төлөө тэмцсэн хоньчиний түүхийг бахархалтайгаар ярьж байв. Тэр Хувийн бахархалын тухай, түүнийхээ төлөө алс холын үзэсгэлэнт бүсгүйчүүд бүхий нутаг руу аялж, тухайн цаг үеийнхээ хүмүүсийн бусармаг зүйлстэй тэмцэж байсан олон хүмүүсийн тухай ярьж байв. Тэр аялал, нээлтүүд, ном судар болон өөрчлөлтийн тухай өгүүллээ.

Хүү ахин нэг толгод руу өгсөн байх зуур зүрх нь түүнд “Нулимсаа дуссан газрыг анхаараарай. Тэнд би байгаа гэсэн үг, тэнд мөн чиний баялаг байгаа.” хэмээн шивнэлээ. Хүү толгод руу аажуухан мацав. Бүтэн дугариг сар одот тэнгэрт манджээ. Баянбүрдээс хөдөлснөөс хойш нэг сарын хугацаа өнгөрчээ. Сарны туяа толгодуудыг сүүдэртүүлж, давалгаалан байгаа тэнгис мэт харагдуулах бөгөөд морь нь цоройн, хүү алхимичтэй уулзсан тэр үдшийг эргэн санагдуулав. Тэрхүү сар цөлийн нам гүмд, нэгэн эрийн баялагаа хайх замыг гэрэлтүүлэн байлаа.

Хүү толгодын оройд хүрэхэд түүний зүрх нь огцом догдлов. Тэнд сарны туяа, цөлийн гэгээнд гайхамшигт, агуу Египетийн Пирамидууд харагдаж байлаа. Хүү өвдөг сөхрөн уйллаа. Тэр Бурханд өөрийн Хувийн бахархалдаа итгүүлсэнд нь, түүнийг настай хаантантай, болор эдлэлийн худалдаачинтай, англи эр болон алхимичтэй учруулсанд нь талархаж байлаа. Хамгаас илүүтэйгээр цөлийн бүсгүйтэй, түүнд хайр хэзээ ч эр хүнийг Хувийн бахархалдаа хүрэхэд нь саад болдоггүй гэж хэлсэн бүсгүйтэй учруулсанд талархаж байлаа.

Хэрвээ тэр хүсвэл баянбүрд рүү, Фатима руу буцан очоод эгэл хоньчины амьдралаар амьдарч ч болно. Эцсийн эцэст алхимич хэдийгээр Дэлхийн хэлийг мэдэж, тугалгыг алт болгон хувиргаж чадах ч гэлээ цөлдөө л амьдарсаар байгаа шүү дээ. Тэр өөрийн ухаан болон чадварыг хүн болгонд үзүүлэх шаардлагагүй юм. Хүү Хувийн бахархалаа биелүүлэхийн төлөөх явцдаа шаардагатай бүх зүйлсэд суралцан танин мэдэж, төсөөлж ч байгаагүй зүйлсүүдтэй тохиолдон дадлагажиж авлаа хэмээн өөртөө хэллээ. Гэвч тэрээр өөрийн баялгаа олох цэгтээ байсан бөгөөд тэрээр өөртөө ямар ч ажил зорилгоо биелүүлээгүй цагт дуусдаггүй гэдгийг санууллаа. Хүү эргэн тойрны элсээ тойруулан харахад түүний нулимс дууссан газар нь нэгэн цох элсэн дээгүүр явж байлаа. Цөлөөр аялж байх хугацаанд тэрхүү цох Бурханы тэмдэг хэмээн Египетчүүд үздэгийг тэр мэдсэн билээ.

Бас нэг зөн совин! Хүү толгодын оройг ухаж эхэллээ. Ингэх зуураа тэрээр болор эдлэлийн худалдаачны хэлсэн хэн ч гэсэн хашааныхаа ард пирамид байгуулж болно гэсэн үгийг саналаа. Хүү хэрвээ тэр үлдсэн бүхий л амьдралдаа чулуу зөөн өрсөн ч түүнийг байгуулж чадахааргүй болохыг харж авлаа. Шөнийн туршид хүү сонгосон газраа ухлаа. Түүнд Пирамидууд баригдсанаас хойшхи олон зууны хугацаанд даруулан байх мэт мэдрэмж төрж байв. Гэвч тэр зогссонгүй. Салхи түүнийг ухахад саад болж гаргасан элсийг буцаан нүх рүү оруулж байсан ч гэсэн үргэлжлүүлсээр л байлаа. Түүний гар нь цэврүүтэж, ядарч байсан ч гэсэн тэр зүрхээ чагнасан билээ. Түүний зүрх нь нулимс дууссан газартаа ух гэж хэлсэн.

Тэрээр нэгэн чулууг татан авахаар гаргах зуур хөлийн чимээ сонслоо. Хэдэн сүүдэгнэсэн дүрс түүн рүү ойртон ирж байв. Сар тэдний араас тусч байсан бөгөөд хүү тэдний нүдийг ч, нүүрийг ч олж харсангүй.

“Чи энд юу хийж байгаа юм бэ?” гэж нэг нь шаардлаа. Хүү цочирдсондоо хариу хэлсэнгүй. Тэр баялгаа хаана байгааг олсон тул юу тохиолдож болохоос эмээж байв.

“Бид омгуудын дайнаас дүрвэж яваа хүмүүс байна, бидэнд мөнгө хэрэгтэй,” гэж нөгөө нь хэллээ.

“Чи наанаа юу нууж байна?”

“Би юм нуугаагүй,” гэж хүү хариуллаа. Гэвч тэдний нэг нь хүүг татан нүхнээс гаргав. Нөгөө нь хүүгийн богцыг ухаж хэсэг алт гаргаж ирлээ.

“Энд алт байна,” гэж тэр хэлэв. Сарны туяа хүүг чирэн гаргасан арабын нүүрэн дээр тусахад хүү тэр эрийн нүднээс үхлийг олж харав.

“Түүнд магадгүй илүү их алт газар доор байгаа байх.”

Тэд хүүг үргэлжлүүлэн ухуулсан боловч юу ч олсонгүй. Нар мандах үед тэд хүүг зодож эхлэлээ. Түүний цус нь садарч, хувцас нь салмаран урагдаж, хүү үхэл ойрхон ирж байгааг мэдэрч байв.

“Хэрвээ чи үхэх болвол мөнгө чамд юуных нь сайн байх вэ? Мөнгө үргэлж хүний амийг аварч чаддаггүй юм,” гэж алхимич хэлсэн билээ. Эцэст нь хүү тэдэн рүү хандэн “Би эрдэнэсийг олохоор ухаж байгаа юм,” гэж хашгирлаа. Тэгээд түүний

амнаас нь цус гоожиж, залгигдаж байсан ч гэсэн Египетийн Пирамидуудын ойролцоох нуугдсан баялгийн талаар хоёр дахин зүүдэлсэн тухайгаа ярих.

Тэдний ахлагч нь бололтой нэг нь бусаддаа “Түүнийг орхи. Түүнд өөр юм байхгүй. Тэр энэ алтыг хулгайлснаас гарцаагүй.” хэж хэллээ. Хүү элсэн дээр шурган унаж, ухаан бараг алдах мэт байлаа. Нөгөө ахлагч түүнийг сэгсрэн “Бид явлаа,” гэж хэлэв.

Гэвч тэд явахаас өмнө ахлагч хүүд хандан “Чи үхэхгүй. Чи амьдрана тэгэхдээ чи хүн ийм тэнэг байж болохгүй гэдгийг сурах болно. Хоёр жилийн өмнө яг энэ газарт би мөн хоёр удаа ижил зүүд зүүдэлсэн юм. Би Испанид очин хоньчид хоньтойгоо хоноглодог нурсан сүмийг хайж олох ёстойг зүүдэлсэн. Миний зүүдэнд гол шүтээн байсан газарт нь нэгэн агч мод ургасан харагдсан бөгөөд тэр модны ёроолд ухвал нуугдсан эрдэнэсийг олох болно гэж хэлсэн билээ. Гэвч би зөвхөн давтагдсан зүүдний төлөө бүхэл бүтэн цөлийг гатлах тийм тэнэг хүн биш.” Тэгээд тэд алга болцгоолоо.

Хүү гуйвж дайван босоод Пирамидуудын зүг ахин нэг удаа харлаа. Тэд хүү рүү харан инээх мэт санагдлаа, хүү тэдэн рүү буцаан инээмсэглэв, түүний зүрх нь хөөр баяраар бялхан байлаа. Яагаад вэ гэвэл хүү одоо өөрийнх нь баялаг хаана байгааг мэдэж авлаа.

-***-

Төгсгөл

Хүү шөнө болох үеэр орхигдсон жижиг сүмд хүрэлцэн очив. Нөгөө агч мод гол шүтээний дэргэдээ байх бөгөөд одод мөн л адил хагас нь эвдэрсэн дээврийн завсраар харагдаж байлаа. Тэр энд хоньтойгоо хамтдаа хоноглосон шөнийг эргэн санах, нөгөө зүүднээс бусдаар бол амгалан шөнө байж билээ. Одоо харин тэр сүрэгтэйгээ биш хүртэй ирсэн байлаа. Тэр суугаад тэнгэрийг удаан ширтлээ. Тэгээд тэр үүргэвчнээсээ шилтэй дарс гаргаж ирэн жаахан балгав. Хүү цөлд алхимичтэй хамт суугаад, оддыг ширтэн дарс хамтдаа ууж байсан үеэ эргэн дурслаа. Тэр аялсан олон замуудаа, түүний баялагийг харуулахын тулд Бурханы сонгосон хачирхалтай замын тухай бодож байлаа. Хэрвээ тэр давтагдсан зүүдийг анхааран итгээгүй бол цыган эмэгтэйтэй, хаантантай, хулгайчтай учрахгүй бас... “Тиймдээ, энэ урт жагсаалт болно. Гэвч энэ зам зөн совингоор бичигдсэн, тийм болохоор би төөрч будилах аргагүй байсан,” гэж хүү өөртөө хэлэв.

Тэр нойронд автан, түүнийг сэрэхэд нар аль хэдийн өндөрт хөөрсөн байлаа. Хүү агч модны ёроолд ухааж эхэллээ.

“Хөгшин шидтэн,” гэж хүү тэнгэр рүү хашгирлаа. “Та бүх л түүхийг мэдэж байсан. Та намайг энд буцан ирүүлэхийн тулд сүмд хэсэг алтыг хүртэл үлдээсэн шүү дээ. Нөгөө хувраг намайг салбарсан хувцастай, арай гэж ирэхэд хөхөрч байсан шүү. Та тэгүүлэхээс намайг аварч болоогүй юм гэж үү?”

“Үгүй,” гэж салхи хэлэхийг тэр сонслоо. “Хэрвээ би чамд хэлсэн бол чи Пирамидуудыг харахгүй байх байсан шүү дээ. Тэд үзэсгэлэнтэй байгаа биз дээ, үгүй гэж үү?”

Хүү инээмсэглээд үргэлжлүүлэн ухлаа. Хагас цагийн дараа түүний хүрз нь ямар нэгэн хатуу зүйлд хүрэв. Цагийн дараа тэр өмнөө Испани алтан зоос бүхий авдар гаргасан зогсож байлаа. Тэнд мөн үнэт чулуунууд, улаан цагаан өд бүхий алтан багнууд болон эрдэнийн чулуугаар чимэглэсэн чулуун баримлууд байв. Энэ нутагт болж байсан түрэмгий дайны ул мөр аль хэдийн мартагдаж, хэн нэгэн сурвалжтан үр саддаа энэ баялгийн тухай хэлэхийг мартсан бололтой.

Хүү Урим болон Түмимаа үүргэвчнээсээ гаргаж ирлээ. Хүү энэ хоёр чулууг нэгэн өглөө захын талбай дээр байх үедээ л ганц удаа хэрэглэсэн билээ. Түүний амьдрал түүний замыг хангалттай зөн совингоор үргэлж тэтгэж байсан юм. Тэр Урим болон Түмимаа авдарт хийлээ. Тэд мөн түүний шинэ баялгийн нэг хэсэг бөгөөд учир нь тэд ахиж хэзээ ч уулзахгүй нөгөө настай хаантныг сануулдаг юм.

Энэ үнэн юм, амьдрал өөрсдийн Хувийн бахархалынхаа төлөө тэмцсэн хүнд үнэхээр өгөөмөр ханддаг юм байна гэж хүү бодлоо. Тэгээд тэр Тарифа руу явж амласан ёсоороо баялгийнхаа арав хуваасны нэг хувийг цыган эмэгтэйд аваачиж өгөх ёстойгоо саналаа.

“Энэ цыганууд үнэхээр овжин юм,” гэж хүү бодлоо. Магадгүй тэд их аялдагтаа ийм байдаг ч юм болов уу.

Салхи хөдлөж эхэллээ. Энэ бол левантер буюу Африкаас ирдэг салхи байлаа. Энэ салхи өөртөө цөлийн үнэрийг ч, эсвэл Мүрийнхний халдлагын заналхийллийг ч авчирсангүй. Түүний оронд салхи хүүгийн сайн мэдэх сүрчигний үнэрийг мөн үнсэлтийг – асар холоос илгээгдэж, алгуурхнаар дамжсаар хүүгийн уруул дээр иртэл үргэлжилсэн үнсэлтийг авчирлаа.

Хүү инээмсэглэв. Энэ бол анхны удаа бүсгүй үүнийг илгээсэн нь байлаа.

“Би очиж явна, Фатима,” хэмээн хүү хэллээ.

-*ТӨГСӨВ*-